



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2023 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 10 ДУГААР САРЫН 06-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

НЭГДСЭН ХУРАЛДААН

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр, Баасан гараг

| | |
|--|---------|
| <i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i> | 1 |
| <i>Хуралдааны товч тэмдэглэл:</i> | 2 - 4 |
| <i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i> | 5 - 101 |

| | |
|--|----------|
| 1. <i>Цаг үеийн шинжтэй асуудлаарх мэдээлэл: Хүүхдийн хөгжил, хамгааллын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар</i> | 10 - 71 |
| 2. <i>Ерөнхий сайдын мэдээлэл: “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар</i> | 71 - 101 |

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы
10 дугаар сарын 06-ны өдөр /Баасан гараг/-ийн нэгдсэн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 73 гишүүнээс 41 гишүүн хүрэлцэн ирж, 56.2 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 13 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: С.Амарсайхан, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Г.Ганболд, Л.Мөнхбаатар, Г.Мөнхцэцэг, Б.Саранчимэг, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ, Ж.Чинбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Ганхуяг, Ц.Сэргэлэн, Ж.Эрдэнэбат;

Тасалсан: Ж.Батжаргал, Д.Батлут, Ж.Батсуурь, Б.Бейсен, Х.Болорчулуун, Н.Ганибал, Б.Жавхлан, Н.Наранбаатар, Х.Нямбаатар, Т.Энхтүвшин;

Хоцорсон: С.Батболд – 39 минут, Д.Ганбат – 10 минут, Д.Өнөрболор – 49 минут, Ш.Раднаасэд – 09 минут, Ж.Сүхбаатар – 1 цаг 11 минут, Н.Учрал – 1 цаг 19 минут, Ч.Хүрэлбаатар – 1 цаг 09 минут, Б.Энх-Амгалан – 1 цаг 17 минут, Н.Энхболд – 06 минут,

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Пүрэвдорж, С.Одонтуяа нараас ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьяа, Б.Пүрэвдорж нар үг хэлэв.

Нэг.Цаг үеийн шинжтэй асуудлаарх мэдээлэл: Хүүхдийн хөгжил, хамгааллын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Улсын Их Хурлын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Соёлын дэд сайд М.Батбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд С.Зулпхар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Э.Ганхүү, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Л.Нямгэрэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Н.Өлзийхутаг, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, бригадын генерал Х.Лхагвасүрэн, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч М.Чинбат, Улсын Ерөнхий Прокурорын газрын орлогч прокурор Ж.Ариунаа, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Г.Мөнхбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Г.Арсланхуяг, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч З.Төмөртөмөө, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ч.Чинбат, Тээврийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх хэлтсийн

ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Г.Отгонтамир, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Ч.Бадамханд, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хууль, эрх зүйн газрын дарга Н.Мягмар, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн референт Г.Нямсүрэн, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, мөн хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа “Хүүхдийн хөгжил, хамгааллын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ”-ний талаар мэдээлэл хийв.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Б.Бат-Эрдэнэ, С.Одонтуяа, Д.Сарангэрэл, Ц.Мөнхцэцэг, Д.Тогтохсүрэн, Д.Ганбат, Т.Доржханд, Ц.Сандаг-Очир, Б.Жаргалмаа, Б.Баярсайхан, С.Ганбаатар, П.Анужин, Д.Өнөрболор, М.Оюунчимэг нарын тавьсан асуултад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Ж.Хунан, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Н.Баярмаа, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Г.Мөнхбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар “Хүүхдийн хөгжил, хамгааллын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээ”-ний талаарх мэдээллийг сонслоо.

Үдээс өмнөх хуралдаан 3 цаг 09 минут үргэлжилж, 13 цаг 22 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 05 минутад эхлэв.

Хоёр.Ерөнхий сайдын мэдээлэл: “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн дэд сайд Л.Халтар, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Ц.Одхүү, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, Авто тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Э.Мөнхнасан, Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга Ц.Эрдэнэ-Очир, Судалгаа, статистикийн хэлтсийн дарга Ц.Мядагмаа, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Замын дарга Х.Хэрлэн, “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхтамир, Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга Ч.Мөнхтуяа, “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Гүрсоронзон, “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Отгонсүх, “Таван толгой төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Н.Будбаяр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Үнэнбат, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн

даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо, мөн хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, зөвлөх Ж.Монголжингоо нар байлцав.

Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэл хийв.

Зам, тээврийн хөгжлийн сайдын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл үг хэлэв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 14 цаг 28 минутаас хуралдааныг даргалав.

Мэдээлэлтэй холбогдуулан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.6-д заасны дагуу цөөнхийн төлөөллөөс Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа, О.Цогтгэрэл, Б.Пүрэвдорж, Д.Ганбат нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Д.Эрдэнэбат, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Замын дарга Х.Хэрлэн, “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Мөнхтамир нар хариулж, тайлбар хийв.

Чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэл хийлээ.

Уг асуудлыг 15 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Бусад. Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл доор зохион байгуулагдаж байгаа “Шинэ сэргэлт-Мал аж ахуй” үндэсний чуулганд Баян-Өлгий, Баянхонгор, Ховд, Дорноговь аймгаас оролцож буй залуу малчид, Нийслэлийн 9, 107 дугаар цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцав.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч Ш.Мөнхцож, С.Энхзаяа нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 36 минут үргэлжилж, 73 гишүүнээс 47 гишүүн хүрэлцэн ирж, 64.4 хувийн ирцтэйгээр 15 цаг 32 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 10 дугаар сарын 06-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
10 цаг 16 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Хуралдаан нээснийг мэдэгдье. Өнөөдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаар Хүүхэд хамгааллын асуудлаарх мэдээлэл сонсохоор өчигдөр чуулган дээр Та бүхэнд мэдэгдсэний дагуу зохион байгуулж байна.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар **“Шинэ сэргэлтийн бодлого”**-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсоно. Засгийн газрын мэдээлэл сонсоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13.4-т заасны дагуу гишүүн энэ хуулийн 9.5-д заасан нэгдсэн хуралдааны хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн Бөхчулууны Пүрэвдорж, Ширнэнбаньдийн Адьшаа, Салдангийн Одонтуяа нараас тус тус албан бичгүүд ирүүлсэн байна.

Ингээд үг хэлье. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн үг хэлнэ. Бөхчулууны Пүрэвдорж гишүүн хэлэлцэх асуудлын

дараалалтай холбоотойгоор үг хэлэх зөвшөөрөл олгоё гэсэн байна. Б.Пүрэвдорж гишүүн.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр хүүхэд хамгааллын асуудал зөвхөн эмэгтэй гишүүдийн асуудал биш юм.

Ер нь сошиалаар эмэгтэйчүүдийг энэ асуудлаар ярьсангүй гэж ярьж байгаа нь бас өрөөсгөл. Яагаад гэвэл эмэгтэйчүүд хүүхэд хамгааллын асуудлаар хууль өргөн барьчихсан байж байгаа. Засгийн газраас хууль орж ирнэ гэдэг үндэслэлээр энэ асуудал түр зуур хойшлоод байж байгаа.

Тэгэхээр эрэгтэй гишүүд ч гэсэн энэ талаар анхаарал тавьдаг. Их Хурлын дарга ч хүртэл санаачилга гаргаад хүүхэд хамгааллын асуудлаар өнөөдөр бүх албан тушаалтнуудыг оролцуулсан хэлэлцүүлгийг зохион байгуулах гээд ажиллаж байна.

Тэгэхээр хэлэлцэх асуудалтай холбоотой бас нэг асуудал байгаа.

Тэгэхээр тун удахгүй улсын төсөв хэлэлцэж эхэлнэ. Энэ төсөв дээр нэг асуудал дутуу үлдсэн байгаа.

Х.Булгантуяа сайд сайн санаж байгаа бол Монгол төрийн буруу бодлогоос болж 2018-2023 оныг дуустал нэг хэсэг зурвас хугацаанд 7 жилээр тэтгэврээ бодуулсан тэр иргэд хохирч үлдэж байгаа.

Нийтдээ 58 мянган иргэн 93 тэрбум төгрөгийн нөхөн олговор авах ёстой байтал энэ олговор энэ оны улсын төсөв дээр тусгагдаж орж ирээгүй байна.

Тэгээд би хэд хэдэн албан тушаалтантай уулзсан боловч энэ нөхөн олговрыг олгох тухай асуудал огт байхгүй, чадахгүй гэдэг ийм зүйлийг ярьж байна.

Тийм учраас зохион байгуулалтад орж тэмцэхээс өөр аргагүй болж байна. Ийм учраас би энэ 58 мянган иргэндээ хандаж уриалга гаргаж байна. Нийслэл, аймаг болгонд нэг нэг толгойлогчтой, тэгээд сум болгонд нэг хүн томилоод, дүүрэг болгонд хүн томилоод, хороо болгонд хүн томилж байгаад тэр 58 мянган иргэний бүгдийнх нь гарын үсгийг цуглуулж хүргүүлэх зайлшгүй шаардлага байна.

Би хэд хэдэн аймгаар явж уулзалт хийсэн. Тэр дээрээ яг энэ асуудлаар зайлшгүй төсөвт суулгах асуудлыг шийдэж өгөөрэй гэдэг үүргийг надад өгч байсан. Тэгээд хэд хэдэн аймаг дээр энэ мөнгө бараг өнөөдрийн эрх баригч нар тусгахгүй байх гэдэг зүйлийг хэлэхэд тэр хүмүүс аймагтаа бид зохион байгуулаад гарын үсгийг цуглуулж энэ тэмцлийг өрнүүлэх ийм ажлыг хийж чадна гэж хэлж байсан.

Тийм учраас би өнөөдрөөс эхлээд тодорхой зохион байгуулалтад орж, энэ 58 мянган иргэний гарын үсгийг цуглуулж, яаралтай 10, 20 хоногийн дараагаас 2024 оны төсвийг батлах ёстой. Нийгмийн даатгалын сангийн төсвийг батлах ёстой. Энэ төсөвтөө оруулж авах нь хамгийн чухал асуудал байгаа.

Тийм учраас идэвхтэй байгаа хүмүүс, ялангуяа тэр 7 жил биш 5 жилээр тэтгэврээ тогтоох тэр групп рүү хандаж яг энэ ажлыг хариуцаж хариуцлагатай хийх тэр хүмүүс холбоо тогтоогоорой гэж хүсэж байна. Зохион байгуулалтыг жич явуулна.

Г.Занданшатар: Одоо Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн.

Ш.Адьяа: Өнөөдөр хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн тухай асуудал Улсын Их Хурлын удирдлагын хэмжээнд нийгэмд маш том асуудал үүсгэж энэ асуудлыг төр ярилцаж шийдвэр гаргах ийм зайлшгүй шаардлага үүссэн байгаа.

Улсын Их Хурлын даргын зүгээс Улсын Их Хурлын чуулган дээр удаа дараа хүүхэд хамгааллын асуудлаар тодорхой байр сууриа илэрхийлдэг.

Түүнээс гадна өнөөдөр Улсын Их Хурлын түвшинд, төрийн эрх барих дээд байгууллагын түвшинд энэ хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа нь сайн үр дүнгүй гэж харж байна.

Тэгэхдээ энэ асуудал дээр хэлэлцүүлэг биш Улсын Их Хурал зайлшгүй шийдвэр гаргах ёстой гэж харж байгаа.

Өнөөдөр сүүлийн 3 жилийн хугацааны статистик судалгаагаар Монгол Улсын хэмжээнд нийт 6007 гэмт хэрэг насанд хүрээгүй хүмүүсийн эсрэг үйлдэгдсэн байгаа.

Үүний улмаас 992 хүүхэд нас барж, 2537 хүүхэд гэмтсэн байна. Энэ хүүхдийн 1547 буюу 25.5 хувь нь бэлгийн хүчирхийллийн гэмт хэрэгт өртсөн. 1181 буюу 76.3 хувь нь хүчиндэх гэмт хэрэгт ингэж өртсөн байна.

Энэ асуудлыг өнөөдөр бид Монголын төрийн хэмжээнд авч шийдэх шаардлагатай байгаа.

Энд би аав хүний хувьд, хууль тогтоогчийн хувьд дараах саналыг

өнөөдөр энэ чуулганд оруулж байна. Энэ шийдэх ёстой асуудал.

Хүүхдийн эсрэг болон хүүхдийн үйлд үйлдсэн гэмт хэргийн энэ асуудал Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн асуудал болж байна. Үндэсний аюулгүй байдлын асуудал болж байгаа шүү.

Тийм учраас энэ гэмт хэргийн ял шийтгэл, бусад нөхцөл байдлын тухай Улсын Их Хурал хойшлуулшгүй горимоор одоо бид энэ хуулийн төслийг өргөн барих, шийдвэр гаргах ийм ажлын хэсгийг яаралтай Улсын Их Хурлын дарга байгуулж, яаралтай горимоор үүнийг шийдэж гаргах ийм саналыг оруулж байна.

Бид олон хууль тогтоомжийг яаралтай горимоор оруулж байсан. Авлигын эсрэг хууль гээд л.

Ийм учраас яаралтай горимоор оруулж энэ асуудлыг шийдэх нь бид үндэсний аюулгүй байдлын асуудал. Хүүхдийн асуудал дээр бид Улсын Их Хурал тодорхой шийдвэр гаргах ёстой гэдэг энэ үүргээ биелүүлэх шаардлагатай байгаа юм.

Мөн одоо ингээд улсын төсөв бид хэлэлцэж байна. Улсын төсөв дээр бас хүүхдийн эсрэг гэмт хэргтэй тэмцэх төсөв хөрөнгийн асуудал ямар ч байдлаар тодорхой харагдахгүй байна.

Тийм учраас хүүхдийн гэмт хэргтэй тэмцэх, хүүхэд хамгааллын асуудлаар Засгийн газарт чиглэл өгч, тодорхой нэгж байгуулж энэ дээр тодорхой шийдвэрийг Улсын Их Хурлаас гаргах зайлшгүй шаардлагатай байна гэж үзэж байна.

Цахим гэмт хэрэг, цахим орчинд өнөөдөр хүүхдийн хүмүүжил, ёс зүйн

асуудал, гэмт хэргийн асуудал энд зайлшгүй шийдэх ёстой асуудал байгаа.

Сургуулийн орчинд ухаалаг гар утсыг яах юм, цахим техник хэрэгслийг яах юм гэдэг асуудлыг хуулиар зайлшгүй шийдэх асуудал байгаа учраас мөн энэ асуудлыг хойшлуулшгүй горимоор орж шийдвэрлүүлэх саналыг Улсын Их Хурлын гишүүний хувьд би оруулж байна.

Энэ асуудлыг зайлшгүй, яаравчилсан, хурдавчилсан горимоор оруулж шийдэж бид өнөөдөр Монголын ирээдүй болсон хүүхдийнхээ асуудлыг хамгаалах, тэдний эрхийг хамгаалах, гэмт хэрэгт өртөхөөс хамгаалахаас гадна гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийн асуудлыг яах юм. Олон хүүхэд гэмт хэрэг үйлдэж байна. Энэ асуудал сургуулийн орчинд байна. Гэр бүлийн орчинд байна. Гэр бүлийн хүчирхийллийн орчинд байна. Энэ асуудлыг бид яаралтай шийдэж, яаралтай горимоор л энэ асуудлыг оруулж шийдвэрлэх саналыг би оруулж байна.

Г.Занданшатар: Улсын Их Хурлын гишүүн Салдангийн Одонтуяа Хүүхэд хамгааллын хуулийн хэрэгжилтийн асуудлаар хэлэлцүүлэг зохион байгуулах саналтай байсан бөгөөд энэ санал нь хангагдсан. Өнөөдрийн хэлэлцүүлэг зохион байгуулагдаж байгаа учраас үг хэлэхээс нэрээ татлаа.

Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. Ажлын хэсгийн гишүүдийг оруулаарай.

Ер нь Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хүүхэд хамгааллын тухай, Хүүхдийн эрхийн тухай хуулийн хэрэгжилт, хүүхдийн эрхийн зөрчил, аюулгүй байдлын асуудлаар мэдээлэл сонсох гэж байна.

Ер нь сая Ш.Адъяа гишүүн ярьж байна. Энэ хууль эрх зүйн орчныг сайжруулья гэж.

Ер нь хүүхдийн эрхийг баталгаажуулсан эрх зүйн орчныг бүрдүүлэх, хүүхэд хамгааллын бүтэц, тогтолцоо бүрдүүлэгч чиглэлээр баталсан хууль тогтоомж цөөнгүй байна. Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулиуд байгаа. Тэгэхдээ хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Ер нь хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр зарим шинэчлэлүүд хийх шаардлагатай байгаа.

Ер нь гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтад хүүхдүүд өртөж, эрх нь зөрчигдөх явдал даамжрах хандлагатай байна.

Гэр бүл сургуулийнхаа орчинд хүртэл хүүхдийн аюулгүй байдлын баталгаа алдагдаж байна. Тэгээд хүүхдийн эрх хамгааллын хуулиудын эрх зүйн шинэтгэлийн гол концепц нь төрийн бүх шатын байгууллага, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид, төрийн бүх байгууллагууд дээр нь тодорхой үүрэг оролцоотой байж хамтран ажиллах тогтолцоог бүрдүүлэхэд чиглэгдсэн.

Харамсалтай нь энэ бүрдүүлж бий болгосон эрх зүйн орчин хүүхдийн эрх хамгааллын тогтолцоо, үүргээ хангалттай гүйцэтгэж чадахгүй байна гэдэг нь өнөөдрийн нөхцөл байдлаар улам бүр ил болж байна.

Ийм учраас л хүүхдийн амьд явах, хөгжих, оролцох, хамгаалуулах эрх байнга зөрчигдөж байна. Хүүхдийн эрсдэлт орчин бий болсон байна. Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан. Эрсдэлт орчны үнэлгээг жил болгон хийж байх

ёстой байгууллагууд нь ажилладаг юм уу, үгүй юм уу.

Хүүхэд мэндэлсэн цагаасаа насанд хүртлээ, 18 нас хүртлээ эцэг, эх, сурган хүмүүжүүлэгчид, төрийн байгууллагуудын халамж анхааралд байх хэрэгтэй гээд заачихсан. Хүүхдүүд аюулгүй, амгалан тайван, тохитой ээлтэй орчинд өсөж бойжиж, стандарт шаардлага хангасан сургууль, цэцэрлэг, орчинд сурч хөгжиж хүмүүжих ёстой.

Тэгэхээр хууль тогтоомж холбогдох дүрэм журмаар хүлээсэн байгууллага, албан тушаалтан, хүмүүс энэ үүргээ сайн биелүүлж чадахгүй байна уу, эсвэл бидний бий болгосон хууль тогтолцоо, эрх зүйн орчин оновчтой биш байна уу.

Ингээд сүүлийн хоёр, гурван хоногийн хугацаанд D-Parliament-аар болон Улсын Их Хурлын даргын нэр дээр олон санал санаачилгууд ирсэн. Согтуу жолоочдоо дайн зарлаач ээ. Хууль эрх зүйн орчныг чангалаач ээ.

Ер нь хутга, зэвсэг бариад явж байгаа согтуу хүнтэй ялгаагүй шүү дээ. Энэ согтуу жолооч гэдэг чинь.

Энэ барилгын стандартаа шинэчилж, цонхуудын наалт, хаалт. Хуучин стандартын цонх чинь шинэ стандартын цонх, энэ вакум цонхууд чинь онгойгоод хүүхдүүд унаад байна. Энэ дээр хаалттай байх стандартын шаардлага Барилга, хот байгуулалтын яам стандартыг бий болгооч. Барилгын цонх, тагт, хаалтын стандартыг харж хүүхдэд ээлтэй аюулгүй стандарт бий болгож гаргаж мөрдүүлэх хэрэгтэй байна.

Тэр барилгын орчин тойрны хүүхдийн орчнуудыг, хүүхдийн тоглоомын талбайнуудыг бүгдийг нь

барилга байшин болгоод. Өчигдөр Ерөнхий сайдын хэлдэгээр бетонон ширэнгэ болгоод байдаг. Энэ дээр стандартаа Барилга, хот байгуулалтын яам шинэчлээч.

Ер нь нийслэл хот болон аймаг, дүүргүүдийн гудамж, талбайн гэрэлтүүлэг, камержуулалт, иргэд, хүүхдийн аюулгүй байдлыг хангахуйц түвшинд хийх хэрэгтэй байна.

Тийм учраас энэ бүх асуудлуудыг нэг цогцоор нь харж шийдлүүд гаргаж авахгүй бол өчигдөр ярих ёстой байсан, өнөөдөр ярих ёстой байсан, маргааш ярих ёсгүй байсан гэж мэтгэлцэж суудаг цаг биш. Харанга дэлдэж байхад чинь.

Аль эсвэл эрэгтэйчүүдийн, эмэгтэйчүүдийн асуудал, тэр байгууллагын асуудал, энэ байгууллагын асуудал гэсэн бие бие рүүгээ чихсэн юм ч байж таарахгүй. Ерөөсөө л хүүхэд эндээд байхад бүгдээрээ л хамтарч ажиллаад л, асуудлаа тодорхойлоод л урьдчилан сэргийлэх, хамгаалах ажлаа шинэ шатад гаргах хэрэгтэй.

Ийм учраас өнөөдөр энэ хэлэлцүүлгийг зохион байгуулж байна.

Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн асуудал зөвхөн нэг байгууллага, нэг салбарын хийх ажил биш. Салбар хоорондын ажлын уялдаа холбоо, ажиллагаа чухал байна.

Боловсролын салбарт багш, нийгмийн ажилтнууд, сэтгэл зүйч, захирал Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан тодорхой үүргүүдтэй байгаа. Үүнээс гадна сургуулийн автобусны хүрэлцээг сайжруулах, сургалтын хөтөлбөрт гэр бүл, хүүхэд хамгааллын талаар мэдлэг олгох агуулгыг багтаах шаардлагатай.

Хүүхэд залуучууд, багаас нь өөрийгөө болон үе тэнгийнхнээ хамгаалах арга мэдлэгийг олгох ёстой.

Ийм учраас хүүхдийн тоглох талбай, чөлөөт цагаа өнгөрөөх, хамгаалагдсан орчин, аюулгүй алхах орон зайг бий болгох хэрэгтэй. Үндсэндээ алга болсон байна. Үүнийг засаж сайжруулахад төрийн байгууллагууд анхаарах хэрэгтэй байна.

Ингээд иргэдээс маш олон асуудал ирсэн. Хүүхдийн эрхийн тухай хуулийн шинэчлэл нь хүүхдийн эрхийг хамгаалахад төрийн бүх шатын байгууллагын үүрэг, оролцоо, хамтын ажиллагаа болон хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн үүргийг хуулиар тогтоосон байна. Энэ хуулийг хэрэгжүүлэхэд ямар саад бэрхшээл байна вэ?

Хүүхэд хамгаалал, харах үйлчилгээний зардалд 1 тэрбум 510 сая төгрөг зарцуулахаар сайдын багцад батлуулсан.

Эдгээр хөрөнгийг үр ашигтай зарцуулахад хэрхэн ажиллаж, ямар үр дүн гарсан бэ? Өчигдрийн Улсын Их Хурлын нэгдсэн чуулган дээр онцлоод яригдаад байсан хүүхдийн эрх зөрчигдсөн асуудлуудад хүүхдийн эрхийн төлөө ажилладаг байгууллагууд ямар арга хэмжээ авсан бэ?

Хүүхдийн тусламжийн 108 утсанд дуудлага, мэдээлэл ирэх нь эрс өссөн байна. Энэ дуудлага өгөөд байхад шийдвэрлэх асуудал хангалттай байгаа юу. Энэ тал дээр ямар процессоор ажиллаж, хэдэн хүүхдийг хамгаалсан бэ гэх мэтчилэн ийм арваад асуултууд ирсэн байна.

Энэ дээр манай холбогдох байгууллагууд хариултаа бэлтгэж байгаарай.

Ингээд ажлын хэсэг орж ирсэн учраас чуулганыхаа хуралдааныг, хэлэлцэх асуудалдаа ингээд орж байна.

Нэг.Цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээлэл:

Хүүхдийн хөгжил, хамгааллын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар

Одоо цаг үеийн шинжтэй асуудлаар, Хүүхэд хамгааллын асуудлаар, Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн асуудлаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа мэдээлэл хийнэ. Индэрт урьж байна.

Х.Булгантуяа: Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын хүүхэд, өсвөр үеийнхний эрхийг хамгаалах, тэдний хөгжил, оролцоог дэмжих чиглэлээр хэрэгжүүлж байгаа бодлого, үйл ажиллагаа, цаашдын зорилтын талаар Та бүхэнд мэдээлэл танилцуулж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2016 онд Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг баталж, хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, хүүхдийг тусгай хамгаалалтаар хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод “Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшлийг дэмжихэд эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ”, Монгол Улсын Засгийн

газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн нийгмийн бүх бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.” гэж бид дунд, урт хугацааны хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах, хүүхдийн эрхийг хангах чиглэлээр бодлогоо тодорхойлсон байгаа.

Монгол Улсын хүн ам **3.5** сая болж, өмнөх оноос **1.4** хувиар өсөж, нийт хүн амд 18 хүртэл насны хүүхдийн эзлэх хувь **36.2** хувь буюу **1.3** сая хүүхэд байна.

Монгол Улсад 2022 оны байдлаар **941.5** мянган өрх бүртгэгдэж, өмнөх онтой харьцуулахад **2.3** хувиар өссөн байна.

Улсын хэмжээнд 2022 оны байдлаар 65 мянга 90 эх амаржиж, 67 мянга 874 хүүхэд төрүүлсэн нь өмнөх оноос амаржсан эх 8.5 хувиар, төрсөн хүүхэд 8.1 хувиар тус тус буурсан байна.

Улсын хэмжээнд 2022-2023 оны хичээлийн жилд **1413 цэцэрлэгт 266 мянга 24 хүүхэд, төрийн болон хувийн өмчийн 859 ерөнхий боловсролын сургуульд 746 мянга 405** хүүхэд суралцаж байна.

Бүтэн өнчин 2911, хагас өнчин 36 мянга 363, үрчлэгдсэн 1478 хүүхэд байна.

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай өрхөд амьдарч байгаа 460 мянга 344 хүүхэд буюу нийт хүүхдийн 35.4 хувь байна.

Хүнсний эрхийн бичигт 76 мянга 63 хүүхэд, хүүхдийн мөнгөн тэтгэмж бүх хүүхдэд олгож байна.

Өнгөрсөн хугацаанд хууль эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд гарсан ахиц дэвшил цөөнгүй байна.

Салбар бүр хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр анхаарч ажиллах шинэ хандлага, хамтын ажиллагаа бий болсныг энд дурдах нь зүйтэй.

Хүүхэд, гэр бүлийн салбарт мөрдөгдөх 50 гаруй дүрэм, журам, стандартыг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг үе шаттайгаар нэмэгдүүлсэн.

2016 онд хууль дөнгөж батлагдаж, хүүхдийн эрхийг хамгаалах тусгайлан агентлагтай болсны дараагаар анх 356.0 сая төгрөгийн төсөвтэйгөөр эхлүүлж байсан энэ хүүхэд хамгааллын үйлчилгээ өнөөдөр 8 тэрбум төгрөгийн төсөвтэй, 21 аймаг, 9 дүүрэгт салбартай бүтэц болж ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн үйл ажиллагааг өргөжүүлж, төрийн үйлчилгээний бүтэц болгож, программын гуравдугаар шатын шинэчлэлийг хийж, утас, чат, мессежээр дуудлага, мэдээлэл хүлээн авч байна.

2017 оноос хүчирхийллийн хохирогчид аюулгүй байдлын хамгаалалд хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх нэгжийг 5 дахин нэмэгдүүлж, 20 түр хамгаалах байр, 15 нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж байна.

Улсын хэмжээнд 737 хамтарсан багт нийтдээ 608 гишүүн ажиллаж байна.

Хүүхдийн эрхийн хууль зүйн хороог шинэчлэн байгуулж, 30 хорооны 514 гишүүн холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүүхэд, гэр бүлийн салбарт хүүхдийн эрхийн зөрчлийг шалган шийдвэрлэх эрх бүхий улсын байцаагчийг бэлтгэж, 36 албан хаагч давхар чиг үүрэгтэй ажиллаж байна.

Хүүхдийн эрх хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагыг магадлан итгэмжилж, 2018 оноос хүүхэд хамгааллын үйлчилгээг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлж эхэлсэн.

2018 он 42, 2019 онд 20, 2020 онд 8, 2021 онд 35, 2022 онд 18 төрийн бус байгууллага хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх магадлан итгэмжлэл авсан байна.

21 аймаг, 9 дүүргийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтсүүд магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллагуудтай 2021 онд 782.5 сая төгрөг, 2022 онд 822.4 сая төгрөгийн гэрээ байгуулж хүүхэд хамгааллын үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлсэн болно.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний шинэчлэлийг хийж тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч тулгамдсан зарим асуудлууд байсаар байна.

Нийгэмд гарч байгаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн 70 гаруй хувь нь гэр бүлийн орчинд эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс үйлдэгдсэн гэмт хэргүүд байна.

Хүүхдийн тусламжийн утас нь 2022 онд 117 мянган дуудлага мэдээлэл, 2023 оны 9 сарын байдлаар 78 мянга 310 дуудлага мэдээлэл хүлээн авсан.

2023 оны 9 сарын байдлаарх хүүхэд хамгааллын 10 мянга 966 дуудлагын шийдвэрлэлт 61.5 хувьтай байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны зорилтот дуудлага 67 хувьд хүрч, иргэд, олон нийт хүүхдэд үйлчилгээ үзүүлдэг мэргэжилтэн, ажилтнууд, айл хөрш хүүхдийн зүгээс хүүхдийн эрхийн зөрчлийг мэдээлэх, зөвлөгөө авах төрлийн дуудлага сүүлийн жилүүдэд өсөж байгаа нь Хүүхэд хамгааллын тухай хууль 108 утсыг иргэд, олон нийт мэддэг болсны бас нэг илэрхийлэл юм.

Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвөөс орон нутгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, хэлтэс сум, хорооны хамтарсан багт шилжүүлсэн кэйс шийдвэрлэлт 2021 онд 65.5 хувь, 2022 онд 79 хувь, 2023 оны 9 дүгээр сарын байдлаар 61.5 хувьтай байгаа нь өмнөх онуудтай харьцуулахад 36 орчим хувиар өссөн байгаа.

Тэгэхдээ үүнийг нэмж сайжруулах хэрэгцээ шаардлага бидэнд байна. Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвөөр 2018-2023 онд 19 мянга 231 хүн үйлчлүүлсний 67.7 хувь нь хүүхэд, 32.3 хувийг насанд хүрэгчид эзэлж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын мэдээллээр 2022 онд

эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа 14 мянга 207 хүүхэд, 2023 онд 8081 хүүхдийг илрүүлж хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлсэн болно.

Цагдаагийн ерөнхий газраас 2023 оны 8 дугаар сарын статистик мэдээллээр насанд хүрээгүй хүнээс үйлдэгдсэн гэмт хэрэг 756, гэмт хэрэгт 932 хүүхэд холбогдон шалгагдаж байна.

Цахим орчин дахь хүүхэд хамгааллыг сайжруулах хэрэгцээ шаардлага бидэнд байна.

Цахим орчны хүүхэд хамгааллын асуудал салбар бүр анхаарч ажиллах шаардлагатай байна. Харилцаа, холбооны зохицуулах хорооны 2022 оны тайланд хүн амын 99.7 хувь нь гар утасны хэрэглэгч, интернэт ашиглалт 61 хувь, сошиал медиа хэрэглэгч 78.7 хувь, кибер аюулгүй байдлын индекс 46.5 хувьтай байна гэж заасан байна.

ITU /The International Telecommunication Union/, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан зөвлөмжид хүүхдийн өдөрт интернэт зарцуулах хугацааг 120 минутаас ихгүй байлгахыг зөвлөдөг. Гэвч 13-аас 18 насны хүүхдийн нийгмийн сүлжээ ашиглахад зарцуулж байгаа дундаж цаг 231 минут байна.

Ялангуяа эцэг, эхчүүд хүүхдээ саатуулах зорилгоор гар утас өгч хэрэглүүлдэг бөгөөд энэ нь интернэт сошиал медиа эрт хэрэглэж эхлэх суурь шалтгаан болж, зүй бус мэдээ, мэдээллийг авах боломжийг бүрдүүлж байгаад анхаарах хэрэгцээ шаардлага байна.

Харилцаа, холбооны зохицуулах хорооноос **www.ekids.mn** веб сайтыг ажиллуулж олон нийт, хүүхэд,

залуучуудад зориулан цахим орчны ёс зүйтэй хэрэглээ, цахим орчинд хэрхэн аюулгүй оролцох талаарх 135 видео шторк, 275 постер, 251 нийтлэл мэдээллийг байршуулсан байгааг эцэг, эхчүүд та бүхэн хандаарай.

Харилцаа, холбооны зохицуулах хорооны <http://black-list.mn> DNS системийн бүртгэлээр 2023 онд нийтдээ 635 домэйн нэрээр хандалтыг хязгаарласан байна.

Government case work channel фэйсбүүк компанитай хамтран Засгийн газартай хамтран ажиллах сувгийн буюу ногоон сувгийг байгуулан ажиллаж байгаа.

2023 онд 477 контентыг зүй бус контент хэмээн устгуулсан байна.

Цахим орчны зохисгүй, хүүхдэд сөрөг нөлөөтэй болон хууль зөрчсөн байж болох контенттой холбоотой гомдлыг хүлээн авч холбогдох эрх бүхий байгууллагад шилжүүлж хууль зөрчсөн эсэхийг тогтоогдсон нөхцөлд шийдвэрийн дагуу тухайн контентыг устгах, хязгаарлах талаар арга хэмжээг авах зэрэг үйл ажиллагааг зохион байгуулах, <http://report.crc.gov.mn> системийг 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрөөс нэвтрүүлэн ажиллуулж, тус системд хүн, хуулийн этгээдээс 131 хүсэлт бүртгэгдсэн байна.

Гэхдээ бүртгэгдсэн кэйсийг шийдвэрлэх цаг хугацаа удаашралтай. Ялангуяа манай фэйсбүүкийн салбар Монгол Улсад байдаггүйгээс үүдэн ялангуяа өвгөн хаалттай холбоотойгоор мэдээ мэдээллийг устгуулахад цаг хугацаа алдаж хүүхдүүд, насанд хүрсэн хүмүүс ч гэсэндээ зүй бус, хууль бус мэдээ мэдээлэл хүлээн авахад энэ боломж

бололцоо бүрдсэн байгаад анхаарах шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил хамгаалал, асрамж дэмжлэг, ээлтэй орчин бүрдүүлэх асуудлыг хойш тавилгүй шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

Улсын хэмжээнд байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй 11 мянга 818 хүүхэд байна.

Монгол улсын хэмжээнд 21 байгууллагын 30 асрамж, халамжийн төв үйлчилгээ үзүүлж, 18 хүртэлх насны 974 хүүхэд, 19-өөс 21 насны 86 залуу үйлчилгээ авч байна.

Нийт хүүхдийн 8.1 хувь нь буюу 86 хүүхэд хөгжлийн бэрхшээлтэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах хөгжлийн төвд төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд 130 хүүхэд, хүүхдийн төв сувилалд хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүн 19-өөс 34 насны хүн өнөөг хүртэл хүүхдүүдтэй хамт амьдрах тохиолдол байна.

Боловсрол, шинжлэх ухааны яамны мэдээллээр 2022-2023 оны хичээлийн жилд хөгжлийн бэрхшээлтэй 7171 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдан сурч байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийг бид 5 аймагт барьж, сая энэ 9 дүгээр сард нээлтийг хийлээ.

Одоо 3 аймаг, нийслэл Улаанбаатар хотод шинээр байгуулахаар төсвийг шийдвэрлэн ажлыг эхлүүлээд байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн шинэчилсэн

найруулгын тухай хуулийн төслийг бид боловсруулаад байна.

Мөн энэ намар бид Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлын тухай хуулийг Улсын Их Хуралд өргөн барихаар бэлдээд байгаа.

Хүүхдийн хөгжил оролцоог дэмжсэн орчин бүрдүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх мөн шаардлагатай байна.

Хүүхдийн хөгжлийн үйлчилгээний хүртээмж бага, 5-аас 18 насны нийт хүүхдийн 12 хувь нь л хөгжлийн үйлчилгээнд хамрагдаж байна.

Улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн дэргэд 532 дотуур байранд 35 мянга 77 хүүхэд амьдарч байгаа.

Ерөнхий боловсролын сургуульд дотроо спорт заалгүй 201 сургууль, урлагийн заалгүй 446 сургууль байна.

Орон нутгийн дотуур байрны ариун цэврийн асуудлыг шийдвэрлэхээр Улсын Их Хурлын гишүүд санаачлан төсвийн санхүүжилтийг шийдсэн нь өнөөдөр хэрэгжилт 50-иас 60 хувьтай байх шиг байна. Үүнийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

2022 онд улсын хэмжээнд 135 сургууль буюу 20.7 хувь нь хүүхэд тээвэрлэх автобустай, 515 сургууль огт автобусгүй байсан бол 2023 оны байдлаар улсын хэмжээнд 292 сургууль хүүхэд тээвэрлэх автобустай болж бараг хоёр дахин нэмэгдсэн сайшаалтай байна.

Үүнээс төрийн өмчийн 72 сургууль, төрийн бус өмчийн 22 сургууль автобустай байгаа нь ялангуяа хүүхэд хүргэх, хүүхэд сургууль, гэрийн хооронд

аюулгүй зорчиход хүүхдийн сургуулийн автобусны тоог нэмэх зайлшгүй шаардлагатай байгааг харуулж байна.

Төрийн өмчийн сургуулийн боловсролын 650 сургуулиас 560 нь гаднаа камертай, огт камергүй 90 сургууль байгаа бөгөөд дотор камертай 589 сургууль, огт камергүй ерөнхий боловсролын 61 сургууль байна.

Бид сургууль доторх аюулгүй байдлыг хангахаас гадна сургууль руу хүүхэд ирж очих зам харгуйн аюулгүй байдлыг давхар хангах зайлшгүй шаардлагатай байна.

Засгийн газрын шийдвэрээр 2022 оноос цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж чадсан нь бага насны хүүхдийн хөгжих, хараа хяналттай байх, эцэг эх ажлаа хийх боломжийг бүрдүүлж чадсан.

Дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн эрх ашиг зөрчигдөх, амиа хорлох зэрэг нөхцөл байдал үүссээр байна. Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бэлдэн Улсын Их Хуралд өргөн барихаар бид бэлдсэн байгаа.

Уг хуулийн төсөлд боловсролын салбарын хүүхэд хамгааллыг өргөжүүлж, боловсрол, сургалтын бүх байгууллага, сүм хийд, дотуур байрны орчинд хүүхдийг хамгаалах, мөн сургуулийн орчинд хүүхдийн эсрэг хүчирхийлэл, дээрэлхэлтийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх, сургууль дээр гарсан хүүхэд хамгааллын кэйсийн мөрөөр сургуулийн хүүхэд хамгааллын баг ажиллах процессыг тодорхой зааж өгөөд байгаа юм.

Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 07-ны өдрийн нэгдсэн чуулганаар батлагдсан Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд хүүхдийн эрх, хамгааллын үйлчилгээг сайжруулах талаар дараах зохицуулалтууд туссан байдаг. Үүнд:

- (i) суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, дэмжлэг үзүүлэх;
- (ii) өсвөр насны хүүхдэд сэтгэл зүйн хямрал, гутрал, тогтворгүй байдлыг даван туулахад чиглэсэн сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлэх, сургууль, дотуур байрны орчинд дасан зохицох, суралцах, хөгжих, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаатай болгох;
- (iii) сургуульд суурилсан эрүүл мэндийн хяналт, тандалтын тогтолцоо бий болгох, суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүр бүртгэлийн сан бүрдүүлэх, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоо нь тодорхой насны давтамжтай хамруулах;
- (iv) дотуур байранд амьдарч байгаа суралцагчид хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны болон авьяасыг дэмжих хөтөлбөрийг тусгайлан хэрэгжүүлэх зардлыг хувьсах зардлаас санхүүжүүлэх;

(v) суралцагч, багш, ажилтан, эцэг эхийн үүрэг оролцоог мөн хуульчилж тусгасан байгаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Хүүхдийн хөгжлийн үйлчилгээний нөхцөл байдал, дүн шинжилгээ, хүүхдийн хөгжлийн бодлого, хууль эрх зүйн орчин, судалгааг хийж хүүхдийн хөгжлийг дэмжих үйлчилгээний зураглалыг Боловсрол, шинжлэх ухааны яам болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулсан.

Цаашдын хүүхдийн хөгжлийн үйлчилгээний нэр, төрлийг тодорхойлж, эрх зүйн орчинд тусгах, хөгжлийн үйлчилгээний стандарт, хөгжлийн үйлчилгээний зардлын аргачлал, норм, нормативыг батлан мөрдөх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалт, дэмжлэгийг нэмэгдүүлэх, үйлчилгээг гэрээлэн гүйцэтгүүлэх зэрэг чиглэлд анхаарч ажиллах болно.

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлтөөр Хүүхдийн төлөө санг сэргээн байгуулсан.

Засгийн газрын 2021 оны журам батлах тухай 172 дугаар тогтоолын хавсралтаар Хүүхдийн төлөө сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журмыг баталж, сангийн удирдлагыг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд хэрэгжүүлж, өдөр тутмын үйл ажиллагааг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар зохион байгуулна. **“Хүүхдийн”** гэж оруулсан байсан.

Хүүхдийн төлөө сан үүнээс хойш нийтдээ 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар 12.8 тэрбум төгрөгийн орлого төвлөрсөн байдаг. Энэхүү төвлөрлөөс ер нь зарцуулалт хийгдээгүй

юм билээ. Сая 2023 оны 7 дугаар сарын 01-нээс зарцуулах эрхийг төсвийн тодотголоор нээж өгсөн.

Өмнө нь гарсан шийдвэрүүд нь олон улсын тив, дэлхийн соёл, урлаг, спортын уралдаан, тэмцээн, наадамд амжилт гаргасан хүүхдэд 2021 онд 15 хүүхэд 25 сая төгрөг, 2022 онд 117 хүүхэд 249.4 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй 4 хүүхэд дэмжлэг үзүүлэхэд 23.3 сая төгрөг, нийт 121 нь хүүхдэд 272.7 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгох шийдвэр гаргасны 191 сая төгрөг нь 2023 онд олгогдсон.

Хүүхдийн замын хөдөлгөөний танин мэдэхүйн талбай төсөл өмнө нь шалгарсан байсан. 443.4 сая төгрөгийн төсөл. Үүнийг дэмжих шийдвэр өмнө нь гарсан байсныг сая 2023 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтад тусгаж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил явагдаж байгаа.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн хувьд хүүхэд хамгааллын үйлчилгээний санхүүжилт анх 2016 онд Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдаж 356 сая төгрөгөөр эхэлж байсан.

Ингээд жил бүр нэмэгдэж 2021 оноос тогтмол 8 тэрбум төгрөг төсөвлөн хэрэгжүүлж байгаа юм.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний төрөл, хэлбэрийг хуулиар оновчтой тодорхойлоогүй, үйлчилгээнд суурилсан зардлын төлөвлөлт тарифгүй, хяналт тодорхойгүй байсан зэрэг нь иргэд, олон нийтийн зүгээс энэхүү зардлын талаар мэдээ, мэдээлэл зөв буруу, ташаа ойлголт их байгаад байх шиг байна.

2022 оны төсвийн тухай хуулийг дагалдан Хүүхэд хамгааллын тухай

хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/218 дугаар тушаал, Хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлэх журам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Сангийн сайдын 2022 оны А/23, 27 дугаар тушаалаар “Хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын норматив”-ыг баталж мөрдүүлж байна.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний түвшин, төрөл, хэлбэр, үйлчилгээнд суурилсан санхүүжилтийг холбогдох аргачлал, нормативын дагуу олгох боломжтой болсон.

Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн зардлын 2020-2023 оны төлөвлөлтийг авч үзэхэд хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардалд 2022 онд 3.9 тэрбум төгрөг, 2023 онд 5.7 тэрбум төгрөг, шуурхай тусламж, үйлчилгээний зардалд 2022 онд 467 сая төгрөг, 2023 онд 348 сая төгрөг, урьдчилан сэргийлэх зардалд 2022 онд 3.1 тэрбум төгрөг, 2023 онд 1.8 тэрбум төгрөг хуваарилсан байна.

Үүнээс үзэхэд хүүхэд хамгааллын цэгүүд, түр хамгаалах байрууд гэх мэтчилэн хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээний зардал нийт төсвийн бараг 50 орчим хувийг эзэлж байгаа юм.

Хүүхэд хамгааллын хөтөлбөрийн зардлын зарцуулалтад аудит хийхэд холбогдох хууль, журмыг мөрддөөгүй, гүйцэтгэлд суурилсан, зардлын төлөвлөлт хийгдээгүй, санхүүгийн сахилга бат сул зэрэг хэд хэдэн зөрчил гарсан.

Цаашид холбогдох хууль журмыг мөрдүүлэх, хариуцлага тооцох, алдаа зөрчлийг арилгуулахад онцгой анхаарч ажиллана.

2024 оны төсвийн тухай хуулийн төсөлд хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлыг нэмэгдүүлж 14.3 тэрбум төгрөгийг 2024 оны төсөвт гээд тусгаад байгаа.

2023 оны хоёрдугаар улиралд хүүхэд хамгааллын үйлчилгээг санхүүжүүлэх аргачлал, үйлчилгээний зардлын нормативын хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж, үр дүнд суурилсан төлөвлөлтийн зарчимтай уялдуулан бид шинэчилсэн.

2023 оны хоёрдугаар улиралд аймаг, орон нутгийн хүүхэд, гэр бүлийн хэлтсийн дарга нар манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, олон улсын байгууллагуудтай хамтран бид норм, нормативыг шинэчлэн тогтоох тухай сургалт, семинар, аргачлалыгаа бид хамтран боловсруулсан. Үүнд:

1.Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардал, түүнийг санхүүжүүлэх зарчмыг тодорхой болгосон.

2.Хүүхэд хамгааллын үйлчилгээний зардлын дундаж нормативыг шинэчлэн боловсруулсан.

3.Хүүхэд шаардлагатай төлбөртэй тусламж, үйлчилгээг гэрээлэн авахаар зохицуулалтыг тусгасан. Сэтгэл зүйн, хууль зүйн өмгөөллийн үйлчилгээг гэрээлэн гүйцэтгэх мэргэшсэн төрийн бус байгууллагууд хүүхэд хамгааллын үйлчилгээг авах боломжтой болгож тусгаж өгсөн.

Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт болон хурдан морины уралдаанч хүүхдийн эрхийг хамгаалах талаар зарим хуулийн шинэчлэлийг тусгасан.

Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Хөдөлмөрийн тухай хуулийн суурь зарчимд хүүхдийн хөдөлмөрийг хориглох, хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах шинэ зохицуулалт тусгаж, 13 нас хүрсэн хүний эрхэлж болох хөнгөн ажлын нөхцөл, 15 нас хүрээгүй хүнийг урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаанд оролцуулах бүрд хүүхдийн эрхийн байцаагчаас зөвшөөрөл авах, насанд хүрээгүй хүнийг ажиллах хүч нийлүүлэх гэрээгээр ажиллуулах, уртын ээлж ээлжээр ажиллуулахыг хориглосон заалтууд тусгагдсан.

Мөн хуулийн 43 дугаар зүйлийн 43.3-т заасны дагуу ажил олгогч нь ажил, амралтын цагийг зохицуулах, хөдөлмөр эрхлэлтийн уян хатан нөхцөл хэрэглэх зэргээр ажилтны ажил, амьдралын тэнцвэрийг хангахад дэмжлэг үзүүлэх, хамтын гэрээ, хөдөлмөрийн дотоод хэм хэмжээнд тусгах замаар ажилтны хүүхдэд ээлтэй хүүхэд хамгааллын бодлого хэрэгжүүлнэ гэсэн чухал заалт тусаж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас холбогдох журам, зааврыг бид батлаад байгаа.

2023 оны байдлаар нийтдээ 563 байгууллага эцэг, эхийн зөвлөл байгуулж, 68 байгууллага цэцэрлэг, 522 байгууллага хүүхдийн өрөөтэй болсон байна.

Үндэсний их баяр наадмын тухай хуулиар хурдан морины уралдаанч хүүхдийн насыг 8 болгож, Үндэсний их баяр наадмын үед хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалт сайжирсан.

2023 онд нийтдээ 352 уралдаан уралдаанд 11 мянга 32 хүүхэд бүртгүүлж хурдан морь унаж оролцсон. 211 хүүхэд мориноос унаж, 145 хүүхэд ямар нэгэн бэртэл, гэмтэлгүй, 63 хүүхэд хөнгөн, 4

хүүхэд хүнд бэртэл авсан гэх мэтчилэн тоон үзүүлэлтүүдийг бид бүртгээд байгаа.

Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийн санг бид хөгжүүлж байна.

-Хүүхдийн тусламжийн 108 утасны үйлчилгээний төвийн программ,

-Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчид үзүүлэх хамгааллын үйлчилгээний портал сайт,

-Нийгмийн ажил, үйлчилгээний нийгмийн НАМС мэдээллийн сан,

-Хурдан морины уралдаанч хүүхдийн бүртгэлийн дэд сан,

-Асрамж, халамжийн төв, түүнд амьдарч байгаа хүүхдийн бүртгэлийн мэдээллийн дэд сан,

-Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн бүртгэл мэдээллийн дэд сангууд ажиллаж манай яамнаас хүүхдийн мэдээллийн 4 санд шинжилгээ хийж байна.

Хүүхэд, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн аяныг салбар дундын зохион байгуулалттайгаар үе шаттайгаар зохион байгуулж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эерэг аргаар хүмүүжүүлэх, ёс суртахууныг нийгэм, гэр бүлд төлөвшүүлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх, олон нийт, эцэг эхийн үүрэг оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр “Хүүхдээ эерэг аргаар хүмүүжүүлье” аян, “Зөв тусгал”, “Unfriend” хөдөлгөөн, “Эцэг, эхийн зөвлөгөөн”, “Хүүхдийн асуудлаар үүрэг хүлээгчдийн үндэсний зөвлөгөөн”, “Хүүхдийн оролцооны үндэсний чуулган”, **“НАЙЗ БАЙЯ”** зэрэг үндэсний чуулган, аян, бүсийн хэмжээний арга хэмжээнүүдийг мөн зохион байгуулсан.

Хүүхдийн эрх, аюулгүй байдлыг хангахад ахмад настны оролцоог хангаж 198 хүүхэд хамгаалагчийг нийслэлийн 152 хороо, 21 аймагт ажиллуулж, Хүүхэд хамгаалагч төслийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Цагдаагийн ерөнхий газартай хамтран үндэсний хэмжээнд 2022 оноос эхлэн хэрэгжүүлж байна.

Хүүхдийн эрхийг хамгаалах, аливаа эрсдэлээс сэргийлэх, эерэг аргаар хүмүүжүүлэх, ёс суртахууныг гэр бүлд нь төлөвшүүлэх, гэр бүлийн боловсрол олгох зорилготой **“ХАМТДАА ХАМГААЛЪЯ”** нөлөөллийн аян, ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн сурагчид, тэдний эцэг, эх, асран хамгаалагчид, багш, ажилтнууд олон нийтийн дунд үе тэнгийн дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой **“НАЙЗ БАЙЯ”** аян, Хүн худалдаалах гэмт хэргийн хүүхэд өртгөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, олон нийтийн мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилготой **“МЭДДЭГ, МЭДЭЭЛДЭГ БАЙЯ”** нөлөөллийн аян, өсвөр насны хүүхдүүдийн бэлгийн хүчирхийллийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, нуугдмал бэлгийн хүчирхийллийн илрүүлэлт, мэдээлэх үүргийг нэмэгдүүлэх зорилготой **“ЧИ ГАНЦААРАА БИШ”** нөлөөллийн аянууд 9-өөс 12 дугаар сарыг дуустал зохион байгуулж байна.

Хууль эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд 2020 онд хийсэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээгээр нийгмийн ажлын чадавх сул, мэргэжлийн удирдлага хангалтгүй, кэйс менежментийн арга зүйг тодорхой болгоогүй, хүүхдийн эсрэг хүчирхийллийг илрүүлэх авах арга хэмжээ, үйлчилгээ хөгжөөгүй,

үйлчилгээний зураглал тодорхойгүй, хүний нөөц, санхүүгийн нөөц дутагдалтай, хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээллийг багтаасан хүүхэд хамгааллын дижитал мэдээллийн удирдлагын систем хөгжөөгүй зэрэг олон асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгааг тодорхойлсон.

Иймд Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай хуулийн төслийг Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хууль болон Боловсролын хуультай уялдуулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бид бэлтгээд ажиллаж байна.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийг шинэчлэн найруулахаар ажиллаж, холбогдох судалгаа, шинжилгээ хийж, хэлэлцүүлгүүд өрнүүлж байна.

Гэр бүлийн тухай хуулийг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулж өөрийн вебсайт дээрээ байршуулан олон нийтээс саналыг авч байгаа юм билээ. Ингээд тун удахгүй Улсын Их Хуралд өргөн барихаар байгаа.

Энэ хуультай уялдуулж Хүүхэд хамгааллын тухай хуулийг бид өргөн барихаар төлөвлөөд байгаа юм.

2023 оны төсвийн жилд хүүхэд харах үйлчилгээний зардалд 1.5 тэрбум төгрөгийг зарцуулахаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын багцад батлагдаж, 643.3 сая төгрөгөөр 2023 онд 142 хүүхэд харах төвд 356 хүүхэд харагч, 1626 хүүхэд хамрагдсан байна.

2024 онд мөн төсөвт хүүхэд харах үйлчилгээний зардал мөн тусгагдаад явж байгаа.

Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийг бид

хийхгүйгээр хүүхэд харах, хүүхдийн эрхийг хамгаалахад хүндрэлтэй.

Энэ хүрээнд Хүүхэд харах үйлчилгээний төв байгуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 31 иргэн хамрагдаж, 270 сая төгрөгийн санхүүжилт зарцуулж, 61 ажлын байр бий болсон.

Хүүхэд харах төв түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээнд 31 иргэн хамрагдаж, 37.2 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн шинэчлэлийг хийхдээ эцэг, эхийн сонирхол, хэрэгцээнд нийцсэн, уян хатан, олон хувилбарт үйлчилгээг бий болгон хүртээмжийг нэмэгдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд бид анхаарах болно.

Хүүхэд харах үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бид мөн Улсын Их Хуралд өргөн барих шаардлагатай байгаа.

Цэцэрлэгийн хүртээмж нэмэгдсэнтэй уялдуулан Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран бид хүүхэд харах үйлчилгээг илүү хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд рүү чиглүүлсэн.

Мөн бага ангийн хүүхдүүд өглөө юм уу, орой, үдээс хойш хичээлдээ хамрагдаад хүүхэд харах хүнгүй гэртээ цоожлогдож үлдэж байгаа дээр чиглүүлэх шаардлага байна.

Г.Занданшатар: Гишүүд мэдээллээ анхааралтай сонсоорой. Чухал чухал асуудлаар ярьж байхад, хүүхдийн асуудлаар ярьж байхад.

Х.Булгантуяа: Хүүхдийн эрх хамгааллын талаар цаашид авах арга хэмжээний тухай товч танилцуулъя.

Б.Пүрэвдорж гишүүн ээ. Өнөөдөр нийгмийн аягүй хурц асуудал байгаад байгаа учраас мэдээлэл танилцуулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хүүхэд, гэр бүлийн салбарт хүний нөөцийн тогтвортой байдал алдагдсан. Цалин урамшуулал, нийгмийн баталгааны хөтөлбөр хэрэгжүүлэх ажлууд хийгдээгүй өнөөг хүрсэн.

Сум, хорооны хамтарсан багийн гишүүдийн 60 гаруй хувь нь солигдож, зарим хороо, сумд, нийгмийн ажилтангүй, хүүхэд, гэр бүлд үйлчилгээ үзүүлэх ажил орхигдож байна.

Эрүүл мэндийн салбар дахь хүүхэд хамгааллыг сайжруулах шаардлагатай байна.

Өрх, багийн эмч нарыг хүчирхийллийг таньж илрүүлэх, мэдээлэх, анхан шатын зөвлөгөө, мэдээлэл өгөх ур чадварт сургах ажил нэгдсэн төлөвлөлттэй хийгдэхгүй байна.

Хүүхэд, гэр бүлийн салбарын хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, гадаад, дотоодын урт хугацааны сургалтад хамруулж мэргэшүүлэх нийгмийн баталгааны хөтөлбөр хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

2016 оноос бид шинэ хуультай, шинэ тогтолцоотой болсон ч гэсэн энэ чиглэлийн боловсон хүчин бидэнд өнөөг хүртэл дутагдалтай байгаа. Энэ чиглэлийн боловсон хүчнээ бид үе шаттайгаар бэлдэх зайлшгүй шаардлагатай байна.

Аймаг, сумын Засаг дарга хуулиараа хүлээсэн үүргээ биелүүлж нийгмийн ажилтны тогтвортой ажиллах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Олон нийтийг соён гэгээрүүлэх, мэдээлэл сурталчилгаа, нөлөөллийн үйл ажиллагааны стратеги боловсруулж, боловсрол, соёлын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх болно.

Хүүхдийн эрхийн мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх, хүүхдийн цахим бүртгэлийн санг хөгжүүлэх, эцэг эх, асран хамгаалагчдын үүрэг хариуцлагыг сайжруулах, гэр бүлийн боловсрол олгох хөтөлбөрийг насан туршийн боловсролоор дамжуулан олгох, хүүхэд, өсвөр үеийнхэнд гэр бүлийн боловсрол олгох ажлыг үе шаттайгаар зохион байгуулах.

Төрөөс олгож буй нийгмийн халамжийн тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмжийг олгохдоо хүүхдийн эрх хамгааллын сургалтын боловсролтой уялдуулж олгох.

Өрхийн шилжилт хөдөлгөөний мэдээллийг бүрэн цахимжуулж бусад үйлчилгээний сантай холбох.

Үүрэн холбооны оператор компаниудтай хамтран **“Хүүхдийн дугаарын бүртгэл”** аяныг үндэсний хэмжээнд зохион байгуулах.

Монгол Улсад түгээмэл хэрэглэгддэг нийгмийн сүлжээний **FACEBOOK, INSTAGRAM, TIK TOK, GOOGLE** платформын аюулгүй байдлын болон нууцлалын тохиргоо хийх зааварчилгааг монгол хэл дээр гаргах.

Бүх шатын соёлын байгууллагаар дамжуулан хэрэгжүүлэх хүүхдийн сэтгэл

зүйн онцлог, чадварт нийцсэн хөгжлийг дэмжих соёлын олон талт бодлого арга хэмжээний төлөвлөгөө батлах.

Өсвөр насны хүүхэд, залуучуудын сэтгэл зүйн эрүүл мэнд амиа хорлоход хүргэж буй хүчин зүйлийг тодорхойлж, эрсдэлийг бууруулах.

Хүүхэд, эхчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, үзлэг оношилгоог хийхдээ хүчирхийлэлд өртсөн эсэхэд ажиглалт, хяналт тавьж ажиллах. Шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгууллагад холбон зуучлах талаар эрүүл мэндийн салбарын эмч, ажилтнуудад ойлголт, мэдлэгийг сайжруулах, хариуцлагыг нэмэгдүүлэх.

Шинээр баригдаж байгаа барилга, байгууламж болон замын засвар стандартын дагуу хийж гүйцэтгэхэд хяналт тавих, барилга хүлээн авах комисст хүүхдийн байцаагч оруулж ажиллуулах.

Хүүхэд эрүүл, аюулгүй байдлыг ханган ажиллах, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай хүүхдийн тоглоомын талбай, орон сууцын гэрэлтүүлэг, цахилгааны сүлжээний аюулгүй байдалд хяналт шалгалтын ажлыг сайжруулах стандартыг сайжруулах.

Барилгын цонх Ерөнхий шаардлага **MNS 5802:2007** стандартад далавчны нээгдэх хувилбаруудад хүүхэд унах, гэмтэх, амь насаа алдахаас сэргийлсэн хязгаарлалтыг тогтоож, онгойлгох хэмжээг нарийвчлан тусгах, хамгаалалт тор байршуулах зохицуулалтыг нэмж тусгах.

Байгууллагуудад эцэг эхийн зөвлөлийг байгуулан хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлж, хүүхдийн эрх хамгаалал, нас сэтгэхүйн болон хөгжлийн

онцлог, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн харилцаа зэрэг сэдвүүдээр сургалт сонсголыг тогтмол зохион байгуулж хэвшүүлэх.

Замын далан, ухсан нүх, суваг шуудуу, траншей, худаг орчимд анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ байршуулах, таглаж битүүлэх, эрсдэл бүхий орчныг камерын хяналтын системээр бүрэн хангах.

Сургууль, цэцэрлэг, нийтийн эзэмшлийн биеийн тамирын болон хүүхдийн тоглоомын талбайн тоног төхөөрөмж, тоглоом хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх, орчны гэрэлтүүлгийг сайжруулах ажлыг зохион байгуулах.

Нийгмийн хариуцлагын хүрээнд зорчигч хүүхдийн аюулгүй байдлыг хангаж, тайван зорчих нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор **“UB CAB”** такси үйлчилгээний компанитай хамтран ажиллаж хууль тогтоомжийн дагуу такси үйлчилгээг камержуулах ажлыг тодорхой үе шаттайгаар нэвтрүүлэх болно.

Улсын Их Хурлын дарга, Эрхэм гишүүд ээ,

Хүүхэд хамгаалал бүх нийтийн үйл хэрэг юм аа.

Хүүхэд хамгаалуулбал ганц нэг салбар, нэг яам хариуцдаггүй. Үүнийг ганцхан Улсын Их Хурлын ганцхан эмэгтэй гишүүдийн ч байдаг юм уу ажил гэж үзэж болохгүй ээ.

Үүнийг ганцхан хүүхдийн төлөө төрийн бус байгууллагууд ч хийх ёстой гэж бид харж болохгүй.

Монгол Улсын нийт хүн амын 36 хувийг бүрдүүлж байгаа хүүхдийн асуудалд олон нийтээрээ зайлшгүй

анхаарах ёстой юм байна гэж өнөөдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Улсын Их Хурал дээр энэ мэдээллийг хийж байгаа юм.

Хүүхдийн эрх хамгааллын талаарх бодлого, хууль эрх зүйн орчны шинэчлэлийг хийснээр хүүхэд хамгааллын оновчтой, цогц тогтолцоо, хүртээмжтэй мэргэжлийн үйлчилгээ, санхүүжилтийн зөв тогтолцоо, мэдээллийн сан бүрдэнэ гэж найдаж байна.

Мөн үүнтэй холбогдон Эрүүгийн хууль болон бусад хуулиудыг чангатгах асуудлыг бид Хууль зүй, дотоод хэргийн яам санаачлан хамтран хийнэ гэдэгт итгэлтэй байна.

Хүүхдийн эрхийг хамгаалахад салбар бүрийн хамтын ажиллагаа, бодит оролцоо чухал болохыг онцлон тэмдэглэхийг хүсэж байна.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Хүрэлбаатарын Булгантуяа, Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Ням-Осорын Учрал, Эрүүл мэндийн сайд Содномын Чинзориг, Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга Жаргалсайханы Хунан, Соёлын дэд сайд Мөнхөөгийн Батбаяр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын дэд сайд Сархадын Зулпхар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Пүрэвжавын Сайнзориг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга

Энхтуяагийн Ганхүү, Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлын албаны дарга Лхамтогмидын Нямгэрэл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Гэр бүлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Нарантуяагийн Баярмаа, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Начиндагвын Өлзийхутаг, Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Бригадын генерал Хожгорын Лхагвасүрэн, Монгол Улсын ерөнхий прокурорын орлогч Максимын Чинбат, Улсын Ерөнхий Прокурорын газрын орлогч прокурор Жандангийн Ариунаа, Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Гансүхийн Мөнхбаяр, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Гомбожавын Ариунбуян, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа Ганхуягийн Арсланхуяг, Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжил, боловсрол, эрүүл мэндийн асуудал хариуцсан орлогч Зундуйн Төмөртөмөө, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Чагдаржавын Чинбат, Тээврийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Ганбатын Отгонтамир, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газрын Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга Чулуунхишигийн Бадамханд, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Дагвадоржийн Дэлгэрсайхан нар оролцож байна.

Мэдээлэлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх Улсын Их Хурлын гишүүд.

Асуулт, үг хоёр нэг. Содномын Чинзориг, Ширнэнбаньдийн Адьшаа гишүүн. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн байна. Ингээд Ш.Адьяаа гишүүнээр тасаллаа.

Цагаанхүүгийн Идэрбат гишүүн.

Ц.Идэрбат: Өглөөний мэнд хүргэе ээ.

Өнөөдөр их чухал асуудал яригдаж байгаа. Миний хувьд хүүхэд хамгааллын багийг орон нутагт ахалж ажиллаж байсан хүний хувьд өнөөдрийн энэ яригдаж байгаа асуудлууд дээр, саяын танилцуулагдсан танилцуулга дээр ч гэсэн орон нутагт анхан шатад энэ хүүхэд хамгааллын асуудлыг хийхэд ямар асуудлууд байдаг юм бэ гэдэг тал дээр хэлье гэж бодож байгаа юм.

Ер нь хүүхэд хамгааллын асуудал гэдэг бол зөвхөн юу гэдэг юм эмэгтэй гишүүдийн юм уу, эсвэл нэг төрийн байгууллагуудын үүрэг байхаас биш энэ чинь эцэг эх, бүх секторууд энд л анхаарч байж л үр дүнд хүрнэ л дээ.

Тэгэхээр эхний ээлжид эцэг, эхийн хараа хяналтын асуудлыг нэлээн тийм тодотгож гаргаж ирмээр байгаа юм.

Өнөөдөр ерэн хэдэн хувьтай гар утас хэрэглэж байгаа хэрнээ ерэн хэдэн хувийн тэр эцэг, эхийн хэд нь хүүхдийнхээ маршрут энэ тэрийг гар утсан дээрээ харж байна вэ, ямар контент үзэж байгааг харж байна вэ гэвэл тийм өндөр тоо гарахгүй байгаа болов уу гэж бодож байгаа.

Тэгэхээр энэ тал дээр бид эхлээд ярих нь зүйтэй юм болов уу.

Хүүхдийн хүчирхийллийн 77 хувь нь гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байна

гэж байна шүү дээ. Тэгээд үүний үндэс ердөө л архидалт байдаг. Ердөө л архидалт.

Тэгэхээр архидалтын эсрэг бид томоохон арга хэмжээ авах юм бол гэр бүлийн хүрээнд үйлдэгдэж байгаа далан хэдэн хувьтай, өндөр хувьтай хүчирхийллийн нэлээдгүй хувь нь буурах байгаа юм.

Тэгэхээр анхан шатандаа сум, баг, хороон дээрээ гэр бүлийн хүрээний архидалтын эсрэг ямар арга хэмжээ авах вэ гэдгээ нэлээн сайн яримаар юм шиг надад санагддаг юм.

Хоёрдугаарт, сургуулийн орчин. Монгол Улс тийм яахаа алдчихсан хүн ам нь багтахаа больчихсон хүмүүс биш шүү дээ. Сургуулийн хүрээнд, сургуулийн өмнөх боловсролын хамрагдал гэх юм бол 90 гаруй хувьтай байгаа. Хүүхдүүдийн маань. Өндөр хувьтай улсуудын тоонд ордог, бид нар.

Тэгэхээр сургуулийн орчинд хүүхдийн аюулгүй байдал, хүчирхийллийн эсрэг анхаарах тал дээр сургалтаас гадна нийгмийн ажилтны үүрэг оролцоо, орон тоо энэ бүх юмнуудыг нэмээд явах юм бол бас энэ хүрээндээ бид хяналтаа тавиад байх бололцоотой болно.

Өнөөдөр 3, 4 мянган хүнд ганцхан нийгмийн ажилтан хаанаа ч хүр хүрдэггүй шүү дээ. Соён гэгээрүүлэх арга хэмжээ л хийдэг. Олон нийтийн арга хэмжээ хийхээс хэтрэхгүй байгаа.

Тэгэхээр миний хувьд сургуулийн нийгмийн ажилтны орон тоог нь нэмээд одоо энэ янз янзын сургалт, зөвлөгөөн хийнэ гэхээсээ илүүтэйгээр тэр эцэг, эхийн групп, ангийн групп чатууд зөндөө. Бүгд ийм байгаа. Хамгийн хурдан

мэдээлэл хүрдэг, хамгийн амархан зардал багатайгаар очих суваг бол энэ байдаг. Үүнийг КОВИД-ын үед орон нутагт туршиж үзэж байсан юм.

Тэгэхээр энэ янз янзын контент, хүчирхийлэлтэй холбоотой, хүүхэд өөрийгөө хамгаалахтай холбоотой контентуудыг бид үйлдвэрлээд эцэг, эхийн групп, ангийн группүүдээр явуулбал хамгийн үр дүнд хүрнэ. Хүүхдүүд тэрийг заавал уншина. Эцэг, эхчүүд уншдаг юм.

Тэгэхээр энэ тал дээр нэлээн анхаараасай гэж бодож байгаа юм.

Тэгээд эцэг эхийн зөвлөлүүд зөвхөн нэг волейболын тэмцээн, сагсны тэмцээн хийхээ болиод яг үр хүүхдийнхээ сургууль, хүмүүжил энэ тал руугаа анхаарах юмнуудыг гол төлөв сургуулиас нь санаачилж зохион байгуулбал нэлээдгүй үр дүнд хүрэх болов уу гэж хардаг юм.

Дараагийнх нь, хамтарсан багийн асуудал. Хамтарсан багийн асуудал дээр эцэстээ хаана хүрэх вэ гэдэг нь тодорхойгүй байдаг юм.

Тэгэхээр хамтарсан багийн асуудал дээр ялангуяа 5 мянгаас дээш хүн амтай багууд дээр яг энэ хүүхдийн асуудлыг хариуцсан орон тоо нэмээд өгчихвөл үр дүнд хүрэх юм болов уу гэж хардаг юм.

Тэгэхгүй одоо байгаа бүтэц дээр явах юм бол тэр 5 мянган хүн, 10 мянган хүнд хүрэх гээд тэд нар зарим үед хүүхэдтэй манатай л болдог шүү.

Тэгэхээр энэ мэтийн ийм нэг, магадгүй бид деталь юм яриад байж магадгүй. Гэхдээ яг амьдрал дээр байгаа юмнуудыг л ярьж байгаа юм.

Ямар ч мөнгөний эрх мэдэл байхгүй. Нэг яваад хүүхдээ эргэчихье. Мөнгө байхгүй. Машины бензиний мөнгө байхгүй. Тэгээд орон нутагтаа ажиллаж байхдаа би энэ дээр таван төгрөг тавиад багийнхандаа зарцуулаад үзэж байсан. Үр дүнд хүрдэг юм билээ. Үүнийг би гишүүн болсон цагаас хойш бараг гурав дахиа ярьж байгаа.

Тэгэхээр одоо төсөв яригдаж байгаа энэ үед үүнийг маш сайн ингээд бүр нэг детальчлаад ингээд үзэх юм бол бидний хүсээд байгаа үр дүн жоохон ч гэсэн хувь дээшлэх болов уу гэж ингэж бодож байгаа.

Дараагийнх нь, мэдээж стандарт. Сая.../минут дуусав/

Г.Занданшатар: Санал хэлсэн. Үг хэллээ. Одоо Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: М.Оюунчимэг ээ, би нэг үг хэлчихье.

Сая Х.Булгантуяа сайдын танилцуулга дээр 2016 онд Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудыг баталсан.

Ер нь хүүхдийн эрхийг хамгаалах, гэр бүлийн хүчирхийллээр урьдчилан сэргийлэх, хүүхдийг тусгай хамгаалалтаар хамгаалах энэ хууль эрх зүйн орчин хангалттай байгаа гэж ярьж байгаа юм.

Тэгээд яагаад энэ хэрэгжихгүй байна.

Дараагийнх нь нэг асуудал бол энэ хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхэд хамгаалалттай холбоотой хөрөнгө санхүү

2017 онд 1.2 тэрбум байсан бол 2022 онд 8 тэрбум төгрөг болж нэмэгдсэн гэж байгаа юм.

Ингээд яагаад үр дүн гарахгүй байна.

Тэгээд ингээд намын үзлээр хандаад танай нам эрх барьж байхад, манай нам эрх барьж байхад гээд яриад байдаг. Ийм юм байхгүй.

Тэгээд одоо юу гэж ярьж байгаа вэ гэхээр хүүхэд хамгааллын асуудал бол эцэг эх, гэр бүл, ахан дүүс, хамаатан садан, багш сурган хүмүүжүүлэгч, нийгмийн бүх эд эс хүүхэд хамгааллын асуудалд оролцох. Энэ үнэн.

Гэхдээ Монголын нийгэм 30 жилийн хугацаанд яагаад ийм балиар ийм болчхов оо? Үүнийг бид бодох ёстой.

Би өчигдөр сайд нарын томилгоон дээр хэлсэн. Өнөөдөр би нэг пост харсан. 100 хар шоргоолж 100 улаан шоргоолжийг шилэн саванд хийчих юм бол яах ч үгүй байгаад байна гэж. Тэр шилэн савыг сэгсрэх юм бол бие биеэ бариад эхэлнэ гэж байгаа юм. Тийм юм харлаа.

Тэгэхээр тэрийг ингээд сэгсрээд байгаа нөхдүүд хэн байна вэ гэхээр зэрэг та бид энд төрийн эрх барих дээд байгууллага энэ Их Хуралд, тэгээд энэ төрийн эрх мэдлийг барьж байгаа энэ хүмүүсийн үлгэр манлайлал, хариуцлага энэ байдлаас л шууд шалтгаалж байгаа ийм зүйл шүү дээ.

Энэ 30 жилийн асуудал. 33 дахь жил рүүгээ орж явж байгаа ийм зүйл.

Тэгээд ерөөсөө байж байгаа зүйл бол бид дээрээсээ эхлэх ёстой байна. Бид нарын байж байгаа хүмүүсийн сахилга

хариуцлага, ялангуяа энэ авлига, ашиг сонирхол. Энэ авлига гэдэг 30 жил энэ Монголын нийгмийг идээд ирлээ шүү дээ. Мэрээд идээд ингээд одоо ийм байдал руу оруулсан. Энэ цаг багтахгүй учраас би бүгдийг нь тоочиж чадахгүй байна л даа.

Тэгэхээр энэ суурь үндсэн шалтгааныг нь Монгол Улсын Их Хурал, Засгийн газар, энэ Засгийн газрын тэргүүн, Ерөнхий сайд одоо ингээд хараад тэгээд энэ тэмцлийг бүхэл бүтэн энэ 30 жилийн хугацаанд авлигатай тэмцэх жил болгож Засгийн газар анх удаа зарлаад ажиллаж байна шүү дээ.

Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байгаа вэ гэхээр энэ юмнаас та бид ухарч болохгүй шүү. Энд оруулж ирж байгаа тэр ашиг сонирхлын хууль, аруугийн хууль, тэгээд л оруулж ирж байгаа энэ авлигатай тэмцэх хууль эрх зүйн энэ юмнаас дундуур нь ингээд завшаад хууль өөрчлөөд. Энд сууж байгаа эрх мэдэлтэй улсуудын эрх ашгийг хамгаалах, тэр хуучин ах дүү нар, үр хүүхдүүдээ томилчихсон томилгооноос нь чөлөөлөхгүй байх.

Тэгээд энэ төр, бизнесийг зааглаж ялгах гэсэн ийм хуулийг нь сулруулах. Тэгээд дахиад л нөгөө төсөл тендер, концесс, лиценз, төр, ард түмний нэр барьж явсан зээл бондоос дэлсдэг энэ юмыг чинь бүр таг хаачхаад байхад одоо үүнийг дахиад л нэг зай гаргаж өгөх гээд. Ийм юм хэрхэвч байж таарахгүй ээ.

Энэ авлигалтай хийх тэмцлийн үр дүн шууд өргөс авсан юм шиг маргааш нийгэмд нөлөөлөөд байна гэж байгаа үг биш. Гэхдээ энэ суурь шалтгааныг нь бид энэ тэмцлээр л өөрчлөхөөс өөр үг байхгүй.

Дараагийнх нь юм бол одоо ингээд жендэрийн асуудал яриад байгаа юм. Тэгээд энэ асуудал яригдаж байгаатай холбоотойгоор ялангуяа Улсын Их Хуралд байгаа эмэгтэй гишүүд рүү нийгэм, социал ингээд хандаад байх шиг байгаа юм. Гэтэл цаад талынх нь суурь шалтгаан бол ерөөсөө энэ эр хүн рүүгээ хандсан бодлого чиглэл л хэрэгтэй байна. Эр хүн бэлтгэж ирсэн энэ арга ухааныг бид гаргаж энэ дээр нэг жоохон арга хэмжээ авч ингэж ажиллаж, суурь шалтгаанаас нь бид.../минут дуусав/

Г.Занданшатар: Үг хэллээ. Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Төсөв санхүүжилт нь нэмэгдээд байгаа мөртлөө яагаад хүүхдийн эрх хамгаалагдаж чадахгүй байна вэ гэж олон нийт ч гэсэн асууж байх шиг байна. Яг манай Б.Бат-Эрдэнэ сайд шиг.

2016 онд бид анх байгуулагдахад энэ ганцхан Ерөнхий газар байсан. Үүнээс хойш 21 аймаг, 9 дүүрэгт бид нэгжтэй байсан. 2017 оноос манай нэгжийн тоо 5 дахин нэмэгдсэн. Яагаад гэвэл хүчирхийлэл ганцхан Улаанбаатар хотод гардаггүй. Хүчирхийллийн кэйс үүслээ гэхэд. Одоо манай энэ чиглэлийн нийгмийн ажилтнууд ганцхан аймгийн төвд л байгаа. Сумдад жишээлбэл хүрч очиж ажиллаж чаддаггүй.

Ямар нэг кэйс үүслээ гэхэд аймгийн төвөөс 200 300 километр машинтай давхиад тэнд очоод ажиллахад түрүүн манай Ц.Идэрбат гишүүн хүн хэллээ. Төсөв санхүүжилт, бензин шатахуун гээд л энэ бүх зардлууд яг л адилхан гарч байгаа юм.

20 түр хамгаалах байр, 15 нэг цэгийн үйлчилгээ гээд энэ бүгдэд

өнөөдөр зөвхөн 2018-2023 онд гээд нийтдээ 5 хүрэхгүй жилийн дотор 19 мянга орчим хүмүүс үйлчлүүлсэн байна.

Үүнтэй холбоотойгоор л энэ зардлууд ерөнхийдөө нэмэгдээд байгаа юм. Гэхдээ ер нь бас ийм л дээ. Энэ нийгмийн ядуурал, ажилгүйдэл, архидалт, гэмт хэргийн тоо яг өсөж байгаа учраас үүнтэй уялдаад л үүний сүүдэрт харамсалтай нь хүүхдүүд хамгийн түрүүнд өртөж байгаа.

Бид гол үүсгээд байгаа энэ том асуудалтайгаа тэмцэж чадахгүй бол энэ төсвийг нэмээд нэмээд үнэнийг хэлэхэд хэцүү. Хүүхдийн хүчирхийлэлгүй улс гэж байдаггүй юм билээ. Харин тэгэхдээ хүүхдийнхээ хүчирхийлэлтэй тэмцэхэд мэдээж энэ ажил дээрээ бид тасралтгүй ажиллана.

Гэхдээ үүн дээр түрүүн манай Ц.Идэрбат гишүүн ч хэллээ. Нийгмийн бухимдал, стресс, ажилгүйдэл, ядуурал, ялангуяа архидалт. Үүнтэй бид зайлшгүй тэмцэх ёстой.

Б.Бат-Эрдэнэ сайдын хэлж байгаа үнэн. Хүчирхийлэл үйлдэгч нарын үнэнийг хэлэхэд ихэнх нь эрэгтэйчүүд байдаг. Ихэнх нь амьдралын боломж хүнд хэцүү, архидалт. Архидалт нь донтолттой болсон гээд. Энэ асуудлыг бид давхар ярихгүйгээр хүүхэд хамгааллын асуудлыг ганцхан нөгөө өнцгөөс нь ярихад хэцүү юм билээ.

Тэгэхээр үүний л сүүдэр өнөөдөр хүүхдүүд дээр минь тусаж л энэ асуудал үүсэж байгаа л гэж бид харах хэрэгтэй.

Ганцхан хүүхэд хамгааллын зардал төсвөөс гадна эрүүл мэндийн үйлчилгээ, наркологийн үйлчилгээ, архидан согтууруулалттай тэмцэх талаар. Дээрээс нь нэмээд хуулийн хариуцлагыг

чангатгах талаар, нийгмээрээ үүнийг бүр нэг тэмцэх ийм л сэтгэл зүйг бид бэлдэж байж л үүнийг бий болгож чадах юм билээ. Хүүхэд хамгааллыг.

Г.Занданшатар: Салдангийн Одонтуяа гишүүн.

С.Одонтуяа: Тэгэхээр Улсын Их Хурлын гишүүний үндсэн үүрэг хууль батлах, баталсан хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох төсвүүдийг батлах байдаг.

Тэгэхээр одоо яг төсөв хэлэлцэхийн өмнө энэ асуудлыг ингэж ярьж байгаа нь яг цагаа олсон нь зөв зүйтэй байна.

Сая олон хүн хэлж байна л даа. Энэ хүүхдийн асуудал бол аль нэг нам, эвсэл хамаагүй, эмэгтэй эрэгтэй хамаагүй бүгд л энд анхаарах ёстой гэж. Би энэтэй санал нийлж байна.

Бид хүүхдээ хамгаалж чадахгүй улс орон өөр юугаа хамгаална, юун үндэсний аюулгүй байдал гээд яриад суух билээ.

Тэгэхээр 2021 оны 3 дугаар сарын 05-нд эмэгтэй гишүүдийн бүлгээс Хүүхэд хамгааллын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг санаачлаад Улсын Их Хуралд өргөн бариад хэлэлцэх эсэх нь дэмжигдсэн.

Ямар шалтгаанаар өнөөдөр багтахгүй байгаа вэ гэхээр Засгийн газраас энэ хууль орж ирнэ. Хамтатгаад баталчих аа гэсэн ийм хүсэлт Засгийн газраас ирсэн учраас бид өнөөдрийг хүртэл хүлээгээд маш их цаг алдлаа.

2022 оны 6 дугаар сарын 01-нд бас Эмэгтэйчүүдийн бүлгээс Гэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

хуулийг өргөн барьсан. Тэгээд энэ ингээд удаад байна.

Өчигдөр Х.Нямбаатар сайд хэлнэ лээ. Өнөө маргаашгүй оруулж ирэхэд бэлэн болсон гэж.

Тэгэхээр Монгол Улс чинь одоо байгаа Гэр бүлийн хууль нь 1999 он билүү дээ хууль шүү дээ. Яаж 1999 оны хуулиар өнөөдрийн энэ гэр бүлийн харилцааг зохицуулах юм. Ямар ч боломжгүй.

Тэгээд тэр эцэг, эхийн үүрэг хариуцлагыг нь нэмэгдүүлье гэдэг чинь ерөөсөө л энэ гэр бүлийн хуульд маш тодорхой заалтууд ороод явж байгаа.

Хоёрт, та нар мэдэж байгаа байх. 3 настай хүүхдийг зодож гэмтээсэн. Өнөөдөр хүртэл тэр хүүхэд бараг ухаан орохгүй байгаа.

Тэгэхээр хүүхдийг зодож гэмтээсэн, хүнд гэмтэл учруулсан этгээдүүдийн ялын бодлогыг чангатгах хэрэгтэй. Энэ албан бичгийг би 7 дугаар сард Хууль зүйн яам руу явуулсан байгаа.

Б.Энхбаяр дарга үүнийг та онцгой анхаараад энэ шинэ орж ирэх хуульдаа тусгаж өгөх хэрэгтэй.

Нэг асуудал дээр их сэтгэл дундуур байна. Хууль нь байгаад байдаг. Хэрэгжилт дээр алдаа гараад байна гэж.

Энэ нөгөө хүүхдийн эрхийн байцаагч гэж бид баталж байсан. Энэ бол яг хүүхдийн төлөө шүгэл үлээж байх ёстой хүмүүс байхгүй юу. Хэрэг гарахаас нь өмнө тэр газар очоод энд яг хүүхдийн эрх зөрчигдөх гээд байна шүү. Үүнийг засаж залруулахгүй бол болохгүй гэдгийг ярих ёстой.

Тэгээд энэ хуулиараа төрийн албан хаагчийн журамдаа төрийн албан хаагч болгочихсон юм уу хаашаа юм.

Тэгэхээр төрийн албан хаагчийг яаж тэр төрийн байгууллагынхаа эсрэг шүгэл үлээх юм. Энэ бол бие даасан, хараат бус юу гэдэг юм Хүний эрхийн Үндэсний Комисс шиг ингээд тусдаа ч юм уу байх ёстой.

Энэ хүүхдийн эрхийн байцаагч нарын би зоригтой гараад дуугарч байгаа нэг ч юм олж сонссонгүй. Энэ хүмүүс хаана явна вэ? Энэ хүмүүсийн дуу хоолойг яагаад хориод байна. Энэ хүмүүс чинь хүүхдийн эрх зөрчигдсөн үед барын аманд гараа хийхээс ч буцахгүй хүмүүс байх ёстой. Энэ дээр би тайлбар авъя.

Төсвийн асуудал дээр хэд хэдэн чухал асуудлыг яримаар байна. Одоо энэ газар хөдлөлтийн асуудал бид нарын сэтгэлийг маш их зовоож байна.

Сургууль, цэцэрлэгийн байшингуудыг хамгийн түрүүнд энэ газар хөдлөлтийн тэсвэртэй эсэхийг одоо яаралтай төсөв гаргаж үүнийг үзэх ёстой. Энэ дээр анхаарах ёстой. Баахан сургууль, цэцэрлэг нураад хүүхэд амь эрсэдсэний дараа үүнийг хэчнээн яриад ямар ч хэрэггүй.

Хар тамхи, хүн худалдаалах гэмт хэргийн асуудал. Энэ бол яах вэ, ил ярих асуудал биш. Энэ дээр нэлээд судалгаа хийлээ.

Улсын Их Хурлын даргад, Тусгай хяналтын дэд хороонд албан бичиг хүргүүлсэн байгаа. Энэ дээр төсөв хөрөнгө тавихгүй бол ноцтой байдалд хүрсэн байгаа.

Энэ хүчирхийллээс хамгаалах байруудын төсөв дээр олигтойхон юм

тавихгүй бол дандаа хандив тусламжаар л урсгал зардлаа аргалдаг.

Тэгээд хэдэн хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүд, хүүхдээс л хамаг мөнгөө харамлаад л. Яагаад байдаг юм. Үүнийг анхаарах хэрэгтэй.

Хүүхэд харах үйлчилгээг би Боловсролын сайдаас асуумаар байна. Нэг л бүдгэрээд л, тоо нь цөөрөөд л явчих шиг болох юм.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Холбогдох газрууд хариулж болно. Н.Баярмаа дарга хариулъя. 83.

Н.Баярмаа: С.Одонтуяа гишүүний асуултад хариулъя.

Хүүхдийн эрхийн тухай хуулийн дагуу хүүхдийн эрхийн улсын байцаагчдын эрх зүйн зохицуулалт байгаа.

Тухайн салбартаа 5 жил ажилласан хүмүүнлэгийн болон ийм сургууль төгссөн хүмүүс гээд.

Хүүхдийн эрхийн байцаагчийн дүрмийг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалаар батлаад, яг салбартаа ажиллаж байгаа хүүхдийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд болон асуудал хариуцсан хэлтсийн дарга нар нь ахлах байцаагчийн эрхтэйгээр мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаад явж байна.

Одоогийн байдлаар улсын хэмжээнд 6 ахлах байцаагч, 37 хүүхдийн эрхийн байцаагч нар Зөрчлийн хуульд заасан 20 зөрчил, мөн сүүлд нэмэгдсэн хүүхдийн мөнгөн тэтгэмжийн олголтын байдалд эцэг, эх нь хүүхдийн эрхийг зөрчсөн, архидан согтуурсан, хаяж явсан ийм эцэг, эхчүүдэд дүгнэлт гаргаж зөрчлийг тооцож байна.

Тэгээд 2023 оны байдлаар 1100 гаруй хүүхдийн эрхийн зөрчил хүүхдийн эрхийн байцаагч нар дүгнэлт шийдвэр гаргасан.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж дээр 700 гаруй хүүхдүүдийн мөнгөн тэтгэмжийг цуцалж хүүхдийнх нь нэрийн дансанд хадгалуулах энэ ажлуудыг хийгээд явж байна.

Тэгээд Хүүхэд хамгааллын хуулийн шинэчилсэн найруулгыг дагаж Хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа.

Тэгээд энэ дээр яг хүүхдийн эрхийн улсын байцаагчийн эрх зүйн орчныг дээшлүүлэх, тухайн харьяалах орон нутгийн хүүхэд, хүн амын тоонд нь харьцуулж Засгийн газар хүүхдийн эрхийн улсын байцаагчдын квотыг тогтоодог байх дүрмийг нь баталдаг байх. Нийгмийн баталгаа, эрх зүйн орчныг сайжруулах чиглэлийн зохицуулалт Хүүхдийн эрхийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр хийгдэнэ гэж үзэж байгаа.

Г.Занданшатар:

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд. Боловсрол, шинжлэх ухааны сайд хариулья.

Л.Энх-Амгалан: С.Одонтуяа гишүүн ээ, Хүүхэд харах үйлчилгээний хуулиа бид эргэж харах ийм цаг болсон байна.

Өнөөдөр хүүхэд харах үйлчилгээг бид юу гэж ойлгох вэ? Энэ үйлчилгээ байвал хэнийг хамруулах вэ, ямар үйлчилгээ өгөх вэ, тэрний хувьсах зардлууд, санхүүжилтийн тогтолцоонууд нь юу байх вэ гэдгээ эргэж харах нийгмийн хэрэгцээ шаардлага үүссэн байна гэж харж байна. Нэгд.

Хоёрт, Монгол Улсын Засгийн газраас сүүлийн хоёр жил цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэл нэлээн томоохон арга хэмжээнүүд авч ямар ч байсан хүсэлт гаргасан хүүхэд бүрийг цэцэрлэгт хамруулдаг ажил хийсэн. Бодитой үр дүнд хүрсэн. Үүнтэй хэн ч маргахгүй болов уу гэж бодож байна.

Ямар ч байсан манай улс шиг сургуулийн өмнөх боловсролынхоо хамрагдалтыг 90 хувьд хүргэсэн улс орон байхгүй юм билээ шүү. Манайх бүсийн хэмжээнд их томоохон амжилт гаргаж байгаа ийм улс юм билээ.

Тэгээд тэр тусмаа 5 настай хүүхдийн цэцэрлэгийн хамрагдалт 92 хувь гэдэг бол маш их өндөр хувь байгаа. Бид энэ тогтолцоогоо сайжруулах шаардлага байна. Нэгд.

Хоёрт, сая Боловсролын багц хуулиар бид чинь цэцэрлэгийн насаа албан ёсны насыг 3-аас 5 нас байсныг 2-оос 5 нас болгоод хуульчилчихсан.

Тийм учраас 2-оос 5 насны хүүхдийн цэцэрлэгийн хамрагдалт дээр төр үүрэг гүйцэтгэнэ. Төрийн үүрэг гэж ойлгож болно.

Тэгээд одоо яг 0-ээс 2 насны хүүхдийн асуудал дээр мэдээж Эрүүл мэндийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Боловсролын яамны хоорондын уялдаа нэлээн чухал байгаа юм. Өсвөр насны хүүхдийн цогц хөгжлийн үйлчилгээг ямар хэлбэрээр яаж хүргэх вэ гэдэг асуудал дээр бид нэлээн анхаарч ажиллаж байгаа.

Тэгээд энэ хүрээндээ таны хөндөж байгаа хүүхэд харах үйлчилгээнийхээ хууль, нийгмийн хэрэгцээний асуудлуудыг бид шинэчлэх ийм

зайлшгүй шаардлагууд болж байна гэж бодож байгаа.

Гол нь Монгол Улсад байгаа 11 мянга 800 хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн асуудал байгаа юм. Тэрний 60 хувь нь ямар нэг хэлбэрээр сургууль, цэцэрлэгийн үйлчилгээг авч байна. 40 хувь нь огт авч чадахгүй хүн хэлбэрийн, бэрхшээлтэй, өвчинтэй, зовлонтой хүүхдүүд байна.

Энэ хэлбэр бол би энэ хүүхэд харах үйлчилгээгээ бид улам илүү боловсронгуй болгож чадах юм бол энэ тогтолцоогоороо дамжиж энэ хүүхдүүдэд боловсролын үйлчилгээ, эрүүл мэндийн үйлчилгээг хүргэх ийм нэг зөв шийдэл байж болох юм болов уу л гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Одоо Даваажанцангийн Сарангэрэл гишүүн.

Д.Сарангэрэл: Баярлалаа. Хүүхэдтэй холбоотой гэмт хэргийн асуудал үнэхээр хэрээс хэтэрч байна л даа.

Цагдаагийн байгууллагын мэдээлэл авахад 2023 оны хагас жилд **960** гэмт хэрэгт **990** хүүхэд хохирсон байна. **374** нь гэмтсэн, **3** нь нас барсан гээд. Энэ тоонуудтай ярих юм алга.

Хагас жилийн хугацаанд **251** хүүхэд бэлгийн хүчирхийлэлд өртсөн байна.

Тэгээд бид нэг ийм сэтгэл сэртхийлгэсэн гэмт хэрэг гарахаар зэрэг цочоод нэг баахан юм болдог юм. Нийгмээрээ, харьяа байгууллагууд нь сэрээд, тэгээд хоорондоо яриад ингээд л өнгөрдөг л дөө.

Сая сайд ерөнхий мэдээлэл хийлээ. Одоо бид тодорхой асуудлуудыг ярих ёстой гэж би бодож байна. Тухайлбал, Англи Улсад бага насны хүүхдийг хүчирхийлсэн хүнд бугуйвч зүүлгэдэг. Тодорхой радиус тойргоос илүү гаргадаггүй ийм арга хэмжээ байж байна. Америкийн Нэгдсэн Улсад энэ хүчирхийлэл үйлдэгчийн лист мэдээллийг зурагтай нь гаргадаг. Интернэтэд. Тухайн иргэн аль нэг дүүргээс өөр дүүрэгт ирлээ гэхэд хүүхдэдээ тэр зургийг зааж өгнө. Манай бидний амьдарч байгаа энэ хэсэгт ийм хүчирхийлэгч, ийм хүн байгаа шүү гэж ингэж болгоомжлуулдаг.

Зарим бусад оронд миний энэ хэлэх үг нэлээн шүүмжлэл дагуулна биз дээ. Энэ хүчирхийлэл үйлдэгч, бага насны хүүхдийг хохироодог ийм хүмүүст химийн аргаар арга хэмжээ авдаг, ажиллагаагүй болгодог ийм мэдээллүүд интернэтэд байна.

Одоо бид үүнийг олон жил ярьсан. Үг, асуулт хоёр хамт байгаа учраас. Хуулийн сайд байж байна. Холбогдох байгууллагын төлөөллүүд, цагдаагийнхан байж байна.

Саяын миний энэ ярьж байгаа асуудлуудыг та нар судалсан уу? Авах боломжтой юу? Хэзээ арга хэмжээ авах вэ гэдгийг би давхар асуумаар байна.

Өчигдөр Ерөнхий сайд Их Хурал дээр үг хэлсэн. **Камержуулалт**-ын асуудлыг ярьсан.

Х.Нямбаатар сайд маань энэ камержуулалтын асуудлыг нэлээн ахиулсан шүү.

Үүнийг үндэсний хэмжээнд хийхэд эмэгтэй гишүүдийнхээ санаачилгыг 2024 оны төсөвт дэмжинэ

гэдгээ Ерөнхий сайд илэрхийлсэн. Улсын Их Хурал дахь 13 эмэгтэй үндэсний хэмжээнд камержуулалтын асуудлыг шийдвэрлэх тэр төсвийн тооцоо судалгааг хийж хуульд суулгана.

Камерын ач холбогдлыг та бүхэн мэдэж байгаа. Тийм ээ.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлнэ. Гэмт хэргийг түргэн шуурхай илрүүлэхэд ач холбогдолтой.

Энэ асуудлыг бид өөрсдөдөө авахыг хүсэж байна.

Гуравдугаарт, бага насны хүүхдийг хүчирхийлсэн энэ гэмт этгээдэд өршөөл үзүүлдэггүй, магадлангаар оруулдаггүй байх, бүх насаар нь хорьдог байх ийм хуулийн хатуу заалтаа хийе ээ. Хуулийн бодлогоо чангатгая. Олон жил ярилаа шүү дээ, бүгдээрээ. Одоо хийе.

Хуучин бүх насаар нь хорино. Нөгөө хуулийн дээд хэмжээ чинь 25 байсан юм. Одоо 20 болчихсон. Бас л энэ гаднын мэдээллийг уншихад 300 жил, 60 жил, 65 жил гээд л бүх гэмт хэргүүдийг нь нийлүүлж байгаад л ингээд л өгдөг юм билээ.

Манай дээд хэмжээ чинь өөрөө 20 жил юм байна шүү дээ. Хэрэв 12 настай охиныг хохироосон энэ этгээдийг 2016 онд бага насны хүүхдийг хүчирхийлсний улмаас бүх насаар нь хориод, өршөөл үзүүлээгүй юм уу, магадлангаар гаргаагүй юм уу, тэр жилийг нь өгчихсөн бол магадгүй энэ хэрэг үйлдэгдэхгүй байсан байж болох байсан.

Хуулийнхан минь ээ, та нар хийнэ шүү дээ, үүнийг. Ийм төслөө оруулаад ирээч ээ. Улсын Их Хурлын 13 эмэгтэй энэ хуулийг барьж аваад ажиллаад батлуулъя.

Ийм эрс арга хэмжээнүүдийг авахгүй бол халагласаар байгаад бид хүүхдүүдээ хохироож дуусах нь. Аль болгон одоо бүгдээрээ доошоо хараад баахан гунигтай царайлаад гашуудлын байдалтай ерөнхий мэдээлэл яриад.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр Хууль зүй, дотоод хэргийн сайд. Ажлаа аваад нэг хонож байна.

Б.Энхбаяр: Хүүхдийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлыг Улсын Их Хурлын чуулганд бараг анх удаа шахуу өндөр түвшинд өргөн бүрэлдэхүүнтэйгээр олон талаас нь ярьж байгаад баяртай байна.

Хүүхдийн эрхийн зөрчлүүд ер нь байнга л гарч ирсэн.

Ер нь сүүлийн 5 жилийн байдлаар гэмт хэргийн улмаас 10 хүүхэд амь насаа алдсан, 300 орчим хүүхэд гэмтэж бэртсэн ийм дүн мэдээлэлтэй байгаа.

Олон хүчин зүйл нөлөөлж байгаа. Олон хүчин зүйл. Нийгмийн хүчин зүйл, өөрөөс хамаарах хүчин зүйл, төр хуультай холбоотой асуудлууд гээд энэ их өргөн хүрээнд авч үзэх ёстой.

Миний тухайд хууль зүйн хүчин зүйлтэй холбоотой буюу ялын бодлогыг чангатгах чиглэлд ямар бодол санаа байна вэ гэдэг дээр айхтар цочиж савж болохгүй. Их шинжлэх ухааны үндэстэй энэ асуудалд хандах ёстой гэдэг ийм байр суурьтай явдаг. Угаасаа.

Айхтар их олон нийтэд хүчирхийлэлд өртсөн хүүхдийн зураг хэргийг гаргахыг би огтхон ч хүлцдэггүй. Хүн болгоноос уриалмаар байна. Өнөөдрийн сонсголыг үзэж байгаа бүх

хүнээс. Аав болгоноос, ээж болгоноос, ах болгоноос.

Ямарваа нэгэн байдлаар хүчирхийлэлд өртсөн ийм гэмт үйлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэх энэ асуудалд тухайн хүмүүс ер нь. Үнэхээр тэр хүүхдийг хайрлаж байгаа бол та болих хэрэгтэй. Үнэхээр хайртай бол.

Худлаа хайр эсгэсэн дүр эсгэж байгаа бол яах вэ. Тийм хүмүүсийг битгий өөгшүүл. Хүүхдийн хүчирхийллийг сурталчилж байгаа нэг хүн дээр ч битгий лайк дар. Нэг хүн дээр битгий шэйрл. Тэрийг шууд блокло.

Өөрийнхөө хүүхдийг хайрладаг, ерөөлийн хүүхдийг хайрладаггүй хүн байж таарахгүй. Хүн болгоны хайр сэтгэл. Үнэн хайр бол чимээгүй байдаг юм шүү. Ер нь бол. Сенсацтай байдаггүй юм. Үнэн хайр бол чив чимээгүй байдаг юм шүү гэдгийг би бүх ард иргэддээ хандаж нэгдүгээрт хэлмээр байгаа юм.

Хоёрдугаарт, Улсын Их Хуралд өнгөрсөн оны хавар Засгийн газраас Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулаад бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийн ялын бодлогыг чангатгах чиглэлд гурван бодлого өргөн барьчихсан байгаа. Үүнийг батлах шаардлагатай.

Нэгдүгээрт, бага насны хүүхдийг хүчиндсэн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд өршөөл уучлал үзүүлэхгүй, магадлангаар суллахгүй гэдэг хуулийн төсөл Улсын Их Хуралд өргөн баригдчихсан байгаа. Үүнийг ерөөсөө шууд баталъя. Шууд баталъя.

Нөгөө талаар бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бэлгийн мөлжлөг үйлдэх гэмт хэрэг байгаа. Энэ дотор торгох ял одоо орчин төгөлдөр, үйлчлэлд байгаа заалт байгаа.

Энэ торгох ял байхгүйгээр шууд хорих ялаар солих хуулийн төсөл Засгийн газраас өнгөрсөн онд өргөн баригдчихсан байгаа. Үүнийг шууд баталъя. Үүнийг шууд баталъя.

Цаашид нэлээн олон асуудлууд яригдана. Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мөрдөн шалгах үйл ажиллагааг нууц задруулж байгаа асуудал дээр.../минут дуусав/

Г.Занданшатар:

Даваажанцангийн Сарангэрэл гишүүн тодруулж асууна. 1 минут.

Д.Сарангэрэл:

Энэ хүчирхийлэгчид оногдуулах ялын бодлогоо тодорхойлох, чангатгахдаа олон улсын туршлагыг манай хууль хяналтын байгууллага нэлээн сайн судлаасай гэсэн ийм хүсэлтэй байна.

Өнөөдөр бидний хэн нэгний хүүхэд өртчихсэн бол энд үг хэлээд сууж байх нь битгий хэл амьсгаа ч авч чадахгүй ийм л хүнд байдалтай байгаа. Өнөөдөр тэр хөөрхий хүүхдийн ээжийн талаар хэлэх ч үг алга. Нийгэм тэр чигээрээ донсолж байна шүү дээ.

Тийм учраас ялын бодлогыг чангатгана гэдэг дээр эмэгтэй гишүүд бид байр сууриа хатуу хамгаалах болно. Үүнийг хойш нь тавихгүй ээ.

Түүнээс гадна С.Одонтуяа гишүүний дахин дахин хэлээд байгаа эмэгтэйчүүд бидний 2021 онд өргөн барьсан Хүүхэд хамгааллын тухай хуулийг яаралтай журмаар оруулж ирж хэлэлцүүлж өгөөсэй гэж Улсын Их Хурлын даргаас мөн хүсэж байна.

Өнгөрсөн хугацаанд бид гар хумхиж суугагүй. Бодлого

тодорхойлогчийнхоо хувьд олон асуудлыг энэ хүүхэд хамгаалах чиглэлд хийж хэрэгжүүлсэн. Харамсалтай нь ажил хэрэг болохгүй байгаа талаар энд Улсын Их Хурлын гишүүдийн хэлж байгаа.../минут дуусав/

Г.Занданшатар: Хүүхэд хамгааллын тухай хуулиа хэлэлцээч гэж С.Одонтуяа гишүүн ч гэсэн, бид ч гэсэн зө зөндөө олон удаа шаардсан. С.Одонтуяа гишүүн энэ хуулийг санаачилсан.

2021 онд нэмэлт өөрчлөлт оруулсан шүү дээ. Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлтүүд оруулсан юм билээ.

Засгийн газраас өргөн барина гээд тухайн үед Х.Булгантуяа гишүүн, С.Одонтуяа гишүүн нар санаачилсан хууль юм билээ.

Х.Булгантуяа гишүүнээс шинэ сайд болсон юм чинь эмэгтэй гишүүд бүгд гарын үсэг зурсан. С.Одонтуяа гишүүний бичиг баримттай юу байна лээ.

Тэгээд С.Одонтуяа гишүүний тэрийг харин Засгийн газраас өргөн барьж нэгтгэж хэлэлцэнэ гээд гацаачихсан. Тэрийгээ яаравчлах хэрэгтэй. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн.

Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн хүүхдийн эрх зөрчигдсөн сонсгол хийх дэгээр сонсгол зохион байгуулах санал гаргасан. Ажлын тав хоногийн дотор хуралд шийдвэрлэх ёстой байгаа шүү. Байнгын хороо.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр Монгол Улсын Үндсэн хуулийн 16.11-д гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална гэж заасан байгаа.

Тэгэхээр гэр бүл, хүүхдийн эрх ашиг угаасаа бүх төрийн ивээлд байх ёстой ийм ноцтой асуудал байдаг. Сүүлийн өдрүүдэд. Ер нь сүүлийн жилүүдэд хүүхдийн эрх зөрчигдсөн хүүхэд хамгааллын асуудлууд хэрэгжиж чадаагүй. Хүүхэд ерөөсөө гэр сургуулийн хоорондох замд, гэр бүл дотроо гэр бүлийн орчинд хараа хяналтгүй үлдэж гал усны болон бусад осол эндлээр нас барах тохиолдол нэмэгдлээ.

Тэгээд хүүхдүүд алга болох, зүгээр сургуулийнхаа явах замдаа гарцан дээр дайруулж амь насаа алдаж байгаа асуудал үнэхээр Монгол хүн бүр сэтгэлийг эмзэглүүлж байна. Бид хүүхэд хамгааллын хуулиуд холбогдох бусад бүх хуульдаа дахин эргэн харж шаардлагатай зохицуулалтуудыг чангатгах, дутуу үлдээсэн зүйлийг оруулах шаардлагатай байна.

Жишээлбэл, миний хувьд Хүний эрхийн дэд хорооны даргын хувьд сүүлийн өдрүүдэд Дорноговьд алга болсон охины асуудлаар улс орнуудын хууль тогтоомж, хүүхэд алга болсон тухайд ямар процедур нарийн журам байдаг гэдгийг нэлээн судалж холбогдох иргэний нийгмийн байгууллагууд, ажилтнуудын саналыг авч байна.

Тэгэхээр ер нь хүүхэд алга болгох асуудал асар нарийн бөгөөд цаг хугацаа бүрээр хүүхдийн амь нас хэмжигддэг ноцтой асуудал учраас улс орнууд бүр тусгайлсан хуультай байна. Тухайлбал, Солонгос Цлсад сураггүй болсон хүүхэд, алга болсон хүүхдийг хамгаалах, дэмжих тухай хууль гэж хууль байна. Энэ хуулиар хүүхдийг эрэн сурвалжлах, мэдээлэл өгөх, бүх холбогдох байгууллагууд, тээврийн хэрэгсэл, тухайн хот, дүүрэг, тосгоны газрууд, цагдаагийн

байгууллагад бүх асуудлыг нарийн журамласан байна.

Тэгээд энэ дотроо ялангуяа эхний 24-өөс 48 цаг бол айхтар нарийн журмаар зохицуулагдаж, энэ болгонд мэдээллээ хэрхэн дамжуулах вэ, холбогдох цагдаагийн байгууллага болон тухайн эрэн сурвалжилж байгаа бүс нутаг дахь төрийн байгууллагуудын бүх л зүйлийг нарийн зохицуулсан байна.

Гэтэл манайд ийм нарийн зохицуулалт Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон бусад хуульд алга байна.

Тийм учраас миний хувьд Цагдаагийн ерөнхий газрын төлөөллөөс нэг асуулт байна.

Манайд 1990 оноос хойш хүүхэд алга болох асуудлаар нэлээн мэдээллүүд цагдаагийн баримтуудад байна. Нийтдээ бараг 10 мянга гаруй хүүхдийг цагдаагийн байгууллага олж эцэг, эхэд нь хүлээлгэж өгсөн байдаг юм байна. Гэхдээ өдийг хүртэл 14 хүүхэд огт сураггүй алга болсон, олдоогүй гэсэн мэдээлэл байна.

Ер нь манай цагдаагийн хэрэг бүртгэлт, мөрдөн байцаах шатанд насанд хүрээгүй хүүхдийг эрэн сурвалжлах асуудлаар тусгайлсан журам байдаг уу?

Бусад улс орнуудын нарийн зохицуулалт шиг, эсвэл гэмт хэргийн ерөнхий зарчмаараа явж байна уу? Насанд хүрээгүй хүүхдийн асуудал, ялангуяа хулгайлагдсан тохиолдолд энэ их ноцтой эмзэг асуудал байна.

Тэгэхээр энэ тал дээр нарийн журам, процесс байна уу? Хэрэв байхгүй бол бид Эрүүгийн тодорхой хуулиуддаа өөрт оруулья гэдгийг Цагдаагийн

ерөнхий газрын төлөөлөгчөөс асуумаар байна.

Хоёрдугаарт нь, Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд хяналт тавьж, хүний эрх, эрх чөлөөг хангах, дэмжих үүрэг бүхий манай хараат бус үндэсний байгууллага болох Хүний эрхийн комиссын үйл ажиллагаанаас асуулт асуумаар байна.

Ер нь Хүүхдийн эрхийг хамгаалах тухай асуудлаар Хүний эрхийн Үндэсний Комиссын жил бүрийн хүний эрхийн тайланд удаа дараа хангалттай мэдээллүүд, тайлан, зөвлөмжүүд гардаг.

Тэгээд холбогдох байгууллага орон нутаг руу тодорхой зөвлөмжүүд өгсөн байдаг.

Тэгээд жишээлбэл 2020 оны 10 сараас 2022 оныг дуустал нийт 17 зөвлөмжийг зөвхөн хүүхдийн эрхтэй холбоотой өгсөн байдаг юм. Эдгээр зөвлөмжөөс тодорхой хэсэг нь хэрэгжээгүй, 70 орчим хувь нь хэрэгжих шатдаа байгаа гэх мэт ийм тайлан байна.

Тэгэхээр яг хүүхдийн эрхтэй холбоотой цаашид энэ зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд ямар төрийн дэмжлэг хэрэгтэй байх вэ? Яагаад тодорхой албан байгууллагууд хүний.../минут дуусав/

Г.Занданшатар: Цагдаагийн ерөнхий газар. 95.

Г.Мөнхбаяр: Эрхэм гишүүд Та бүхний энэ өдрийн амрыг эрэн мэндчилье.

Цагдаагийн ерөнхий газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Г.Мөнхбаяр байна.

Тэгэхээр цагдаагийн байгууллагаас сүүлийн 10 жилийн хугацаанд, сая хэллээ. 10 мянга гаруй хүүхэд эрэн сурвалжлагдаж, олж ар гэрт нь хүлээлгэж өгсөн ажиллагаа байгаа.

1996-2022 оны хооронд нийт 16 хүүхэд сураггүй алга болсон. Гэмт хэргийн улмаас алга болсон байж болзошгүй 2 байгаа. Энэ нь Сэлэнгэ аймаг, Дорноговь аймагт тухайн 2 хэрэг бүртгэгдсэн байдаг.

Ингээд 14 хүүхэд нь ямар байдлаар эрэн сурвалжилж байгаа вэ гэхээр ахуйн ослын улмаас усанд осолдох, ой модонд төөрөх гэх мэтчилэн 14 хүүхэд дээр алга болсныг эрэн сурвалжлах ажиллагааг цагдаагийн байгууллагаас тасралтгүй зохион явуулж байна.

Мөн эрэн сурвалжлах тусгай журам байдаг уу гэж асуулаа.

Тэгэхээр Цагдаагийн ерөнхий газрын даргын баталсан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам гэж байдаг. Энэ журам дээр эрэн сурвалжлах ажиллагааны нарийн зохицуулалтыг заасан байгаа.

Бага насны хүүхдүүд дээр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагаас дуудлага мэдээллийг цагдаагийн байгууллагад бүртгэгдсэн нэн даруйд бусад нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын хэмжээндээ зохион байгуулж ажилладаг.

Г.Занданшатар: Хүний эрхийн комисс Ж.Хунан дарга. 80.

Ж.Хунан: Ц.Мөнхцэцэг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр өнөөдөр хүүхдийн эрхийн асуудлыг Улсын Их Хурлаар хэлэлцэж байгаад баяртай байна. Маш чухал асуудал.

Хүний эрхийн Үндэсний Комисс энэ дээр тогтмол анхаарал хандуулж ирж байсан.

Өнгөрсөн хугацаанд 22 хүний эрх, эрх чөлөөний талаарх илтгэлийг Улсын Их Хуралд өргөн барьснаас 15-д нь хүүхдийн эрхийн асуудлыг тусгайлан тусгаж оруулж байсан.

Хүүхдийн эрхтэй холбоотой Монгол Улсын дотоодын механизмаас гадна олон улсын механизмаас л тодорхой зөвлөмж шаардлагуудыг өгсөн байдаг. Жишээлбэл, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийг хийж, 36 дугаар чуулганаар Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний III илтгэлээр гарсан зөвлөмжийг хүргүүлсэн.

Энд 190 зөвлөмж өгснөөс 170-ыг нь Монгол Улс хүлээж авсан. Эдгээр 170-аас 55 нь цэвэр хүүхдийн эрхтэй холбоотой, хүүхэд хамгаалалттай холбоотой зөвлөмж байдаг.

Энэхүү зөвлөмжийг хэдийгээр 2021 онд Монгол Улсад өгсөн ч өнөөдрийг хүртэл эдгээр зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх төлөвлөгөө албажиж гараагүй нөхцөл байдалтай байгааг дуулгах нь зүйтэй.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос сүүлийн 3 жил буюу шинэ бүрэлдэхүүн томилогдсоноос хойш хүүхдийн эрхийн асуудлыг 3 илтгэлдээ тусгайлан бүлэг болгож оруулсан.

Хүүхдийн эрхийн тодорхой асуудлуудыг хөндөж ажилласан байгаа.

Хамгийн эхэнд энэ КОВИД-ын үе дэх хүүхдийн эрхийн асуудлыг хөндөж тодорхой саналуудыг гаргаж шийдвэрлүүлж байсан.

Дараа нь 21 дэх илтгэл дээр хүчирхийллээс ангид байх эрхийн хүрээнд хүүхэд хамгааллын үндсэн бүтэц болох хамтарсан баг, нэг цэгийн үйлчилгээний төв, хамгаалах байрны үйл ажиллагаанд хяналт, шинжилгээг хийж үр дүнг Улсын Их Хуралд танилцуулж холбогдох шийдвэрүүдийг гаргуулж ажилласан.

22 дахь илтгэлдээ Хүний эрхийн Үндэсний Комисс хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны үйл ажиллагаа болон дотуур байран дахь хүүхдийн эрхийн асуудлыг хөндөж тусгасан байдаг.

Энэ хүрээнд Улсын Их Хурлаас тогтоолууд гарсан. 20 дахь илтгэлийг хэлэлцээд 67 дугаар тогтоол гарсан байдаг. 21 дэх илтгэлийг хэлэлцээд Улсын Их Хурлын 49 дүгээр тогтоол гарсан байдаг.

22 дахь илтгэлийг хэлэлцээд 35 дугаар тогтоол гарч Засгийн газарт тодорхой үүрэг даалгавар чиглэлийг өгүүлсэн байдаг.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос өгч байгаа хүүхдийн эрхийн зөрчилтэй холбоотой, хүүхдийн эрхийг хангах, хамгаалахтай холбоотой зөвлөмжийн хэрэгжилт төдийлөн хангалттай гэж хэлэхэд хэцүү. Энд тодорхой шалтгаанууд байна гэж харж байгаа.

Нэгд гэвэл, энэ хүүхдийн эрхийг бүрэн дүүрэн хамгаалах, хүүхдийн эрх

зөрчигдөхгүй байх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай хөрөнгө, төсөв тавигддаггүй юм байна. Энэ нь хүрэлцдэггүй юм байна. Ялангуяа орон нутагт, ялангуяа энэ бүтэц, энэ аюулгүй байдлыг хангах орчныг бүрдүүлэх тал дээр хөрөнгө оруулалт төдийлөн хийгдэхгүй, байгаа нэг нь хүүхдийн эрхийн мэдрэмжгүй, хүний эрхийн мэдрэмжгүй асуудлууд байна.

Дараагийн асуудал, хүүхэд хамгааллын үйлчилгээ үзүүлж байгаа энэ боловсон хүчин, хүний нөөцийн асуудал үнэхээр учир дутагдалтай байна. Ялангуяа орон нутагт.

Түрүүн Ц.Идэрбат гишүүн яг бодит нөхцөл байдлыг хэлж байна.

Хэдийгээр жижиг асуудал гэж байгаа боловч үнэхээр орон нутагт нөхцөл байдал тийм байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн судалгаагаар хамтарсан багийн үйл ажиллагааг хариуцдаг нийгмийн ажилтны манай судалгаанд хамрагдсан 62 хувь нь мэргэжлийн бус байгаа юм.

Өөрөөр хэлбэл мэргэжлийн бус хүн байна гэдэг бол тэр хүүхэд хамгааллын онцлог, хэрэгцээ шаардлага, мөн чанарыг бүрэн гүйцэд ойлгоогүй.../минут дуусав/

Г.Занданшатар: Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан хариулья.

Л.Энх-Амгалан: Бид нэг зүйлийг нийгмээрээ их зөв ойлгомоор байна.

Одоо ингээд ниргэсэн хойно нь хашхирав гэдэг шиг ийм байдлаар. Тэгээд ганц хоёр өдрийн сенсац болоод ийм

загасны ой санамжтай баймааргүй байгаа юм.

Тэгээд сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөж байгаа асуудал байгаа. Тэрийг би нуухгүй. Гэхдээ бүх бурууг сургууль руу, бүх бурууг багш нар луу чихдэг.

Тэгээд багш нар, сурган хүмүүжүүлэгч нар хүчирхийлэгч болчихсон, эсвэл хамгийн хүүхдийн эрхийн мэдрэмжгүй болчихсон юм шиг нэг ийм ойлголтыг нийгэмд төрүүлж болохгүй ээ. Үүнийг би бүр хатуу хэлж анхааруулья гэж бодож байгаа.

Тэгээд ер нь сая Х.Булгантуяа сайдын хийж байгаа энэ мэдээлэл дээр байж байна шүү дээ. Нийгэмд гарч байгаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн 70 гаруй хувь нь гэр бүлийн орчинд, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдийн зүгээс үйлдэгдсэн байна гэж. 70 хувь.

Тэгэхээр үнэхээр сургуулийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөөд байна уу, гэр бүлийн орчинд хүүхдийн эрх зөрчигдөөд байна уу гэдэг асуудлуудыг бид зөв үнэлж цэглэмээр байгаа юм.

Тэгээд нэг үхрийн эвэр доргихоор мянган үхрийн эвэр доргино гэдэг шиг ингээд бүгдийг сургууль руу, бүгдийг багш нар луу, тэгээд сургуулийн орчинд дандаа хүүхдийн эрх зөрчигддөг нэг ийм ойлголт ерөөсөө байж болохгүй.

Одоо энэ Хүний эрхийн комиссын Ж.Хунан дарга сууж байна. Ер нь Ж.Хунан дарга аа, бид хамтарч энэ багш нарын эрх ер нь яаж зөрчигдөж байгаа юм, эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс энэ дарамтаас болж яаж зөрчигдөж байгаа юм гэдгийг. Үүнийг бид ер нь авч үзэх ийм бодитой нөхцөл байдал Монгол Улсад үүсчихсэн байна шүү.

Одоо сая Солонгост хэд хэдэн багш нарын амиа хорлосон асуудлуудаас маш том жагсаал цуглаан болж, багш нарын эрхийг хамгаалах хуультай болж байна шүү дээ. Солонгос Улс.

Яг түүнтэй адилхнаар өнөөдөр энэ боловсролын салбарт үүсэж байгаа багш нар дээр маш их ачаалал байдаг. Дахиад дээрээс нь эцэг эх, асран хамгаалагчдын зүгээс маш их тийм сэтгэл санааны дарамт үзүүлдэг, доромжилдог ийм нөхцөл байдал үүсчихсэн байна. Үүнээс болж багш нар хичээлийн ачааллаас гадна сэтгэл зүйн дарамтад орж байгаа, стресстэж байгаа, бухимдаж байгаа ийм бодитой зөрчил дутагдлууд их гарч байна.

Тэгэхээр үүнийг зайлшгүйгээр харж үзэх ёстой. Харин ч Ц.Мөнхцэцэг гишүүн их зөв өнцгөөс нь харж энэ асуудлуудыг хөндлөө.

Тэгээд өчигдөр бид Монголын болон дэлхийн багш нарын баярын өдөр болсон. Энэ баярын өдөр багш нарын эрхийг хамгаалах ийм өдөр байх ёстой гэж бодож байгаа.

Ганцхан өдөр багш, сурган хүмүүжүүлэгчдийн эрхийг хамгаалчихдаг биш ер нь 364 хоногт багш нарын эрхийг хамгаалах энэ асуудал дээр бид үүссэн энэ нөхцөл байдал дээр тодорхой дүгнэлт хийж байж тодорхой шийдлүүд нийгмээрээ гарах ёстой юм байна гэж л би хэлэхийг хүсэж байна. Тийм.

Г.Занданшатар: Бямбасүрэнгийн Энх-Амгалан гишүүн. Алга байна. Хаслаа. Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Өнөөдөр хүүхэд хамгааллын цаг үеийн чухал асуудлыг хэлэлцэж байна.

Би асуулт асуухгүй. Зүгээр үг хэлье гэж бодож байна. Ерөөсөө л энэ асуудлын үндсэн шалтгаан нийгмийн асуудал байгаа юм. Бид нийгмийн асуудлыг ер нь цогцоор нь авч үзэхгүйгээр дан хууль эрх зүйн орчныг нь шийдээд байвал энэ асуудлын ард ерөөсөө гарахгүй. Бид нийгмийн асуудлыг нь шийдэх ийм зайлшгүй шаардлага байгаа юм.

Үндсэн гурван шалтгаантай л даа. Энэ гурван шалтгааныг нь бүх л хүн ярьж байгаа.

Нэгдүгээрт нь, гэр бүл салалт бол үүний хамгийн үндсэн нэг шалтгаан болж байгаа.

Монгол Улс чинь жилд гэр бүл салалт сүүлийн жилд чинь 3-аас 4 дахин нэмэгдэж байна гээд байгаа шүү дээ. Сүүлийн 3 жил гэр бүл болсон залуучуудын 50 орчим хувь нь салж байна гээд байгаа шүү дээ.

Тэгэхээр гэр бүлийн салалт үндсэндээ үүний суурь асуудал нь болж байгаа байхгүй юу.

Хоёрдугаарт, архидалт. Түрүүн хэд хэдэн гишүүн хэлж байна лээ. Гэр бүлээрээ архичин болоод байгаа байхгүй юу. Энэ тэгээд нийгмийн асуудал.

Гуравдугаарт нь, хүүхдэдээ тавих анхаарал халамж муу.

Энэ гурван үндсэн шалтгааны улмаас л энэ хүүхэд хамгааллын асуудал гарч ирээд байгаа юм.

Би гурван санал хэлье гэж бодож байна.

Нэгдүгээрт нь, хууль эрх зүйн орчны хувьд нь сайжруулах шаардлага байгаа. Эрүүгийн хуулийн асуудал гарч ирж байна. Чангатгах ёстой гэдэг дээр сая Хууль зүйн сайд тодорхой санал хэлж байна.

Хоёрт, нь хамгийн чухал юм манай Б.Энхбаяр сайд анхаарна биз. Энэ Гэр бүлийн хуулийг. Бид гэр бүлийн хуулийг өнгөрсөн парламентад ярьж байгаад орхиод буцаагаад татаад аваад явчихсан байхгүй юу. Засгийн газар.

Тэгэхээр Засгийн газар ойрын үед энэ Гэр бүлийн хуулийг гаргах ёстой юм. Үндсэн нийгмийн суурь болсон үндсэн хууль нь гараагүй байгаа байхгүй юу.

Тийм учраас Гэр бүлийн хуулийг Засгийн газар яаралтай бэлтгээд ойрын үед нэг оруулж хэлэлцүүлмээр байгаа юм.

Гурав дахь асуудал. Энэ гаж донтнуудыг яах вэ гэдэг асуудлыг бодмоор байгаа юм. Энэ дээр тусгайлсан арга хэмжээ авах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх чиглэлээр Хууль зүйн яам анхаарах шаардлага байгаа юм.

Ийм гурван асуудал дээр би хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгох чиглэлээр анхаарах хэрэгтэй гэж бодож байна.

Энэ нийгмийн асуудал учраас бид нийгмийн хүрээнд энэ хоёр том асуудлыг шийдэх ёстой юм.

Нэгдүгээрт нь, өрхийн тэргүүн эрчүүдээ бэлтгэх хэрэгтэй байгаа юм. Өрхийн тэргүүн эрчүүдээ бэлтгэх хэрэгтэй байгаа юм.

Гэр бүлээ аваад явчих чадавхтай, сэтгэлийн тэнхээтэй, амьдралын зорилго, мөрөөдөлтэй ийм залуучуудыг бэлдэх хэрэгтэй байхгүй юу.

Нөгөө талаас нь хоёр дахь юм нь эхчүүдээ бэлдэх хэрэгтэй байгаа юм. Эхчүүдээ. Нийгмийн суурь асуудлуудаа бид шийдэхгүйгээр хүүхэд хамгааллын асуудлыг бид шийдэж огт ч чадахгүй.

Гурав дахь том асуудал бол энэ орлоготой холбоотой асуудал байгаа юм. Нийгмийн асуудал. Орлоготой нь холбоотой. Ажилтай байлгах, орлогыг нь нэмэгдүүлэх энэ чиглэлийн асуудал байгаад байгаа юм. Орлогогүй учраас л өөр асуудал руу ингээд яваад байгаа юм.

Ийм гурван том асуудлыг бид шийдэх ёстой.

Тийм учраас эрх зүйн хүрээний асуудлаа шийдэх ёстой. Нийгмийн үндсэн шалтгаан болоод байгаа орлогыг нь яаж нэмэгдүүлэх вэ гэдэг дээр анхаарах ёстой.

Гурав дахь нь, хүнээ бэлтгэх хэрэгтэй байгаа юм. Эрчүүдээ, өрхийн тэргүүнээ, эрчүүдээ, эхчүүдээ бэлтгэж хүүхэд хамгааллынхаа асуудалд ингэж цогцоор нь авч үзэх юм бол бид цаашдаа том дэвшил гаргана гэж бодож байгаа.

Энэ асуудал мэдээж нэг, хоёр жилдээ шийдэгдэж чадахгүй нь ойлгомжтой. Урт удаан хугацааны бодлого гаргаж хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа юм.

Тийм учраас Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам цаашдаа ийм асуудал дээр анхаарах шаардлага байна гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал хэллээ. Тийм ээ.

Дашдондогийн Ганбат гишүүн.

Д.Ганбат: Надад минут энэ тэр байвал ахиухан шиг өгчхөөрэй.

Засгийн газраа төлөөлөөд манай Х.Булгантуяа сайд ланжгар илтгэл тавилаа л даа.

Тэгээд бид одоо яг ниргэсэн хойно нь хашхирав гээд Боловсролын сайд хэлж байгаа нь яг үнэн. Ниргэсэн хойно нь хашхирч байна.

Өнгөрсөн борооны хойноос эсгий нөмрөв гэдэг л үлгэр болж байна шүү дээ. Өнөөдөр одоо яг бид нарын ингээд яриад хэлэлцээд сууж байх энэ цаг хугацаанд 12 настай эмэгтэй хүүхэд яасан нь мэдэгдэхгүй байж байна. Гэмт этгээдүүдийн гарт орчихсон.

Одоо 72, одоо хэдэн цаг юм? Бид бараг тэр цагийг энд байршуулчих хэрэгтэй байхгүй юу. Тэдэн минут явж байна, тэдэн секунд явж байна гээд.

Ингэж хариуцлагатай хандах ёстой. Бараг дараагийнхаа өдрийн хоног хугацаандаа ороод ингээд явчихлаа. Тэгээд энэ хүүхдийн амьд байх, олдох магадлал улам багасаж байна.

Яг өмнө нь энэ аймгаас, энэ газраас бас Сэржмядаг гээд. Би хэвлэл мэдээлэл дээр нэрийг нь тавьчихсан болохоор хэлж байгаа шүү. Ийм охин алга болсон.

Тэгээд яг үүний дараа бас баахан камер тавьсан юм шиг байгаа юм. Мөнгө төгрөг зарж. Тэгээд тэр камер нь ажиллагаагүй. Энэ чинь юу хэлээд байна вэ гэвэл энэ улс орон авлигад

идэгдчихсэн, хариуцлага хүлээх хүн байхгүй ийм л байдалтай байгаагийн шинж байхгүй юу.

Бид нарт ч сайн үлгэр дуурайлал бий л дээ. Танайхан дотор. Би өнөөгийн Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Ерөнхийлөгчийг хэлмээр байгаа юм. Жирэмсэн эмэгтэй тапочитай гарч ирлээ гээд л огцорч байсан шүү дээ. Засгийн газар.

Ингэж ёс суртахууны хариуцлага хүлээж байсан болохоор дараа нь ард түмэн Ерөнхийлөгчид хүртэл дэмжиж байна шүү дээ.

Тэгэхээр өнөөдөр шир царайлаад. Тэр охин алга болчихсон байхад бид энд томилгоо яриад сууж байгаа байхгүй юу.

Би тэр томилгоонд нь ирж оролцоо ч үгүй л дээ. Аягүй муухай санагдаж байгаа байхгүй юу. Энэ ард түмэн хараад сууж байхад. Тэр нь ч сайд болно, энэ нь ч сайд болно гээд.

Тэгэхээр манай Удирдах зөвлөл нь албан тушаал тэнд яриад сууж байхаас биш энэ ард түмний амьдрал, хүүхдийн эрхийг хамгааллыг ярьж байсан удаа байхгүй. Ярих ч үгүй.

Тэгэхээр 8 жил болчихоод, 3 жил болчихоод энэ хууль эрх зүйн орчныг сайжруулж чадаагүй энэ Улсын Их Хурал бараг тарсан нь дээр дээ.

Дараагийнхаа Сонгуулийн хуулийг бэлдчихсэн юм чинь түүгээр нь явуулаад шийдэх ёстой.

Намуудыг ч гэсэн дахин бүртгэл хийлгэх хэрэгтэй. Монгол Ардын нам тарвал таарна даа. Дагуул болсон бид ч гэсэн. Аан. Энэ охин нам нь ч гэсэн.

Ингэж байж л хариуцлага ярина шүү. 1 минутаа нэмээд өгчхөөрэй.

Г.Занданшатар: Хариулт хангалтгүй бол хариултын дараа.

Ер нь Боловсрол, шинжлэх ухааны сайд юу яриад байна аа.

Хүүхдүүд үхэж байхад дуугүй байж байх ёстой юм уу. Ниргэсэн хойно хашхирав гэж юу яриад байгаа юм.

Ард түмний төлөөлөгчдийн байгууллага дотоод, гадаад ямар ч асуудлаар асуудал ярих ёстой.

Хүүхдүүд үхээд байна. Эцэг хүний хувьд ч гэсэн тэр, эх хүний хувьд ч гэсэн төлөөлөгчдийн байгууллага ард түмэн шаардаж байна.

Хүүхэд үхэж байхад дуугүй байж байх ёстой юм уу. Тэгээд бие бие рүүгээ буруугаа чихээд л. Энэ чинь хаана хаанаа ажил чинь болохгүй байна. Харанга дэлдэж байна.

Тогмидын Доржханд гишүүн асуулт асууна. Санал хэлчихсэн. Тэгээд шал ондоо юм яриад явчихсан. Та.

Нам, улс төр яриад явчихсан. Хүүхдийг үхлээр улс төр хийж хэрэггүй ээ.

Одоо зүгээр бие бие рүүгээ чихдэг, түлхдэг, аль эсвэл улс төрждөг цаг биш.

Хүүхдийн асуудал ариун асуудал бөгөөд үүнийг бодлого, шийдэл гаргаж ярих хэрэгтэй. Хууль, эрх зүй ярих ёстой.

Тогмидын Доржханд гишүүн.

Хариулт байхгүй юм чинь ямар юмны 1 минут. Битгий улстөржөөд бай.

Т.Доржханд: Тэгэхээр маш харамсалтай хэрэг явдал болж байгаа, болсоор байсан.

Тэгээд одоо бид энэ дээр олон улсын туршлага нь юу юм бэ гэдгийг нэлээн олон хүмүүс мэдээлэл өгөөд байна л даа. Тэгээд тэрийг би та бүгдэд нэг анхааруулаад. Тэгээд зарим хууль хүчний байгууллагууд нь ажил болгоод явчхаасай гэж хүсэж байгаа юм.

Энэ Англи, Америк, Канад, Израиль, Швед улсуудад гэмт хэргийн хохирогч болсон хүний нэрээр нэрлэсэн хуулиуд байдаг гэж.

Энэ нь тухайн хэргийг мартуулахгүй байх, хохирогчийн дурсгалыг хүндэтгэх, дахин ийм хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх зорилготой байдаг гээд. Тухайлбал, 1994 онд **Меган Канка** /Megan Nicole Kanka/ гэх бага насны охиныг хулгайлсан, хүчиндсэн, улмаар амь насанд нь хүрсэн.

Ийм хэрэг дахин гаргуулахгүйн тулд Меганы хуулийг баталсан.

Тэгээд энэ хуулийн үр дүнд маш олон хүүхдийн амь насыг аварсан. Яагаад вэ гэхээр мэдээллийг нь ил тавьдаг болсон. Үр дүнд нь эцэг эх, олон нийт, ойр орчны хүмүүсийн анхааралд оруулдаг, урьдчилан сэргийлж чаддаг болсон гээд.

Тэгэхээр хохирогчийн нэрээр нэрлээд явсан ийм жишээнүүд үр дүнтэй гэж. Үүнийг манай Хууль зүйн сайд анхааралдаа авна биз.

Мөн Америкийн Нэгдсэн Улсад **Амбер** /Amber Hagerman/ гэдэг охин алга болсон. Маш харамсалтайгаар.

Тэгээд **“AMBER alert”** буюу **“Амберын сэрэмжлүүлэг”** гэдэг ийм хууль батлагдсан. Онцлог нь юу вэ гэхээр тухайн орон зайд хүүхэд алга болсон мэдээлэл ирсэн даруйд тэр сэрэмжлүүлэг нь ажиллаад тухайн орчны хүмүүсийн гар утсан дээр нь шууд хүүхдийнх нь зураг болон холбогдох мэдээллүүд ирдэг гээд.

Ингэснээрээ маш богино хугацаанд үр дүнтэй ажиллаж чадсан байдаг юм гээд.

Тэгэхээр **“AMBER alert”**-ийг бид илүү бодит ажил болгох хэрэгтэй байна.

Бас энэ хэвлэл мэдээлэлтэй холбоотойгоор. Тухайлбал, Япон Улсын жишээ байна. Япон Улсад хэвлэл мэдээлэл нь аливаа гэмт хэргийг бүгдийг нь маш дэлгэрэнгүйгээр мэдээлдэг.

Ганцхан тохиолдолд тэрийг мэдээлдэггүй. Тэр нь юу вэ гэхээр хүн барьцаалагдсан, хүүхэд барьцаалагдсан тохиолдолд гээд.

Тэгэхээр жишээ нь 1960 онд гэмт этгээдүүд Токиогийн бага сургуулийн сурагч 7 настай хүүг барьцаалж гэрийнхнээс нь мөнгө шаардан, улмаар амь насанд нь хүрсэн хэрэг гарсан байдаг.

Баривчилсныхаа дараа гэмт этгээд хүүхдийн аминд хүрсэн шалтгааныхаа талаар бичсэн байгаа. Яасан бэ гэсэн чинь сонин хэвлэлээр өөрийнх нь мэдээлэл гараад, энэ хүүхэд барьцаалагдчихлаа гэсэн ийм мэдээлэл гараад ирэхээр тэр хүн өөрийн эрхгүй нөгөө хүүхдийн амь насыг нь хөнөөсөн юм гэдэг мэдүүлэг өгсөн байгаа юм.

Тэгэхээр өөрөө хариуцлага хүлээхгүйн тулд нөгөө хохирогчийг ингээд амь насыг нь бүрэлгэдэг хэрэг хэвлэл мэдээллээс шалтгаалж байна.

Дээрээс нь цаазын ялаас шалтгаалж байна. Цаазын ялыг хэрвээ баталчих юм бол би нэгэнт үхэх нь тодорхой юм чинь гээд эсрэгээрээ нөгөө хохирогчийгоо хөнөөчихдөг тохиолдол дэлхий даяар маш их байгаа.

Тэгээд ийм болохоор үүнийг зохицуулах хэрэгтэй байгаа юм. Зохицуулах хэрэгтэй байгаа юм. Энэ дээр түрүүчийн хэлдэг улс төржиж болохгүй. Богино хугацаанд шуугиад өнгөрдөг байж болохгүй.

Тэгэхээр үр дүнтэй байхын тулд ийм аргуудыг авах хэрэгтэй байна.

Тэгээд үүнтэй холбоотойгоор “Хүн бай” гээд. Та нар санаж байгаа манай залуучууд, ялангуяа **Ч.Ганжавхлан** гээд залуу олон улсын байгууллагад очиж мэдээллээ өгөөд тэгээд их үр дүнтэй ажиллаж байгаа ийм аян байгаа.

Энэ хүрээнд “**ИД ШИДИЙН ОРОН**” гээд хөтөлбөрүүд явж байна, байшингууд баригдаж байна, хувийн санаачилгаар явж байна. Үүнийг дэмжих боломж байгаа юу? Би үүнийг сайдаас нь асуучихмаар байх юм.

Тухайлбал, өнөөдөр Яармаг, өнөөдөр Нисэхэд гээд би сүүлийн 6 жил хүүхдүүдэд англи хэл зааж байгаа байхгүй юу. Хажуугаар нь хамгаалах ажил бас хийдэг юм.

Тэгээд үүнийг ингээд яг бодит ажил болгохын тулд хувийн сектортэйгээ орж ажилламаар байгаа юм. Энэ дээр нэг хариулт өгөөч. Х.Булгантуяа.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд.

Х.Булгантуяа: Т.Доржханд гишүүний хэлж байгаа саналууд маш зөв өө.

Тийм ч учраас өчигдөр Цагдаагийн ерөнхий газартай бид хамтран хэвлэлийн хурал хийхдээ хэлсэн. Гадаадад “**Sex Offender Registry**” гээд “**Хүчирхийлэл үйлдэгчдийн жагсаалт**” гээд.

Хэрвээ тэр хүмүүс бидний хүүхдийг хайрлахгүй хүчирхийлж чадаж байгаа бол тэр хүмүүсийн эрх бас хязгаарлагдах ёстой.

Одоо ингээд 10 жил шоронд суучхаад л гарч ирээд л дараагийн хэргээ үйлддэг хүмүүсийг нийгэмд мэдээлэхгүйгээр ил гаргаад байна гэдэг бол байж болшгүй гээд Америкт жишээлбэл энэ листийг гаргадаг.

Тэгээд өчигдөр би сошиал дээр тавьсан юм. Ингэж гаргах ёстой. Нэртэй устай нь, тэр битгий хэл ажлын газрын хаягтай нь, гэрийнх нь хаягтай нь. Өөрөөр хэлбэл, эцэг эхчүүд ээ, хүүхдүүд ээ, энэ хүнээс болгоомжлоорой гэж тавих ёстой гээд.

Тэгсэн чинь манайхан чинь одоо тэгээд энэ чинь хүний эрхийн асуудал юм биш үү гээд л зарим нь баахан шуугсан байна лээ.

Ер нь бид олон улсын энэ сайн туршлагауудыг хэрэгжүүлэх ёстой. Дугуйг шинээр нь хийх биш. Олон улсад туршигдсан хүүхэд хамгааллын тогтолцоо, арга барилуудыг яах ёстой гэдэгтэй санал нэг байна.

Бид Ч.Ганжавхлангийн төрийн бус байгууллагатй ер нь хамтарч ажилладаг. Нийгмийн нөлөөллийн ажил, үйл ажиллагаа хамтран зохион байгуулж бид хамтран ажилладаг.

Манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр үнэнийг хэлэхэд төрөөгүй хүүхдээс авхуулаад ахмад настан Монголын 3.4 сая бүхий л хүмүүсийн асуудал яригддаг.

Өнөөдөр бид хүүхдийн асуудал ярьж байгаа бол тун удахгүй хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудал, ахмад настны асуудал гээд бүх асуудлууд яригддаг.

Бид ялангуяа энэ чиглэлээр мэргэшсэн, тууштай ажилладаг, шинэ санал, санаачилгыг гаргаж ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудтай нээлттэй хамтран ажилладаг.

Тэгээд би бас энэ завшааныг ашиглан энэ чиглэлээр ажиллаж байгаа төрийн бус байгууллагуудтай бид хамтран ажиллах нь зүйтэй гэж бодож байгаа.

Ер нь үүнийг ганцхан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, төр засгийн ажил биш түрүүн хэлсэнчлэн нам үл харгалзан төр, төрийн бус байгууллагууд, хувийн хэвшил, иргэд, нийгэм бид бүгдээрээ хамтарч байж л энэ асуудалд нэлээн ахиц дэвшил гаргах юм билээ.

Тэгээд үүнтэй санал нэг байна. Т.Доржханд гишүүн ээ, дэмжиж ажиллах болно.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн тодруулж асууна. 1 минут.

Тэгэхээр бодит ажил байх хэрэгтэй л дээ. Тэгээд би зарим гишүүдтэй санал нэг байгаа. Энэ асуудал эмэгтэй гишүүдийн асуудал биш юм. Бүгдийнх нь асуудал. Нэг.

Хоёрдугаарт, ажил хийхийн тулд төсөв байх ёстой. Төсөв байхгүй ажил явахгүй. Гэтэл төсөв чинь 14.3 гээд өсөөд ороод ирсэн байна гээд. Гэтэл манай Хан-Уул дээр чинь хүүхэд хамгаалах 2 төв байсан хоёулаа байхгүй болчихсон.

Одоо би хүүхэд хөгжүүлэх чиглэлээр байшин барьж байгаа. Тэрийг авна гээд л ингээд явж л байна л даа. Болно болно. Гэхдээ төсвийнхөө асуудлыг шийдэх хэрэгтэй байна.

Одоо энэ 2024 оны төсөв дээр яг энэ асуудал дээрээ шийдэх хэрэгтэй.

Дээрээс нь зөвхөн байшингийн асуудал шийдмээргүй байгаа байхгүй юу. Хүүхэд хамгаалах төв гэдэг чинь хохирол үүссэний дараа бий болж байгаа процесс. Гэтэл наана нь урьдчилан сэргийлэх байдал дээр төсөв байна уу? Төсвөө та нар яг яаж харж байгаа юм. Энэ апп аа та нар яаж хэрэгжүүлэх юм?

Тэр “Хүн байя” гэдэг саяын сэрэмжлүүлгийг яг тийм байдлаар хийх юм бол хувийн сектор чинь ороод ирэх боломжтой юм билээ шүү дээ.

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн.

Х.Булгантуяа: Төсөв, боловсон хүчний хувьд үнэхээр хүнд байгаа нь үнэн.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос 21 дүгээр тайлан дээр манай салбарын боловсон хүчний асуудлаар тавьсан байна лээ.

Нийт манай боловсон хүчний 54 хувь нь 1-ээс 2 жил л ажиллаж байна. Цалин багатай, нийгмийн хамгийн хүнд хүчир зүйлтэй, хүчирхийлэл, гэмт хэрэг энэ бүх зүйлтэй нүүр тулаад, дээрээс нь нэмээд төсвийн багахан сая төгрөг хүрэхгүй цалингаар ажиллана гэхээр 1-ээс 2 жил ажиллаад л. Ихэнх нь залуухан эмэгтэйчүүд байдаг. Ингээд л тун удахгүй ажлаасаа гарчихдаг.

Тэгэхээр бид төрийн захиргааны албан хаагч гээд шаардлага өндөр тавьдаг. Дээд боловсролтой ийм тийм гээд.

Дээрээс нь нэмээд одоо байгаа манай 8 тэрбум төгрөгийн төсөв бол хүүхэд хамгаалалдаа түрүүн хэлсэнчлэн чадан ядан хүрдэг. Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан дээр байна лээ. Нийт хамтарсан багийн 60, 70 хувь нь л төсөвтэй байна. Үлдсэн нь төсөвгүй байна.

Орон нутаг уг нь Орон нутгийн хөгжлийн сангаас нэмж төсөв тавих ёстой байдаг. Тэгж сайн ажилладаг Засаг дарга нар байдаг. Тэгдэггүй ч Засаг дарга нар байдаг.

Камержуулалтуудыг гэхэд үүнийг орон нутаг уг нь өөрсдөө санхүүжилтээ.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Манай улсад хууль эрх зүй хангалттай байгаа даа.

Журам нь байгаа, хөтөлбөр нь байгаа, төлөвлөгөө нь байгаа, бүтэц, нэгж нь байгаа. Явж явж манай улс шиг ингэж

21 аймаг, 9 дүүрэг, 330 сумдаа нэгжтэй ийм сайн бүтэцтэй улс орон ховор л байх.

Одоо гагцхүү тэр ажил хариуцсан шат шатдаа байгаа улсуудынхаа ажлыг л хийлгэх хэрэгтэй шүү дээ. Ажилд нь хяналт тавих хэрэгтэй шүү дээ. Ажлаа л хийхгүй байна шүү дээ. Хариуцлага нь сул байна шүү дээ.

Тэгээд нэг кэйс гарахаар ингээд л улсаараа сандралдаад л яах вэ ийх вэ гээд л ингээд л явдаг. Хэзээ ямар асуудал гарахыг хэн ч мэдэхгүй шүү дээ. Тэр гарахаас урьдчилан сэргийлээд, төсөв мөнгийг нь сайжрууллаа, нэмлээ гээд байдаг тэр яг төсвүүд чинь хаанаа очоод байна аа?

Анхан шатанд тэр хороон дээр хамтарсан баг дээр төсөв байдаггүй шүү дээ. Өнөөдөр яг үнэнийг хэлэхэд бид ноднин хэмнэлтийн хуулиар хэт туйлшраад л 21 аймаг, 9 дүүргийнхээ Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн унааг бүгдийг нь байхгүй болгочихсон шүү дээ. Хөл дүүжлэх унаагүй л байж байгаа шүү дээ.

Өнөөдөр тэр Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс чинь унаагүй л явж байгаа шүү дээ.

Ажилчид нь тэр хороон дээр тэр дуудлага ирэхээр хармаанаасаа таксины мөнгөө гаргаад л өөрсдөө явж тэр хүүхдүүдийнхээ араас, эцэг эхчүүдийнхээ араас хөөцөлдөөд явж байгаа шүү дээ.

Тэгээд асуудалд хэт туйлшраад, асуудлынхаа гүнд орж мэддэггүй, анхан шат дээр нь ажиллаж мэддэггүй. Яг өнөөдрийг хэлэхэд энд ингээд л 76 гишүүн өөрсдөө жигтэйхэн цээж дэлдээд яриад байгаа боловч яг үнэнийг хэлэхэд та бүхэн өөр өөрийнхөө аймгийнхаа Гэр

бүл, хөгжлийн, дүүргийнхээ Гэр бүл, залуучуудын хөгжлийн хэлтэс дээр очоод үзээрэй. Төрийн албан хаагчтайгаа уулзаад үзээрэй. Тэр улсууд чинь өөдөөс чинь юу ярих нь вэ. Төсөв мөнгө л ярих юм байна лээ.

Яг үнэнийг хэлэхэд тэр нэмэгдүүлээд байгаа төсөв чинь тэр анхан шат дээрээ очихгүй байгаа шүү.

Үйл ажиллагааны зардалд нь нэг машинтай байлаа гэвэл бензин байхгүй. Тэгээд яаж бензингүй машинаар хаашаа явах юм. Өөрсдөө дуудагдаад явах юм уу гэдгээс авхуулаад ажил их байгаа юм билээ.

Тийм учраас яг энэ ажлынхаа гүн рүү орж энэ асуудлын гол нь хаана байна. Түүнээс бүх шатанд төсөв, төлөвлөгөө, хөтөлбөрүүд байгаа.

Бүх орон нутгийн удирдлагуудад үүрэгжүүлсэн үүрэг даалгавар байгаа. Үүнийгээ л хийхгүй байгаа юм. Орон нутгийн удирдлагуудын ажлыг бид дүгнэдэг. Харин хүүхдэд ямар ээлтэй орчин бүрдүүлсэн юм, яаж эрсдэлээс хамгаалсан юм гэдэг ажлыг нь дүгнэдэг ажлынхаа арга барилд өөрчлөлт оруулах хэрэгтэй шүү дээ.

Ард иргэдийнхээ, ирээдүй болсон хүүхэд, багачуудынхаа хөгжлийг хэрхэн хангасан удирдлага вэ, хүүхдүүдийнхээ аюулгүй байдлыг яаж хангасан удирдлага вэ гэдгээр нь ажлыг нь дүгнэдэг байх ёстой. Орлого, төсөв санхүү нь мэдээж дүгнэх л байх. Хүний хөгжлийг хэрхэн яаж хангаж ажилласан юм гэдгээр нь цаашдаа орон нутгийн удирдлагууд, шат шатад нь ажлыг нь дүгнэдэг байж энэ хүнээ гэсэн орон нутаг явах болов уу гэж бодож байгаа юм.

Тийм учраас төсөв, мөнгөнийнхээ асуудлыг Та бүхэн яриарай. Анхан шатан дээрээ байдаггүй юм билээ шүү.

Тийм учраас төсвийн хуваарилалтаа Та хэлээдхээч. Хаана, аль дүүргүүд дээр хэдэн төгрөгийн төсөв яг очоод байгаа юм. Хорооны хамтарсан баг дээр яг хэдэн төгрөгийн төсөв байдаг юм. Яг үүнийг гаргаад хэлээдхээч.

Хорооны хамтарсан багийн хурал дээр очоод сууж байсан Их Хурлын гишүүн байна уу, сайд нар байна уу, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамныхан байна уу?

Тийм учраас ажлынхаа гүнд орж ажиллах ёстой гэж би хувьдаа хэлэх гэж байна.

Түүнээс биш асуудал болохоор л ингэж бөөн юм болдог энэ байдал. Нөгөө хэдэн ээжүүд рүүгээ, эхчүүд рүүгээ, эмэгтэй гишүүд рүүгээ дайрдаг байдал цаашдаа ч байх болно. Ийм байдалтай байвал.

Тийм учраас энэ чинь эцэг, эхчүүдийн үүрэг роль гэж нэг юм байна шүү дээ. Тэр Гэр бүлийнхээ хууль дээр тэр хариуцлагыг нь чанга л даа.

Хүүхдээ хамгаалах, харж асрах үүрэг нь эцэг эхэд байгаа шүү дээ. Түүнээс биш энэ сая гаруй хүүхдүүдийн.../минут дуусав/

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд.

Х.Булгантуяа: Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаа үнэн.

Манай нийт төсөв нийслэлд 79 орчим хувь нь. Нийслэл, аймаг хоёр

нийлээд ерөнхийдөө 65 орчим хувийг 2022 оны төсвөөс авч байгаа.

Энэ нь ингээд цаашаагаа хуваарилалт нь хийгдээд, тэнд ажиллаж байгаа анхан шатын байгууллагууд, үүнээс ер нь яах вэ, нийт төсвийн 50 орчим хувь нь нөгөө түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүдэд сүүлийн 5 жилд гэхэд бараг 20 мянга орчим хүн үйлчлүүлсэн.

Энд үйлчлүүлсэн хүмүүст үйлчилгээний зардал. Хүмүүс бодохдоо зүгээр очоод үйлчлүүлээд нэг зөвлөгөө аваад гарчихдаг юм шиг бодоод байх шиг байгаа юм. Энд шаардлагатай нэлээдгүй урт хугацаанд тэнд амьдарч сэтгэл зүйн зөвлөгөө авах, дээрээс нь хуулийн зөвлөгөө авах, гэр бүл салахдаа хүртэл тулах юм бол тийшээ явах. Бүр байнгын хүүхэд хамгаалах байр луу, эсвэл эцэг, эх байх эрхийг нь хасуулаад байршуулах гэх мэтчилэн арга хэмжээг бид авч байгаа.

Тэгэхдээ энэ төсөв хүрэлцэхгүй байгаа нь үнэн. Яагаад гэвэл энэ хэргийн тоо нэмэгдээд байдаг.

Сүүлийн 2017 оноос хойш сүүлийн 3, 4 жил ингээд тогтмол тоонд байна гэдэг чинь төрийн албан хаагчдын энэ хугацаанд цалин хангамж, бензин шатахуун гээд.

Төрийн хэмнэлтийн хуулиар жишээлбэл энэ сургалт, сурталчилгааны ажил хийх төсөв хасагдчихангуут өнгөрсөн онд боловсролын салбарын 500 орчим нийгмийн ажилтнуудад хүүхэд хамгааллын чиглэлээр сургалт хийсэн чинь аудитаас акт тавьчихаж байгаа юм. Хийж болохгүй гээд.

Тэгэхээр энэ мэдээ мэдээллүүдээ энэ олон салбарын хэдэн зуун ажилтнууд яаж хийж мэдээ мэдээлэл,

сурталчилгааныхаа ажлаа хийх байгаа юм. Үнэхээр хэцүү.

Бид сая 2023 оны 7 сарын төсвийн тодотголоор манай байгууллагууд машинтай буцаж болсон. Үүнийг төсвийн тодотгол дээр Улсын Их Хурал баталж өгсөн. Манай хүүхдийн байгууллагууд үүн дээр баяртай байгаа.

Гэхдээ үүнтэй холбоотой бензин шатахууны зардлууд онцгой тавигдаж чадаагүй.

Тэгэхээр түрүүний хэлсэнчлэн аймаг дээр хүүхэд, гэр бүлийн манай байцаагч нар гэхэд, салбарынхан гэхэд аймгийн төвд байдаг сум руу 200, 300 километрийн цаана очиж ажиллахад бензин шатахууны асуудал бас ингээд л байхгүй.

Тэгээд ихэнх нь залуухан эмэгтэйчүүд, хүүхнүүд байдаг. Ингээд өөрийнхөө машиныг бариад л. Жолооч ч гэж байхгүй. Ингээд л бариад л ажиллах ёстой юм шиг байгаа юм.

Тэгэхээр энэ асуудлыг шийдэхгүйгээр хүний амьдралын хамгийн хэцүү зүйлтэй нүүр тулж очиж ажилла, хүүхдийн эрхийн төлөө ажилла гээд шөнөжин өдөржин ажиллуулна гэдэг хэцүү юм билээ.

Тийм ч учраас манай албан хаагчдын 50 гаруй хувь нь 1-ээс 2 жил арай гэж, хүүхдийн эрхийн тухай арай гэж мэдээд л, ойлгоод л, кэйс дээр ажиллаж чаддаг болоод л тэгээд л одоо уучлаарай ажлаасаа гарлаа, дарга аа, цалин мөнгө амьдралд хүрэлцэхгүй байна, энэ их хэцүү ажил байна гээд л ингээд л яваад өгөхөөр бид үнэнийг хэлэхэд яаж ч чадахгүй байгаа юм.

Тэгээд сая энэ удаагийн 2023 онд 7 сарын төсвийн тодотголоор манай салбарынхны үндсэн цалин нэмэгдсэн. Ингээд орон нутагт ажиллаж байгаа манай төрийн албан хаагчдын цалин нэмэгдэхээр байгаа.

Дээрээс нь нэмээд бид Хүүхэд хамгааллын тухай хуулийг оруулж ирэхэд сум болгонд хүүхэд хамгааллын ажилтантай болмоор байна. Манай Дархан-Уул аймаг энэ дээр Хүний эрхийн Үндэсний Комиссын тайлан дээр биччихсэн байна лээ. Үлгэр жишээ. Хамтарсан баг болгон нийгмийн ажилтантай байна.

Дорнод аймгийн гэхэд зарим сумдуудад нь бүр кэйс болгонд хоёр нийгмийн ажилтантай.

Үнэнийг хэлэхэд нийгмийн ажилчдыг сүүлийн хэдхэн жилд л, арваадхан жилд л цөөхөн хэдэн их дээд сургуульд бэлддэг болсон юм байна. Монголд. Гадаадад бэлтгэгдээд байгаа зүйл байхгүй.

Тэгэхээр хүүхэд хамгаалал гэдэг энэ шинэ тогтолцоо, энэ шинэ ойлголт бидний хувьд ч, төрийн бодлогын хувьд ч жоохон шинэ ийм амаргүй байгаад байгаа нь үнэн.

Тэгээд та бүхэн маань 2024 оны, өчигдөр Ерөнхий сайд ч бас хэллээ, Хурлын дарга ч бас хэлж байна. Улсын Их Хурал, Нийгмийн бодлогын байнгын хороо, гишүүд маань өөрсдөө санал санаачилга гаргаад Улсын Их Хурал дээр өргөн барьсан төсөв дээр тодорхой зохицуулалтуудыг хийж төсвийг нэмэгдүүлэх ажлыг санаачлан зохион байгуулах нь зүйтэй юм байна гэж өчигдөр Ерөнхий сайд, Их Хурлын дарга ч гэсэн онцолж хэллээ.

Тэгээд Их Хурлын гишүүд Та бүхэн маань энэ дээр дэмжлэг үзүүлээч ээ гэж хүсэж байна.

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ц.Сандаг-Очир: Х.Булгантуяа сайд аа, наад орон нутгийн нэгжийнхээ төрийн албан хаагчид төрийн захиргааны албан хаагчид байх юм уу, төрийн үйлчилгээний албан хаагчид байх юм уу гэдгээ эргэж харахгүй юм уу.

Тэнд заавал төрийн захиргааны шалгуур шаардлага хангасан гээд. Ерөөсөө энэ чинь гэр бүлийн асуудал, хүүхэдтэй ажиллах ажилтай учраас сэтгэлтэй, ур чадвартай ийм л хүн байх ёстой юм даа.

Түүнээс биш заавал тэр төрийн захиргааны шаардлага, шалгуурыг хангасан гээд. Яг үнэнийг хэлэхэд энэ ажил дээр чинь ажиллах боловсон хүчний маш их хомсдолтой байгаа шүү. Авдаг цалин нь бага, ачаалал нь их, нийгмийн хамгаалал нь сул дорой учраас.

Тийм учраас үнэхээр ажиллая гэсэн сэтгэлтэй, ур чадвартай. Ахмадууд хүртэл яагаад ажиллаж болохгүй гэж.

Хүүхдийн төлөө сэтгэлтэй, чин сэтгэлээрээ ажилладаг ийм л хүн гэр бүлд чинь хэрэгтэй шүү дээ. Энэ нэгжүүдэд чинь хэрэгтэй. Гэтэл нөгөө төрийн захиргааны албан хаагч байна гэдгээрээ хязгаарлагдаад л ингээд л ажиллаж чаддаггүй. Ажиллая ч гэсэн нөгөө шалгуур шаардлагыг нь хангаж чадахгүй.../минут дуусав/

Г.Занданшатар: Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулна.

Х.Булгантуяа: Орон нутагт төрийн захиргааны албан хаагчдын шалгуур их өндөр. Дээрээс нь нэмээд Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулдаг шалгалт нь хааяа нэг болдог.

Үүнээс үүдээд үнэнийг хэлэхэд орон нутагт ганцхан манай салбар гэхэд ТЗ-ийн албан хаагчдын орон тоо их хоосон байгаа юм билээ. Өндөр тэр шалгуурыг нь тэнцэх хүн ч ховорхон.

Арай гэж нэг тэнцээд ордог. Шалгуурыг нь хангаад. Нэг сум дээр ганц хоёрхон хүн байдаг. Тэгээд тэнцээд орохоор нөгөөдөх нь тун удахгүй гараад явчихдаг.

Тэгээд яах вэ, би салбарынхантайгаа ярья. Манайхан ТЗ байх гол шалтгаан нь улс төржөөд байдаг юм уу, дараагийн Засаг дарга ч байдаг юм уу, сайд нь ч байдаг юм уу ирээд халчихгүй. ТҮ-тэй харьцуулахад арай тогтвор суурьшилтай ажиллах боломж бололцоо нь илүү сайн хангагдах. Дээрээс нь нэмээд саяхныг хүртэл чинь ТЗ, ТҮ-гийн нэмэгдлүүд, орон нутгийн нэмэгдлүүд ялгаатай байснаас үүдээд ТЗ байх сонирхол байгаад байдаг юм билээ.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн.

Б.Жаргалмаа: Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая.

Энэ танхимд сууж байгаа хүмүүсийг ингээд харах юм бол эмэгтэй гишүүд л сууж байна л даа. Их Хуралд байгаа нөхдүүд ч гэсэн ер нь иймэрхүү байдлаар л хүүхдийн асуудалд хандаж байгаа юм. Энэ бол шүүмж.

Яагаад гэвэл хүүхдийн асуудал гэхээр л зөвхөн эмэгтэйчүүд мэдэх ёстой юм шиг нийгэм бидэнд ингэж хандаж

байгаа нь нийгмийн өөрийн алдаа гэж би харж байна.

Одоо ёстой л нөгөө эр, эм эс нийлж үр тогтдогийн адилаар ээж, аав бүгд л гэр бүл, өрх албан байгууллага, төр өөрсдөө хүүхдийнхээ төлөө ажиллах ёстой.

Өнөөдөр ийм л нөхцөл байдалтай ажиллаж байна.

Их Хурал ажлаа хийгээгүй биш хийсэн.

Та бүхэнд би зөвхөн 2023 оны тоо баримт хэлье л дээ.

3 сарын 28-ны өдөр Нийгмийн бодлогын байнгын хороо хүүхдийн эрхийнхээ асуудлаар нээлттэй сонсгол хийсэн.

7 сарын 5-ны өдөр мөн дахиад хүүхдийн эрх чөлөөг хангахтай холбоотой асуудлаар нээлттэй сонсгол хийж үүрэг, чиглэл өгсөн үү. Өгсөн.

4 сарын 3-ны өдөр цахим орчин дахь хүүхэд хамгаалал сэдвээр бас нээлттэй сонсгол хийсэн үү. Хийсэн. Энэ танхимд сууж байгаа бүх хүмүүс байсан.

Их Хурлаас хүүхдийн төлөө зүрх сэтгэл нь цохилж байгаа бүхий л хүнд үүрэг, чиглэл өгсөн үү. Өгсөн. Их Хурал Засгийн газарт чиглэл өгсөн үү. Өгсөн. Ажил явахгүй байх.

Хүүхдийн төлөө хүүхэд хамгааллын бодлого дээр 8 тэрбум төгрөгийг тавиулах гээд хэмнэлтийн хуулиараа хасуулахгүй гэж бид яаж орилж чарлаж байж 8 тэрбумаар нь үлдээлээ. Хүрэлцэхгүй байна. Анхан шатанд чинь хамтарсан багт чинь бензин шатахуун, нийгмийн сэтгэл зүйч байхгүй

байна, бэлдээд өгөөч гээд 8 тэрбумаа хасуулахгүйн төлөө бид зүтгэж байгаад 8 тэрбумаар нь тавиулсан уу. Тавиулсан.

Өнөөдөр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь даргагүй, үүрэг гүйцэтгэгчтэйгээ л сууж байгаа шүү дээ. Яагаад төрийн ажил ийм удаан байгаа юм. Юундаа байдаг юм. Хүүхдийн төлөө бид мөнгөө зарцуулж чадахгүй байна л гээд байгаа юм.

Энэ чинь мөнгөөр явдаг ажил юм уу. Сэтгэл зүрхээрээ явдаг ажил биз дээ. Үнэхээр Сонгинохайрхан дүүрэгт хүүхдийн осол гэмтэл гараад байна.

Би социалаар орилсонгүй л гээд байна л даа. Зам, тээврийн яаман дээр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаман дээр үнэхээр би С.Бямбацогт сайдын өрөөнд орилоод гүйгээд орсон.

Замын тэмдэг тэмдэглэгээ, гарц гаргалгаа гаргаад өгөөч ээ. 4 хүүхдийн амь эрсэдчихлээ. Өнөөдөр дахиад нэг хүүхэд эндчихлээ. Хэдэн хүүхдийн амь надаас нэхэх гээд байгаа юм бэ гээд би орилоод орсон. Өнөөдрийг хүртэл гарц гаргалгаа гаргаагүй л байна.

Юу хүсээд байна вэ гэвэл би зүгээр сэтгэл хүсээд байна. Энэ бүх хэлэлцүүлэг, энэ бүх нээлттэй сонголт, хяналтын сонголын дараа бид юу хэлсэн бэ гэвэл бүгдээрээ хүүхдүүдийнхээ төлөө “за” гээд хэлчихье.

Байгууллага бүр, аж ахуйн нэгж бүр нэгдүгээрт хүүхэд гээд уриагаа гаргачихъя. Ажиллая. Маш их уриалгыг гаргасан.

Өнөөдөр Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороон дээр зам тэмдэг тэмдэглэгээ байхгүйгээс шалтгаалаад 4 хүүхэд амь эрсэдчихсэн.

Л.Халтар сайдын үеэс, өмнөх Засгийн газрын үеэс л би гуйгаад л байгаа. Тэмдэг гаргаад өгөөч ээ гэж. Яагаад ажил хийгдэхгүй байгаа юм бэ?

Хүүхдийн халамжийн төв дээр очсон. Б.Баярсайхан гишүүний ажлын хэсгээр. Хүүхдийн хүчирхийллийн эсрэг. Хүүхэд хамгааллын төв дээр өөрсдөө хүүхдийнхээ эрхийг зөрчөөд байна шүү дээ гээд би хурал дээр хэлсэн.

Өнөөдрийг хүртэл шокт орсон. 17 метр квадрат байранд 24 хүүхэд суулгачаад хүчирхийлэлд өртсөн хүүхдүүд нь хүчирхийллийн тэр хэрэг нь юу болж байгаа бол гээд ижий ааваасаа асууж чадахгүй. Хүчирхийлүүлсэн. Хүчирхийлэлд өртчихөөд 5, 6 удаа би тэгж байгаад тэгээд хүчирхийлээд тэгээд намайг тэгээд хүчиндээд гээд 5, 6 удаа байцаагдаж байна. Энэ өөрөө хүүхдийн хүчирхийлэл биш үү? Монголын төр өөрөө хүүхдээ хүчирхийлэх ёсгүй.

Өчнөөн удаа ингэж орилсон.

Яагаад ажлаа хийхгүй байгаа юм бэ? Одоо Их Хурал дээр байгаа хэдэн эмэгтэйчүүд чинь юу хийх ёстой юм.

С.Одонтуяа гишүүн бид хоёр бас яасан. Төрийн бус байгууллагуудаа бүгдийг нь авчраад нийгмийн сэтгэл зүйчид сул байгаа юм байна. Аваад ажиллуулаач ээ. Уулзаад.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт хангалтгүй л бол асуулт асууна. Х.Булгантуяа сайд.

Х.Булгантуяа: Б.Жаргалмаа гишүүний хэлж байгаа үнэн.

Манай Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүд үнэхээр ажиллаагүй биш ажиллаж байгаа.

Энэ парламентад сүүлийн 30 жилийн түүхэнд 3-хан эмэгтэй гишүүнтэй парламент хоёр ч байсан юм билээ.

Тэгэхээр өнөөдөр 13 хүнд эмэгтэйчүүдийн хүүхдийн асуудал гээд нийгмийн жаран хэдэн хувийг Та бүхэн хариуцах ёстой гэвэл энэ асуудал ингээд төдийгөөс өдий болтол үнэнийг хэлэхэд хуримтлагдаж явсаар байгаад өнөөдөр ингэж гарч ирж байгаа илрэл.

Яах вэ, төсөв мөнгийг нь дэмжээд байгаа ч гэсэн гэмт хэргийн тоо нэмэгдээд байгаа нь нийгмийн ядуурал, ажилгүйдэл энэ юмтай л бид сууриар нь тэмцэж чадахгүй бол үнэнийг хэлэхэд хэцүү юм билээ, Б.Жаргалмаа гишүүн ээ.

Тэгээд та санаж байгаа бол би жишээлбэл Баянзүрх дүүргээс сонгогдсон гишүүн. Би тэнд сургууль, цэцэрлэг рүү явж байгаад 4 хороон дээр жишиг гудамж камертай нь, гэрэлтүүлэгтэй нь тавьж өгсөн чинь сая төрийн хэмнэлтийн хуулиар, Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулиар улсын төсвөөс үүнийг хийхийг хориглочихсон. Үүнийг нийслэл өөрөө юм уу, дүүрэг төсвөөрөө хийх ёстой гээд.

Тэгсэн мөртлөө яг бид нараас шаардаж байгаа юм. Яагаад энэ камержуулалт, гэрэлтүүлэг, зам гарц хийхгүй байгаа юм гээд.

Эсвэл энэ уялдаа холбоонуудаа нэг сайн хангаад. Эмэгтэй гишүүд ээ, Улсын Их Хурлын гишүүд ээ, хэрвээ төсөв тавина гэх юм бол энэ хуулиуддаа Улсын Их Хурал дээр төсөв өргөн барьчихсан байж байгаа. Хуульд нь өөрчлөлт оруулах ёстой.

Тэгж байж улсын төсвөөс энэ зам харгуй, гэрэлтүүлэг, камержуулалт, энэ юман дээр төсөв тавих эрхтэй болох юм билээ.

Тэгэхгүй гэвэл үүнийг нийслэл юм уу, дүүрэг өөрөө л шийднэ гэсэн үг. Яах вэ, нийслэл, дүүргийн төсөв төдийлөн сайн байхгүй.

Манай дүүрэг, орон нутгууд ажиллахгүй биш ажиллаж байгаа. Манай Баянзүрх дүүрэг гэхэд өөрийнхөө төсвөөр 3 давхар хүүхэд хамгааллын байртай болсон.

Олон улсын байгууллагуудаас, бас манай яамнаас хамтраад тэр тохижилт, санхүүжилт бүх юмнуудыг нь шийдэж байгаа.

Тэгэхдээ энэ 8 тэрбумын төсөв чинь 3 давхар байр олныг барих юм бол урсгал зардлаасаа авхуулаад л, ажиллах боловсон хүчнээсээ авхуулаад л гараад явчхаад байгаа юм.

Тэгэхээр гишүүдээсээ хүсэхэд энэ дээр хэдүүлээ хамтраад боловсон хүчнээ бэлтгэхээсээ авхуулаад, төсөв санхүүгээс нь авхуулаад. Дээрээс нь нэмээд саяын энэ камержуулалт, гэрэлтүүлэг, сургууль, цэцэрлэг рүү явж байгаа зам талбайг хэрвээ Улсын Их Хурал дээр улсын төсөв дээр бид шийдэж чадахгүй юм бол бид нараас тэгвэл хариуцлага нэхэх хэцүү болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр үүнийгээ яах юм бэ гэдэг асуудал ярих болчихоод байгаа юм.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна. 1 минут.

Б.Жаргалмаа: Цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаар Н.Учрал сайд ер нь ямар ажил хийж байна вэ? Энэ хамгааллын асуудлыг. Ер нь цахим орчин нийгмийг удирдаад байгааг Та бүхэн харж байгаа байх. Тийм ээ.

Тэгэхээр энэ дээр бид юу хийх ёстой юм бэ гэдэг дээр хууль асууж байна.

Нөгөөтээгүүр хүний нөөцийн асуудал. Яг одоо анхан шатанд ажиллах боломжгүй л гээд байдаг. Хүний нөөцөө яаж бэлдэж байгаа юм бэ? Х.Булгантуяа сайд аа, Л.Энх-Амгалан сайд аа. Яг хүүхэд хамгааллын чиглэлээр, нийгмийн ажилтны чиглэлээр.

Нийгмийн ажилтны тухай хууль чинь хэзээ орж ирэх юм бэ? Х.Булгантуяа сайд аа.

Ер нь Монгол Улс хүн амын статистик тоон дээрээ алдаатай, зөрүүтэй тоо хэлдэг. Дандаа. Ахмадууд дээрээ хүртэл зөрүүтэй тоо хэлдэг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэд дээр зөрүүтэй тоо хэлдэг.

Яг өнөөдөр эрсдэлийн судалгаагаа хийсэн үү гэдэг зүйлийг дандаа ярьдаг. Бид. Яг өнөөдөр эрсдэлд өртөж болзошгүй хүүхдүүдийнхээ судалгааг бид хийж чадсан уу, үгүй юу гэдэг дээр яг одоо Та бүхэн нэг тайлбар өгөөдхөөч ээ.

Тэгээд Их хурлын дарга аа,

Нийгмийн ажилтны тухай хуулиа, Хүүхэд хамгааллын тухай хуулиа, Гэр бүлийн тухай хуулиа, Цахим орчин дахь хүүхэд хамгааллын тухай хуулиа яг энэ цаг мөчид бүгдээрээ одоо баталъя.

Бусад тэр мөнгө иддэг уудаг юмнуудаа бүгдээрээ больё. Та нар. Тэгэх үү.

Их Хурлын эрэгтэй гишүүд ээ. Эрэгтэй, эмэгтэй гээд.

Г.Занданшатар: Эхлээд Ням-Осорын Учрал сайд. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал.

Н.Учрал: Түрүүн нэлээн олон гишүүд асуусан.

Тэр **“AMBER Alert”**-тэй холбоотой. Тэр **“AMBER Alert”** бол олон улсын network. Нэг ёсондоо социал медиа, олон нийтийн медианууд болоод бусад цахим орчинд үйл ажиллагаа явуулж байгаа нэлээн олон компаниуд энэ **“AMBER Alert”**-тэй хамтарч ажилладаг.

Гэхдээ манай бүсэд хамааралтай эсэх асуудал дээр бид хүсэлтүүдээ хэд хэд явуулсан.

Ер нь Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах хуулийг анх өргөн мэдүүлэхэд бид ер нь case channel-ийг л тодорхой болгоё гэсэн юм. Яг энэ **“AMBER Alert”**-т шиг. Дээрээс нь бусад тэр социал медиа платформуудтай хэрхэн харилцах вэ гэдэг зарчмаа л тодорхой болгоё л гэж зорьсон юм шүү дээ.

Тухайн үед олон нийт шүүмжлээд ингээд л буцчихсан болохоос биш тухайн үед хийчихсэн бол харилцаа холбооны хувьд маш их ойлгомжтой болох байсан.

Тэгэхээр цаашдаа бид.../минут дуусав/

Г.Занданшатар: Б.Жаргалмаа гишүүн эхлээд 4 минутдаа асууж сур. За юу. Тэгвэл 4 минутад хариулт авдаг.

Сүүлийн 1 минут чинь тодруулах асуулт байхгүй юу. Хариулт хангалтгүй гэж үзвэл. Тэгэхээр энэ чинь амжихгүй болчихоод байгаа юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа.

Х.Булгантуяа: Эрсдэлийн түвшний үнэлгээг хоёр жил хийсэн. Эрсдэлтэй айл өрхүүдэд амьдарч байгаа хүүхдүүдийн тухай мэдээллүүдийг хүргэсэн. Нийт хүүхдийн гуравны нэг байгаа. Энэ бол том тоо.

Тэгэхээр 8 тэрбум төгрөгөө Та бүхэн бодоод үзэх юм бол, энэ эрсдэлд байгаа хүүхдүүддээ хуваагаад үзэх юм бол нэг хүүхдэд 20 мянган төгрөг хүрэхгүй байгаа.

Тэгэхээр бидний хувьд яах вэ, тайлбар хийх ч илүүц биз дээ.

Тэгэхдээ нийгмийн чиглэлийн мэргэжилтэй хүмүүсийг ажиллуулахыг бид 17 их сургууль сүүлийн арван хэдэн жилийн хугацаанд л бэлдэж эхэлсэн.

Боловсролын сайд Боловсролын зээлийн сангийн нэн шаардлагатай мэргэжилтнүүдийн жагсаалтад оруулж Боловсролын зээлийн сангаас энэ хүүхдүүдийг сурах дээр зээллэг олгодог, тэтгэлэг, дэмжлэг олгодог байдлаар шийдвэрлэсэн.

Гэхдээ олон улсын туршлагуудыг судлахад бид гадагшаа энэ нарийн мэргэжлийн хүмүүсээ бэлтгэх хэрэгцээ шаардлага манай салбарт маш их байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлаар, хүүхдийн хамгааллын асуудлаар, хүүхдийн эрүүл мэнд, нарийн мэргэжлийн асуудлуудаар үнэнийг хэлэхэд төр л өөрөө бэлдэхгүй бол айлууд хүүхдээ миний хүү Америк яваад тусгай.../минут дуусав/

Г.Занданшатар: Ер нь Хүүхэд хамгааллын тухай хуулиар энэ сэжигтэй хүмүүстэй яаж харьцах вэ. Ер нь хүүхдүүдэд боловсрол олгох асуудлыг энэ хүүхдийн хүчирхийллээс сэргийлэх хамгийн чухал арга хэмжээ гэж үздэг.

Энэ чиглэлээр Хүүхэд хамгааллын тухай хуульд сум, хороодод нийгмийн хамгааллын ажилтан ажиллуулахаар тусгасан.

Энд 1044 ажилтан шаардлагатай байгаа. 1044 ажилтан. Сум, хороодод 540 ажилтан нэмж ажиллуулах шаардлагатай. Үүний төсөв нь 11.3 тэрбум байгаа юм.

Өнөөдөр хэлэлцүүлгээс гарах бодит шийдэл нь одоо энэ төсөв хэлэлцэж байгаа үед нь 11.3 тэрбум төгрөгийг шийдэж өгөөд, ингээд энэ эрсдэлтэй бүлгийн хүүхдүүдийг тодорхойлох, тэдэнтэй ажиллах, нөлөөллийн үйл ажиллагаа хэрэгжүүлэх. Энэ цагдаагийн байгууллага ч гэсэн тэр олон улсын жишгээр урьдчилан сэргийлэх нөлөөллийн, зорилтот бүлгийн эрсдэлд өртөж болзошгүй хүүхдүүдийн судалгаа гаргаж, тэдэнтэй ажиллах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх энэ ажлууд чинь ингэж цогц явагдах уялдаа холбоо сайжрах учиртай.

Тэр Солонгосын багш нарын жишээ татаад байх ч юм байхгүй. Солонгосын боловсролын систем бол маш өндөр ачаалалтай, дарамттай, шахалттай, өрсөлдөөнтэй систем дээр

эцэг, эхчүүдийн дарамт хэрээс хэтэрсэн учраас ийм асуудал үүссэн.

Эцэг эхчүүдээс утсаар үзүүлж байгаа дарамтыг нь рекординг хийж бичиж авдаг л байх тийм зохицуулалт хийгээд л асуудлыг шийдсэн шүү дээ.

Тэгээд хоёр өөр тогтолцоонуудыг харьцуулаад байх шаардлагагүй. Энэ чинь бүх талын хамтын ажиллагаа шаардлагатай. Боловсрол, эрүүл мэнд, цагдаа, хууль хяналтын байгууллага.

Тийм учраас энэ дээр нэг их бие бие рүүгээ чихээд л, тэгээд л оройтож, урьдчилж хашхираад л байх ямар ч шаардлага байхгүй.

Ингээд Балжиннямын Баярсайхан гишүүн.

Б.Баярсайхан: Баярлалаа. Өнөөдөр бид зөвхөн хүүхэд биш. Энэ Монгол үндэстэн цаашаа байх юм уу, байхгүй юм уу. Энэ Монгол гэдэг улс орныг хэн авч явах гэж байгаа юм. Тэр хүмүүсээ бид яаж бэлдэж байгаа талаар л ийм хариуцлагатай уулзалт, хэлэлцүүлэг, яриа хийж байна гэж ойлгох хэрэгтэй.

Миний хувьд Улсын Их Хуралд орж ирэхээс өмнө арваад жил, Улсын Их Хуралд орсноос хойш 3 жил яг энэ хүүхдийн асуудалтай ажиллаад явж байна.

Их Хурлын түвшинд яаж ойлгодог юм, Засгийн газрын хэрэгжүүлж байгаа байгууллагууд нь яаж ажилладаг юм гэдгийг нүдээрээ харж байгаа.

Тэгээд би Х.Булгантуяа сайдад нэг зүйлийг хэлмээр байна.

Та сайдаар томилогдоод удаагүй байгаа юм чинь танд буруутгал өгөөд

байх шаардлага байхгүй. Гэхдээ та яг доод талынхаа ажиллаж байгаа зарим нэг хүмүүсийн амаар ажлаа өнөөдөр ямар нэг юм нь шалгалтад орж байгаа биш ингээд болж бүтэж байгаа юм шиг бас яриад байх шаардлага байхгүй.

Би юу гэж хэлэх гэж байна гэхээр өнөөдрийн хүүхэд хамгааллын бодлого өнөөдөр яг байгаа онож байгаа юм уу? Бид нарт 8 тэрбумын төсөв чинь хүрч байгаа юм уу гэхээр таны яам, таны агентлаг энэ дээр өнөөдрийг хүртэл хариулж чаддаггүй.

Энэ 8 тэрбумынхаа 5 тэрбумыг, энэ Б.Баярсайхан гишүүн юу яриад байна гээд яриад байна гэсэн. Энэ Нийгмийн бодлогын байнгын хороон дээр 3 жил дараалж орж ирэхдээ танай агентлаг төсвөө хамгаалж чаддаггүй. 8 тэрбумынхаа 5 тэрбумыг хаачсаныг тайлбарлаж чаддаггүй.

Тэгээд жил болгон улсын төсөв дээр эмэгтэйчүүд төсөв нэмэх талаар ярьдаг. Яах юм, төсөв нэмж. Яг бодлого чинь байгаа онож байгаа юм уу, төсөв шаардлагатай юм уу гэхээр тэр дээрээ дүгнэлт хийгээд орж ирж чадахгүй байгаа хүмүүс дээр яах юм.

Тэгээд баахан хурал цуглаан хийдэг. Нэг гишүүний сонгуулийн ажилд хүртэл мөнгө зарсан тохиолдол ч гэсэн байгаа. Би худлаа яриагүй. Аудитын дүгнэлт нь байж байгаа.

Өнөөдөр улсын хэмжээнд 715 хамтарсан баг байгаа. Энд Г.Арсланхуяг дарга хэлнэ, цагдаагийнхан хэлнэ.

Энд 387 мянган төгрөг өгдөг гэсэн. 712 хамтарсан багт. Энэ худлаа.

4 аймаг, 9 дүүргийн хамтарсан багуудтай 11 сарын турш хүүхэд

хамгааллын байгууллагуудад би шалгалт хийж явсан. Ж.Хунан дарга энд сууж байна.

Тэгээд үүнийгээ ингээд тогтоолын төсөл болгоод Байнгын хороон дээр Засгийн газарт үүрэг чиглэл өгөөд явсан. Нэг нь ч хэрэгжээгүй байгаа шүү дээ.

Энэ дотор чинь хүүхэд ярьдаг хүн байгаад байна шүү дээ. Үүнийгээ ойшоож үзээч ээ. Монгол Ардын намын бүлэг дээр энэ ажлыг танилцуулсан 10 хүрэхгүй гишүүд хүрч ирээд л суусан шүү дээ.

Одоо цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийг би санаачлаад өргөн барих гээд яваад байна. Сая D-Parliament дээр хэлэлцүүлээ.

Цахим орчинд монгол контент хийгээд өгөөч ээ гээд Соёлын яамнаас би 3 жил гуйж байгаа.

Сая тэр контейнер дээр байгаа 4 хүүхэд юу харж, тэр үйлдлийг хийгээд сууж байгаа юм.

Тэгээд Х.Булгантуяа сайд та энэ агентлагаа цэвэрлэхгүй бол одоо төсөв чинь 15 тэрбум хүрэх сургаар энэ агентлагийн чинь дарга дээр баахан хүмүүсийн нэр ус яригдаад явж байна.

Энэ дээр би олон дахин хариуцлагатай хэлье.

Ямар ч нам, улс төрийн харьяагүй яг хүүхдийн байгууллагаар мэргэшсэн мэргэжлийн хүнийг томилмоор байна. Хүүхдийн байгууллагын 100 жил болох гэж байна. Бид хүчирхийллээсээ салаагүй сууж байна.

Хүүхэд хамгаалал гэхээр ганцхан хүчирхийлэлд өртсөн хүүхдийн тухай ярьдаг. Шим тэжээлгүй хоол унд идэж

таргалж байгаа, хорт хавдраар өвчилж байгаа. 12-оос 17-хон настай 500 гаруй хүүхэд, охидууд жилдээ жирэмсэлж байна. 13 настай хүүхэд төрүүлж байна.

Зан чанарынх нь талаар яаж хамгаалах юм, соёлоор нь яаж хамгаалах юм, хэл, соёлыг нь яаж хамгаалах юм, бие махбодыг нь яаж хамгаалах юм гээд.

Би Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг хамгийн их шүүмжилдэг боловч хамгийн их ажлыг нь өмнө нь орж хийдэг.

Энд Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3-ыг яагаад хэрэгжүүлэхгүй байгаа юм.

Байгууллага болгон, аймаг, Засаг дарга, бүх Төрийн нарийн бичгийн дарга, Хүүхдийн төлөө үндэсний зөвлөл Ерөнхий сайдын бүгд биелүүлье гээд амлаад ингэсэн. Танайхаас зөвлөмж нь гарч ирэхгүй байгаа шүү дээ. Ажлаа хийхгүй байгаа шүү дээ.

Энэ агентлаг дээр байгаа энэ худал хуурмаг юмаа та мэдэж байгаа юу?

Г.Занданшатар: Б.Баярсайхан гишүүн ээ, 3 сарын 28-нд Байнгын хорооны тогтоол гарсан. 7 сарын 05-нд бас сонсгол зохион байгуулж байсан. Хүүхдийн хамгааллын асуудлаар. Тийм ээ. Асуулга тавьж байсан.

Хүүхдийн эрхийн зөрчлийн асуудлаар нийтийн сонсгол хийхээр Ц.Мөнхцэцэг гишүүн, Б.Баярсайхан гишүүн хоёр санал гаргаад албан бичгээр энэ асуудал ажлын тав хоногийн дотор шийдвэрлэхээр явж байгаа.

Тэгээд тэр дээр үүнийг задалж ярьж болно. Эхлээд Н.Учрал сайд

хариулна. Ням-Осорын Учрал сайд. Цахим харилцаа, хөгжлийн сайд.

Н.Учрал: Би Б.Баярсайхан гишүүний 2020 оноос парламентад сонгогдсоноосоо хойш энэ цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг яриад, хөндөөд бас ажил хэрэг болгоод ингээд хуулиа боловсруулчхаад олон нийтээр хэлэлцүүлж байгааг би их хүндэтгэж байгаа.

Дээрээс нь С.Одонтуяа гишүүнтэй ч энэ асуудлаар уулзаж байсан.

Ер нь манай эмэгтэй гишүүд цахим орчин дахь хүүхэд хамгааллын асуудлыг анхаараач ээ гэдгийг асар олон удаа ярьж хэлж, олон нийтийн сонгол хийж, төсөв мөнгө нэмүүлье гэж явсан.

Яг үнэхээр нөхцөл байдлаа бид эргээд харах ёстой. Хөдөлмөрийн яам өнгөрсөн үе үедээ хэзээ ч энэ хүүхэд хамгаалал дээр анхаарал тавьж байгаагүй шүү. Яг үнэндээ.

Энэ ажлыг хэн хийсэн юм бэ гэхээр Хууль зүйн яам л хийсэн юм билээ.

Өнөөдөр Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Г.Арсланхуяг хурандаа л энэ ажлыг хийсэн шүү дээ.

Өнөөдөр тэр Unfriend байна уу, тэр Unfollow, одоо энэ олон аян өрнүүлээд ингээд өөрсдөө зүтгэж байгаа шүү дээ. Энэ чинь тийм төсөв мөнгө байдаг ч үгүй юм билээ. Дандаа олон нийтийн дэмжлэгтэйгээр хийгээд л өнөөдрийг хүрсэн.

Би тэр Чингэлтэй дээр ч гэсэн тэр “ногоон бүс” олгочихсон байна гээд хэдэн хороог нь очоод үзсэн. Тэр чинь камерын хяналтын системийг нь

хийчхээд л гэмт хэрэг багассан гээд л үзүүлж байсан. Жилийн өмнө л ярьж байсан шүү дээ.

Тэгээд л камер тавья гээд л өнөөдөр сэрж байгаа юм шиг юм яриад хэрэггүй шүү дээ.

Хөдөлмөрийн яамныхан та нар энэ Хууль зүйн яамтайгаа ажиллах хэрэгтэй байхгүй юу. Одоо үнэхээр камер хэрэгтэй юм бол энэ чинь нөхцөл байдлыг нь очоод үз л дээ. Одоо тэгээд л тавья гэвэл ороод л тавилаа шүү дээ.

Гэхдээ үүнийг улс хийх шаардлага байхгүй. Олон нийтийн дэмжлэгтэйгээр тэр төрийн бусуудтайгаа нийлээд л хамтраад л хийх хэрэгтэй.

Одоо түүнээс биш тэр нэг агентлагийн төсөв нэмүүллээ гэж юу ч өөрчлөгдөхгүй. Түүний оронд харин тэр санаачилга гаргаад байгаа Ч.Ганжавхлангийн төрийн бус байгууллагатай нь хамтраад тэр мөнгө төгрөгөөр нь дэмжээд, энэ цагдаагийн байгууллагад тэр контент хийлгэх гэж байгаа бол тэр мөнгө төгрөгийг нь өгөөд юмыг нь хийлгэх хэрэгтэй шүү дээ.

Тэгэхгүйгээр хэдэн агентлаг дээр хэдэн цалин нэмнэ. Түрүүн Ц.Сандаг-Очир гишүүний хэлж байгаа үнэн шүү дээ. Ямар үр дүн гарах юм. Тэгээд л нэг цалин нэмсэн нэртэй. Тэгээд үр дүн байхгүй.

Тэгэхээр энэ ажил дээр анхааръя. Цахим орчин дахь хүүхэд хамгааллын хууль дээр ч гэсэн би мэргэжлийн яамны хувьд саналаа өгөөд тэгээд хамтарч ажиллахдаа би нээлттэй байна.

Өмнө нь Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах хууль гээд явсан. Тэгээд тэр хуулийг хамгийн их

эсэргүүцэж байсан. Үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдлаа гээд л уйлан дуугарч байсан нөхдүүд өнөөдөр гэнэт сэргэхэд хүүхдэд хайртай болоод л пост хийгээд сууж байгаа шүү дээ.

Тухайн үед хэлж байсан шүү дээ. Наадах чинь маргааш юу болохыг та нар гэж байхад л намайг барьж идчих гээд байсан.

Өнөөдөр тэр хүмүүс чинь бүгдээрээ амь орчихсон бүгдээрээ хүүхдэд хайртай хүн болчихоод пост хийгээд сууж байна шүү дээ. Жинхэнэ жадлан эсэргүүцэж байсан нөхдүүд.

Тэгээд энэ хуулийг гаргавал олон нийт өөрсдөө гаргах хэрэгтэй. Үүнийг улс төрчид хийхгүй. Үүнийг тэр Ч.Ганжавхлан ба бусад төрийн бус байгууллагууд бүгдээрээ нийлээд өөрсдөө санаачлаад бид дэмжээд л явж болно. Үүнийг улс төрчид хийдэг юм биш. Амьдрал дээр ажиллаж байгаа хүмүүс нь энэ хуулиа явуулах хэрэгтэй.

Тэгээд бид өнөөдөр **e-mongolia**-ийн 1.6 сая хүнд зөвлөмж хүргүүлсэн. **GOOGLE FAMILY LINK**-ийг ашигладаг, мэддэг ойлголттой хүмүүс нь. Google Family Link дээр интернэт хязгаарлаж байгаа, location тодорхойлж байгаа, хүүхдүүдийнхээ YouTube, бусад аппликэйшний хэрэглээг хязгаарлаж байгаа.

Би хүүхдүүддээ **Google Family Link** дээр үнэ төлбөргүйг нь аваад үзээд байж байгаа. Миний хүүхэд юу үзэж байгааг. Ингээд хэрэглэх бололцоо байна. E-Mongolia дээр бид иргэнийг таньдаг байсан бол хүүхдийг таньдаг болгоё гээд одоо **E-KIDS**-ийг дотор нь оруулах гэж байна.

Өнөөдөр би операторуудтай ярьсан. E-Mongolia-ийн e-kids-ийг дата унагадаггүй болгооч ээ гэсэн. Нийгмийн хариуцлагын хүрээнд дэмжье гэж байна.

Ингээд хүн болгон доор доороо юу чадах юм. Тэр боломжоо дайчлаад л ингээд л хамтдаа ажиллая, ажил хэрэг болгоё.

Тэгээд Их Хурлын дарга бас үүнд анхаараад сонсгол хийе. Өнөөдөр ингээд цаг үеэ.../минут дуусав/

Г.Занданшатар: Тийм. Н.Учрал гишүүний тэр социал сүлжээний зохицуулалтын хууль маш сайн хууль. Шаардлагатай хууль байсан гэдэг нь ингээд л амьдрал тутам батлагдаад л байгаа юм даа.

Цагдаагийн байгууллага ч гэсэн **“ХАМТДАА ХАМГААЛЪЯ”** хийгээд цахим орчин дахь хүүхэд хамгааллын их сайн аян өрнүүлсэн.

Цагдаагийн газрын энэ **“АНЗААР”**, тэр **“ЯАРААД ЯАХ ВЭ ДЭЭ”** гэх мэтчилэн нөлөөллийн ажиллагаанууд их сайн болж байгаа юм шүү.

Тэр цагдаа, олон нийтийн хамтын ажиллагааны ажлууд их шинэ шатанд гарч байгаа. Цагдаагаас хийж байгаа ажлууд байгаа юм. Харилцан уялдах л хэрэгтэй байгаа юм.

Ингээд зочид танилцуулъя.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл доор зохион байгуулагдаж байгаа **“ШИНЭ СЭРГЭЛТ-МАЛ АЖ АХУЙ”** үндэсний чуулганд Баян-Өлгий, Баянхонгор аймгаас оролцож буй залуу малчид Улсын Их Хурлын үйл

ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Залуу малчин залуучууддаа ажил, хөдөлмөрийн өндөр амжилт, сайн сайхныг хүсэн ерөөе. /алга ташив/

Бие амгалан, сүрэг тарган сайхан намарцгааж байна уу.

Одоо энэ Боловсролын сайд залуу малчдын хамгийн их тавигдаж байгаа нэг асуудал бол хүүхдийн боловсролын асуудал байгаа. Шинэ хуулиар 7 настай орж болохоор болсон.

Тэгэхдээ 6 настай байхад чинь ээж нь хараад аймгийн төв дээр үлддэг. Аав нь хөдөө малтайгаа үлддэг. Ингээд л гэр бүл салалт, тэгээд л хүүхдийн эрхийн том зөрчлүүд гараад байсан. Бодит байдлууд хөдөөд их тулгамдсан асуудал болж байсан. Үүнийг 7 нас болгосон.

Тэгэхдээ л ер нь хөдөөгийн сургуулийн орчин их өөр. Энэ дээр анхаарах юмнууд их байгаа.

Ингээд малчдадаа амжилт хүсье. Баярлалаа. /алга ташив/

Хүрэлбаатарын Булгантуяа сайд нэмж хариулья.

Х.Булгантуяа: Б.Баярсайхан гишүүний ярьж байгаа Хөдөлмөрийн тухай хуулийн хэрэгжилт. Журам нь гарсан. Хэрэгжээд явж байгаа.

Ер нь яах вэ, хүүхэд хамгааллын бодлогын баримт бичгүүд сайн хэрэгжиж байгаа гэж хэлж чадахгүй. Ямар ч байсан 68 байгууллага хажуу талдаа хүүхдийн цэцэрлэгтэй, 5363 эцэг, эхийн зөвлөл бий болсон байна, 522 байгууллага хүүхдийн ерөөтэй болсон байна, хүүхэд

хамгааллын бодлоготой байгууллага 1983 болсон байна.

Бид ер нь цаашдаа авч хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээн дээр ялангуяа нэн түрүүнд төсвөөс цалинжиж байгаа төрийн байгууллагууд энд зайлшгүй ийм баримт бичигтэй байх ёстой.

Тэгэхдээ ер нь ганцхан баримт бичигтэй байлаа гээд юм сайжирдаггүй. Хууль сайхан байлаа гээд сайхан хэрэгждэггүйтэй адилхан үүний хэрэгжилт дээр нь төсвийн захирагч нар, төрийн төрийн байгууллагуудын дарга, удирдлагууд өөрснөө манлайлж оролцож байж хувийн хэвшлүүдийг үүн дээр нь шахаж ажиллах ёстой юм билээ.

Энэ байгууллагын дарга удирдлагын хувьд 2016 оноос хойш байгуулагдсан 8 жилийн хугацаанд 5 дахь даргынхаа нүүрийг үзэж байна. Нэг дарга нь нэг жил гаруй болоод л ерөнхийдөө солигддог.

Тэгээд яагаад ч юм болохгүй байна гээд л тэгээд шүүмжлээд л, эсвэл тэр нь ч асуудалтай байдаг юм уу. Тэгээд сүүлдээ өөрсдөө ч бас ажлаасаа гарчих юм.

Яг ийм байдалтай байх юм бол их хэцүү байгаа нь үнэн.

Сая 7 дугаар сард энэ байгууллагын хуульд өөрчлөлт ороод, Засгийн газрын тухай хуульд энэ байгууллагын статус нь өөрчлөгдчихсөн учраас залуучуудын асуудлыг тусад нь гаргаж зөвхөн хүүхдийн байгууллагаар нь явуулья гэж Улсын Их Хурал, Засгийн газраас шийдвэрлэсэн учраас даргын асуудлыг энэ юу нь батлагдсаны дараагаар гээд, одоо ингээд ажлын

байрных нь тодорхойлолт юмнууд нь гараад зарлагдах гээд явж байгаа.

Тэгээд би бол энэ дээр улс төржөөд байх юм байхгүй ээ. Хүүхдийн асуудлаа мэддэг, миний өмнөөс хүүхдийн асуудал дээр надад тус нэмэр болдог хүн байвал би тавихад би бэлэн.

Гэхдээ хүүхдийн асуудал дээр ганц хүний асуудал ерөөсөө биш. Даргын асуудал биш. Төрийн бус байгууллагуудтай, эрдэмтэн судлаачтай, иргэний нийгмийн байгууллагуудтай нам харгалзан Ардчилсан намын эмэгтэйчүүд, ХҮН нам бүгдтэй нь л хамтарч ажиллаж байж энэ асуудлын ард гарах юм билээ.

Тэгээд тийм л дарга томилогдоосой гэж бодож байгаа.

ТЗ-ийн шаардлага нь их өндөр учраас үнэнийг хэлэхэд болдог бол НҮБ-ын Хүүхдийн байгууллага, тэнд ажиллаж байсан хүмүүсээс тавих юм сан гэж бодох юм.

Тэгээд манай төрийн захиргааны шаардлага нь маш өндөр учраас тэнд хэр баргийн хүн томилогдоход их хэцүү. Тэгээд одоо байж байгаа хэд дотроосоо л томилохоос өөр аргагүй л юм билээ. Тэгээд тэд нарыг нь хүмүүс бүгдээрээ шүүмжлээд байдаг.

Тэгэхээр одоо яах ёстой юм байгаа юм бүү мэд.

Г.Занданшатар: Балжиннямын Баярсайхан гишүүн тодруулж асууна.

Б.Баярсайхан: Шүүмжлээд гэж ярих хэрэггүй ээ, Х.Булгантуяа сайд аа.

Шүүмжилсэн би л шүүмжилсэн. Шүүмжиллээ гээд өнөөдөр ажлыг нь хийсэн. Танай яам ганцаараа хийж

чадахгүй байгаа учраас Хөдөлмөрийн тухай хуулийн 43.3 дахь заалтыг батлуулаад “байгууллага болгон хүүхэд хамгааллын бодлоготой байна” гээд. Байгууллагууд чинь юу хийхээ мэдэхгүй байна шүү дээ. Энэ бодлого гэдэг дотроо.

Үүнийгээ л хийж чадахгүй байна шүү дээ л гэдгийг чинь ярьж байгаа.

Та намайг шүүмжилсэн гээд байгаа бол аудитын дүгнэлтээ нэг харчих. За юу. Хүүхэд хамгааллын байран дээр энэ төсвийн 8 тэрбумаас чинь архи, виски авсан, гэр орондоо цахилгаан хэрэгсэл, бараа үйлчилгээ авсан, хүний сонгуулийн мөнгөнд зарцуулсан. Худлаа сургалт хийх нэрийдлээр мөнгө төгрөг үнэгүй зарцуулсан гээд аудит чинь өөрөө хэлээд байна шүү дээ.

Би хэлээд байгаа юм биш ээ.

Тэгээд Н.Өлзийхутаг даргыг та одоо шүглээ үлээ үлээ. Энэ агентлаг, яаман дээр чинь юу болохгүй байдаг юм. Тэр Боловсролын зээлийн сангийн тэр хэн билээ. Тэр хүн шиг та наад асуудлаа гаргаж ярь.

Тэгэхгүй бол үе үеийн дарга нарын.../минут дуусав/

Г.Занданшатар: Чинбатын Ундрэм гишүүн алга байна. Хаслаа.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн.

С.Ганбаатар: Өнөөдөр Улсын Их Хурал цаг үеэ олсон асуудлаа ярьж байна.

Би өмнө нь Л.Мөнхбаясгалан сэтгүүлчийн нэг нэвтрүүлгийг үзэж байсан юм. Алга болсон хүүхдийн ээж дээр очоод ярьсан. Ерөөсөө л миний хүүхэд хамгийн сүүлд над руу утсаар ярьсан. Би нэг ажилтай байж байгаад 5

минутын дараа авахад дахиж би тэр хүүхэдтэй хэзээ ч холбогдож чадаагүй гээд.

Тэгээд л алсын бараа ширтээд л явдаг болчихсон гэж ярьсан.

Одоо Монгол орон даяараа өнөөдөр хирт хийж, цочирдож Их Хурал өнөөдөр хуралдаж байна. Үгүй одоо ингээд ч гэсэндээ хуралдсан ч яах вэ.

Одоо хамгийн аймаар нь нэг өдөр нэг оволзож хуралдаад л дараагийн хирт хийлт, цочирдох асуудал хүртэл ингэж тэнэг байдалтай байхгүй байцгаая гэдгийг л нэгдүгээрт би хэлье.

Б.Баярсайхан гишүүн бол яг энэ асуудлыг ажлын хэсэг гаргаад явсан. Ажлын хэсэг дотор нь би орсон. Үнэхээр сэтгэл гаргаж явсан.

Нэгдүгээрт, бидний ажил. Улсын Их Хурал өнөөдөр тэр ажлын хэсгийн дүгнэлт, хийсэн ажлуудыг анхаарч, сэтгэл гаргаж, сонсож, ажил хэрэг болгохдоо дутуу дулимаг байсан.

Бид алдаа оноогоо шууд ярьдаг байх ёстой. Тэр Б.Баярсайхан гишүүний ахалсан тэр ажлын хэсгийн дүгнэлтийг дахиж үзээд Их Хурлаараа ярилцаад юу юу хийж болох вэ, эрх зүйн орчинд ямар ямар арга хэмжээ авах вэ гэдгээ ярихаас энэ ажил эхэлнэ ээ.

Үүнийгээ ирэх долоо хоног байна уу, яаралтай бид ажиллуулах хэрэгтэй.

Хоёрдугаарт, хэн нэгнийг буруутгах, зөвтгөх тухай би ярих гээгүй ээ. Одоо хэдүүлээ яах вэ. Нэг л Монгол. Зүрх шимширч байна, шаналж байна.

Үндсэн хуульд “төрийн үндсэн үүрэг иргэдийн аюулгүй байдлыг хангах”

гэж байгаа. Иргэд дотроо өөрсдийгөө өмгөөлөх чадваргүй, хамгаалах чадваргүй хүүхдүүдээ хамгаалах гэдэг бол төрийн нэн тэргүүний үүрэг.

325 билүү. Одоо би санахгүй байна. Одоо би бас дэмжээд л явж байсан. Зүгээр манлайлаагүй. 325 сая төгрөгийн төсөвтэй байсан юмыг эмэгтэй гишүүд болон эрэгтэй гишүүд ч оролцсон. Мань мэт нь оролцоод 8 тэрбум болгосон.

Энэ ямар хөгийн мөнгө гэж санана. Нэг хүүхдэд 5 мянган төгрөг л ногдож байгаа шүү дээ. Тэр зорилтот хүүхэд гээд байгаа. Түүн дээр 20 мянга. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд тооцох юм бол 15 мянга. Нэг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд 1200 төгрөг гэсэн үг. Монголын нийт хүүхдэд тооцох юм бол 400 төгрөг сард зарцуулж байгаа юм шүү дээ. Бид нүдний булай.

Тэгэхээр энэ бүхний үндэс уурхай юу вэ гэвэл. Түрүүн Б.Бат-Эрдэнэ аварга хэлсэн. Авлигал бол бидний одоо энэ бүхний үүр уурхай шүү.

Үндсэндээ Улсын Их Хурал **“эрх зүйн орчныг нь бүрдүүлэх”, “төсвийг нь батлах”, тэгээд “хуульд хяналт тавих”** гэсэн гуравхан ажилтай.

Энэ асуудал дээр би гурав дахь ажлаасаа буюу тэр ажлын хэсгээр хийсэн тэр өчнөөн ажлыг одоо нэг эргэж харж ажил болгох талаар ажиллая. Дахиад тэгээс эхлэхгүй ээ. Нэгдүгээр ажил.

Хоёрдугаарт, төсөв. Өнөөдөр Оюу Толгойн том цөм хийсэн хулгай, нүүрсний хулгай гэж байгаа. Авлигатай тэмцээд байгаа. Нэгдүгээр асуулт. Авлигатай тэмцэх газар, энэ хууль хяналтын байгууллагуудаас нь.

Энэ авлигатай тэмцээд тэмцээд олсон хэдэн төгрөгийн орлого байгаа вэ? Тэр хулгайч нараас хэдэн төгрөг олж ирсэн бэ? Тэндээс хэдэн төгрөгийн мөнгийг нь хүүхдийн энэ асуудал дээр тавих боломжтой байгаа вэ? Нэгдүгээр асуулт.

Яагаад би үүнийг асууж байгаа вэ гэвэл авлигал их байна гэдэг бол ажилгүйдэл, ядуурал, архидалт бий болж байгаа гэсэн үг.

Би тэр ажилгүй байгаа, тэр архидаад байгаа, тэр унхиагүй байгаа хүмүүсийг өмөөрөөгүй. Гэхдээ л төрөөс ажлын байр бий болгох, орлоготой байлгах асуудал дээрээ бид авлигалдуулаад ноль байгаа.

Хоёрдугаар миний асуулт, боловсролын салбарын ажилтнууд дээр үнэхээр сайн ажлууд хийж байгаа. Боловсролын яаман дээр.

Одоо өнөөдөр.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Хүрэлбаатарын Булгантуяа сайд. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд.

Х.Булгантуяа: С.Ганбаатар гишүүний хэлж байгаа үнэн.

Яг энэ бүгдийн үндэс суурь нь ажилгүй, орлогогүй, ядууралтай, архидалттай байгаагийн л гол илрэл нь өнөөдөр энд гарч байгаа.

Түүрүүн энэ мэдээлэл дээр хэлсэн. Хүүхдийн эсрэг гэмт хэрэг, хүчирхийллийн 70 гаруй хувь нь гэр орондоо ойр тойрных нь хүмүүс нь, ах дүү, хамаатан садан нь, хажуу айл нь гээд ийм байдалтай л хүүхдүүд өртөж байна гэдэг бол бид нарын нэн түрүүнд

ядууралтайгаа тэмцэх дээр л ер нь их анхаарах хэрэгтэй юм билээ.

Тэгээд бид үүн дээр ажилгүйдлийн эсрэг манай Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамыг том судалгаа зарласан байна лээ гэж сошиалаар шүүмжлээд байна лээ.

Ер нь С.Ганбаатар гишүүн Үйлдвэрчний эвлэлийн дарга байсан. Маш сайн мэдэж байгаа.

Бид зөндөө их боловсон хүчин бэлдээгүй биш бэлдэж байна. Манай их дээд сургуулийн хамрагдалт сайн байна уу, сайн байна. Ерөнхий боловсролын сургуульд олон хүүхдүүд сайн хамрагдалттай сурч байна уу, сурч байна.

Тэгсэн мөртлөө ажил олгогчдод нь ажилтан олдохгүй. Ажилгүй хүмүүст нь ажил олдохгүй. Тэгээд үүнийг ер нь энэ хөдөлмөрийн зах зээлийн нэг том судалгаа хийж өнөөдөр хувийн хэвшилд битгий хэл төр өөрийнхөө боловсон хүчнийг бэлтгэж авч чадахгүй байна. Манай салбарт хүртэл ийм байна.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бид хөдөлмөрийн зах зээлийн нэлээн томоохон хэмжээний судалгаа хийж, өнөөдөр Боловсролын зээлийн сангийнхаа зээлийг, МСҮТ-ийнхээ хөтөлбөрийг, жижиг дундынхаа зээлийг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зээл, энэ бүгдийг уялдуулахгүй бол үнэхээр хайран байна.

Тэгээд нөгөө харамч хүн хоёр төлнө гэгчээр ийм тооцоо судалгаа байхгүйгээр бодлого гаргаад, мөнгө гаргаад яваад байхаар ерөөсөө байгаа онохгүй байна.

Тийм учраас бид энэ дээр нэг томоохон хэмжээний хөдөлмөрийн

судалгаа хийе гэж сая Үйлдвэрчний эвлэл, ажил олгогч Худалдаа, аж үйлдвэрийн танхимтай байгуулсан гурван талт хэлэлцээр дээр туссаны дагуу хөдөлмөрийн зах зээлийн судалгаа хийж, ажил олголтыг л олигтой дэмжиж байж бид ядуурал, ажилгүйдэл, үүнээс үүдсэн гэмт хэрэг, хүчирхийлэлтэй тэмцэх юм.

Ийм байдлаар бид Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, ялангуяа хөдөлмөр эрхлэлтийг нэлээн дорвитой дэмжье гэдэг ийм байдлаар ажиллаж байгаа. Манай бодлого ч гэсэн энэ рүү чиглэгдэж, **“Халамжаас хөдөлмөрт”** гэдэг том бодлого уягдаж явж байгаа.

Г.Занданшатар: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн 1 минут тодруулъя.

С.Ганбаатар: Гол асуудал бол яг Хөдөлмөрийн яаман дээр ганцааранд нь лаахайдахаасаа илүү, боловсролын салбар дээр ганцааранд нь лаахайдахаасаа илүү одоо жишээ нь ер нь хүүхдүүдээ бид чинь багш нарт лаахайдаад хаячхаж байгаа шүү дээ.

Тэгээд боловсролын салбар, эрүүл мэндийн салбар, тэр хороо хорин, тэгээд л тэр хууль хүчний байгууллагууд бүгд нийлж ажилладаг тэр нэг хороон дээр нэг зөвлөл байдаг юм. Тэрийгээ бид аягүй хүчтэй болгохоос өөр аргагүй байдал руу орчихсон байгаа.

Тэгээд энэ хуулийн хэрэгжилтийн хяналтын тал дээр бид Улсын Их Хурал, холбогдох яам, Тамгын газартай бид хамтарч шинэ шатад нь ажлын хэрэгжилтийг нь хангахгүй бол болохгүй гэдэг энэ саналыг би давхар хэлмээр байна.

Ингээд төсөв, эрх зүйн орчин гэдэг хоёр дээрээ би тодруулж хэллээ. Баярлалаа.

Г.Занданшатар:

Лувсанцэрэнгийн Энх-Амгалан сайд. Сайд, ажлын хэсэг асуух юм уу? Л.Энх-Амгалан сайд.

Л.Энх-Амгалан: Үнэхээр сэтгэл эмзэглүүлсэн харамсалтай зүйл гэвэл үнэхээр энэ л дээ.

Тэгээд түрүүн Ц.Сандаг-Очир гишүүн хэллээ. Хууль цөөдөөгүй гэж. Яг үнэн байгаа юм.

Тэгээд ерөнхийдөө бид баталж байгаа хуулиудынхаа уялдаа, тэгээд хууль өөрөө амьдралаар шалгагддаг учраас тодорхой өөрчлөлтүүдийг нь цаг хугацаа алдахгүйгээр хийгээд.

Тэгээд гол нь энэ санхүүжилтийнх нь эх үүсвэрүүдийг зөв хийдэг, зөв шийдэж өгдөг нэг ийм л хуулиудтай болж байж л бид асуудал шийдэгдэх юм байна л гэж хараад байгаа юм.

Эрүүл мэндийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсролын сайд гээд гурван сайд сар бүхэн энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийнхээ төлөөлөлтэй уулзаад, ер нь Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд өгч байгаа үйлчилгээ, тогтолцоо, санхүүжилтүүд гээд газрын зураглалуудыг бид шинээр хийж үзэж байгаа юм.

Үнэхээр хоорондоо ямар ч уялдаагүй байдаг юм билээ. Одоо бид нарт тэгж харагдаж байгаа юм чинь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үнэхээр маш том зовлон байна гэдэг нь ойлгомжтой шүү дээ.

Яг түүнтэй адилхнаар энэ хүүхдийн эрх, хамгааллын тухай энэ

бодлого, эрх зүйн орчны шинэчлэлээ үнэхээр цаг алдалгүйгээр бид хийе.

Хийхдээ хамгийн гол нь яг оновчтой тийм цогц тогтолцоог бид хийж чадаж байна уу гэдэг их сайн газрын зураглал гаргаж хийх ёстой юм байна. Ингэж бас болох юм байна.

Тэгэхгүйгээр одоо юу гэдэг юм, зүгээр нэг яамны хүүхдийн эрхийн асуудал, нэг яамны, эсвэл хоёр, гуравхан яамны асуудлууд болгоод ингээд орхидог ийм юм байж болохгүй.

Тэгэхээр гол тогтолцооны асуудлууд, энэ хүртээмжийн асуудлууд, санхүүжилтийн зөв тогтолцоо. Тэгээд Монгол Улс бас нэг ийм Монголын төрийн ой санамж гэдэг шиг тоо, мэдээллийн сангуудынхаа юмнуудыг ингээд нэг цэгцэлж авч байж л бодлого зөв уялдаж амьдрал дээр хэрэгжих юм байна л гэсэн нэг ийм л зүйл, ойлголттой байгаад байгаа юм.

Тэгэхээр би яг юу гэж хэлэхийг хүсэж байна вэ гэхээр үнэхээр нэгэнт Их Хурал дээр өргөн баригдчихсан байж байгаа тэр Гэр бүлийн тухай хууль, хүүхэд хамгаалалттай холбоотой хуулиуд, хүүхдийн цахим орчны хамгаалалтын хуулиуд гээд энэ бүх хуулиудаа үндсэндээ нэг ийм багц болгож цаг алдалгүйгээр баталж.

Тэгэхдээ хамгийн гол нь амьдралд хэрэгжих. Тэгээд санхүүжилттэй байх тийм хуулиуд дээрээ л өөрчлөлт хийх нь зүйтэй юм байна. Ингэж байж л бид энэ нийгэмд үүссэн асуудал дээр тодорхой ахиц дэвшлүүд гарах болов уу л гэсэн ийм л бодолтой байгаад байгаа юм.

Г.Занданшатар: Пүрэв-Очирын Анужин гишүүн.

П.Анужин: Баярлалаа. Энд нэг гажуудалтай ойлголт Их Хурлын гишүүд дунд ч гэсэн яваад байна.

Өөрийнхөө хэзээ ч анхаарлаа хандуулдаггүй байсан асуудлаа хэн нэгэн хэзээ ч ярьж байгаагүй мэтээр ингэж ойлгохоо засмаар байна.

Их Хурлын гишүүдийн амнаас хүртэл анх удаа хүүхдийн асуудлыг Улсын Их Хурлын түвшинд ингэж ярьж байна гэж юу ярьж байна аа. Юу ярьж байгаагаа ойлгож байна уу.

Улсын Их Хурлын дэргэд мэргэжлийн Байнгын хороодууд байдаг.

Хүүхдийн асуудлыг эрхэлдэг энэ Байнгын хороон дээр хүүхэд хамгааллын асуудлууд, эх нярайн асуудлууд, хүүхдийн хүнс, тэжээлийн асуудлууд, хүүхэд, тамхинд донтсон асуудлууд, эм тарианы асуудлууд, архины асуудлууд, гэр бүлийн хүчирхийллийн асуудлууд долоо хоног бүр яригддаг.

Бид энэ чиглэлээр ажлын хэсэг байгуулж, эмэгтэй гишүүд толгойлдог шүү. Голдуу ажлын хэсгийг. Эрэгтэй гишүүд энэ асуудлууд яригдахаар Их Хуралдаа, чуулганыхаа хуралд суудаггүй. Яг одоогийн энэ байгаа байдал шигээ. Энд хэдэн эрэгтэй гишүүд яг энэ асуудлыг ярьж байхад сууж байна.

Нийгэмд хүүхдийг тойрсон нийгмийн чанартай асуудлыг гарахаар хэдэн эмэгтэйчүүдийг балбаад, тэр малгайн доор эрэгтэй гишүүд ард үлддэг.

Тийм ч учраас та нар эдгээр асуудалд хүнийрхүү ханддаг. Хүнийрхүү ханддагийн чинь том баталгаа улсын төсөв юм.

Бид үеийн үед энэ хүүхдийн асуудлуудыг тойрч ярьж байсан. Би нэг зүйлийг хэлмээр байна. 2023 оны 3 дугаар сард бид Нийгмийн бодлогын байнгын хорооноос Засгийн газарт тогтоол өгсөн. Ажиллах чиглэлийн тогтоол өгсөн.

Энэ тогтоолын нэгдүгээрт Хүүхэд хамгааллын тухай хуулиа яаралтай өргөн барих тухай бид тодорхой цагаан цаасан дээр хараар бичээд оруулж ирсэн. Бид ажилласан. Ажлын хэсэг 8 сар ажилласан.

Өнөөдөр Х.Булгантуяа сайд мэдээллийн чанартай зүйл хийхгүй байх байсан. Бидний Засгийн газарт өгсөн 20, 30 чиглэлийг ингэж ингэж хэрэгжүүлж байна гэдэг тодорхой зүйлийг ярих байтал Байнгын хороон дээр байнгын асуугддаг мэдээллийн чанартай зүйлээ Улсын Их Хурал дээр орж ирж төөрөгдүүлж байгаа нь энэ том гажуудал.

Хаана байна бид нарын ажилласан, Улсын Их Хурал төсвөө зарсан тэр хийсэн ажил хаана байна. Яаман дээр чинь очоод хүүхэд хамгааллын хуулийг булаагаад авалтай нь биш дээ. Үүнээс илүү Улсын Их Хурал яаж ажиллах вэ?

Бид нарыг энэ хүүхэд тойрсон нийгмийн шинж чанартай эмзэг асуудлыг ярьж байхад нэг ч медиа байдаггүй. Медиад бид үүнийг яриад байна гэхийг түгээхийн тулд асар их мөнгө, зардал хэрэгтэй. Ийм зардал мөнгө чинь Улсын Их Хуралд байдаггүй.

Тэгэхээр яах ёстой вэ. Хэн түрүүлж нийгмийн асуудал болгож орилсон нь анх удаа анхаарал хандуулж байна гэж ингэж жүжиглэж шоудаж байх уу бид.

Өнөөдрийн Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны сайдын мэдээлэл үнэхээр хангалтгүй. Бид нарт мэдээлэл хэрэггүй. Наадхыг чинь танай сайтаас уншина.

Тэгэхээр ажлаа хий. Хуулиа оруулж ир гэдгийг хэлмээр байна.

Юу асуух юм, энд өнөөдөр. Асуудгийг чинь Нийгмийн бодлогын байнгын хороон дээр хийчихдэг шүү дээ. Долоо хоногт хэчнээн удаа. Ингэж болохгүй гэдгийг хэлье.

Эцэст нь хүүхдийн асуудал ээж хүний асуудал биш. Хүүхдийн асуудал ээж, эцэг хүний асуудал. Сайн гэр бүл байж чадахгүй байж болно. Сайн эцэг, эх байх ёстой шүү. Сайн эцэг байх үүрэг эрхтэй хүн бүхэнд бий.

Хүүхдийн асуудал, сэтгэлийн бүрэн бүтэн асуудал гэдэг бол хүүхдийн сургуулийн нөхөн төлбөр биш шүү, эрчүүд ээ.

Нүд нь бүлтэлзсэн хүүхдүүд чинь гэрээ хаяад явчихаар гэмт хэрэгт 5.7 хувиар илүү эрсэддэг юм. Үүнийг мэдэж ав. Гишүүд ээ.

Төсвийн өмнө Та бүхэн хүүхдийн асуудалд илүү дотно ханд аа. Эргээд тойрог дээрээ очихдоо та нар эмэгтэйчүүд, хүүхдийн төлөө ярьсан хуулийг л илүү ярьж оноо авдаг шүү гэдгийг чинь би ахиад энд хэлмээр байна. Асуулт байхгүй. Надад.

Г.Занданшатар: Сонгинохайрхан дүүргийн 107 дугаар цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эрхэм хүндэт багш, ажилчид, сурган хүмүүжүүлэгчдэдээ соён гэгээрүүлэх, хүүхдүүдийг сурган хүмүүжүүлэх үйлсэд нь өндрөөс өндөр амжилтыг хүсэн ерөөе өө. /алга ташив/

Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Баярлалаа. Хүрээлэн буй орчны хүүхэд хамгаалал, тэр дотроо дэд бүтэц, одоо цахим орчин, гэр бүлийн орчны, боловсролын орчны гээд энэ хүүхэд хамгааллын бүхий л асуудал хүүхдэд ээлтэй, хүүхдийн эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлсэн байх ёстой гэдгийг хүн бүр бүгдээрээ л мэдэж байгаа.

Гэтэл энэ ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш өнөөдөр хүүхдэд ээлтэй орчныг бүрдүүлж чадаагүй гэдгийг Та бүгд өнөөгийн энэ нөхцөл байдлаас үндсэндээ харж байгаа байх.

Хүүхдийн ээлтэй гэхээсээ илүү, бараг хатуу үгээр хэлэх юм бол хүүхдийн эсрэг ээлгүй нийгэмд амьдарч байна гэдгийг өнөөдрийн цаг үе бидэнд харуулж байна.

Х.Булгантуяа гишүүний хэлээд байгаа тэр ужгирсан ядуурал, ажилгүйдэл хүүхдийн нуруун дээр үнэхээр дарамт үзүүлж байна. Энэ дээр цогц бодлого, арга хэмжээ авах ёстой.

Боловсролын ялгаатай орчин, үе тэнгийнхний ялгаварлан гадуурхалт, ээлгүй орчин, дэд бүтэц, амьдрах нөхцөл, хүчирхийлэл, айдас, ганцаардал, хүүхдийн өвчин гээд хүүхдийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа маш олон асуудлыг цогцоор нь бид ойлгож, арга хэмжээ авах цаг үе нь аль хэдийн болсон.

Тэгээд өнөөдөр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төсвийн төлөвлөлт ер нь хангалтгүй байгаа гэдгийг илтгэж байгаа л даа.

Тэгээд авлигын эсрэг гэмт хэргийн улмаас төрд учирсан хохирлын эргэн төлөлт 2 их наяд гэж миний хувьд ойлгосон. Тэгвэл үнэхээр энэ төсөв нь хүрэлцэхгүй байгаа бол энэ төрд учирсан хохирлын төлбөрийг хүүхдийн төлөө зарцуулах ёстой шүү дээ.

Энэ дээр би Хууль зүйн яам, Б.Энхбаяр сайд, мөн Х.Булгантуяа сайд хамтраад энэ шийдлээ гаргах боломжтой гэж харагдаж байгаа.

Төсвийн төслөөс харахад энэ авлигын эсрэг гэмт хэргийн улмаас төрд учирсан хохирлын эргэн төлөлт ч байдаг юм уу, эсвэл хэрэг зөрчлийн торгууль, шийтгэлийн орлого жилд ер нь хэр байдаг юм бэ? Энэ төсвийн төлөвлөлт дээр ерөөсөө харагдахгүй юм билээ.

Тэгээд сайдын мэдээллээс харахад нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа ер нь зайлшгүй шаардлагатай өрхөд амьдарч байгаа 460 мянга 344 хүүхэд буюу нийт хүүхдийн 35.4 хувь байна. Энэ бол маш том тоо. Энэ дээр ерөөсөө л цогц арга хэмжээ авахгүй бол болохгүй гэдгийг илтгэж байгаа тоо.

Тэгээд сая эмэгтэй гишүүд нэлээн хэлж байна л даа. Ер нь гишүүд хамтарч байгаад 2021 оны 3 дугаар сард энэ хүүхэд хамгааллын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг өргөн барьсан байгаа. Өнөөдөр хэлэлцэгдэж эхлээгүй байгаа нь үнэн.

Гэхдээ миний ойлгож байгаагаар дан ганц хууль эрх зүйн орчныг сайжруулснаас энэ бүх зүйл арилж алга болохгүй. Хууль хэрэгжүүлдэг төрийн

холбогдох байгууллагууд ажилдаа эзэн болж ажиллах ёстой.

Тийм ч учраас Сэлэнгэ аймагт улсын хэмжээнд ер нь анх удаа гэж байгаа шүү. Анх удаа энэ Хүүхэд хамгаалал, хөгжлийн сургалтын төв, мөн Нөхөн сэргээх, хүүхэд хамгааллын төвийг би цогц байдлаар шийдэхээр санаачилга гаргаж улсын төсөв дээр оруулаад. Уг нь энэ жил ашиглалтад орох байлаа.

Барилга нь баригдчихсан. Гэтэл төсвийн төлөвлөлтийг нь иж бүрэн хийгээгүйгээс хойшлогдох байдал үүсээд байгаа. Энэ дээр Х.Булгантуяа сайд анхаарах хэрэгтэй.

Энэ бол улсын хэмжээнд анх удаа Сэлэнгэ аймагт хийгдэж байгаа төсөл шүү.

Тэгээд Сангийн яам, холбогдох шат шатын төрийн байгууллагууд ингэж хүүхдийн төлөөх ажилд хайнга хандаж болохгүй ээ. Ийм сэтгэлгүй байж болохгүй.

Дараагийн нэг асуудал, хүний мөн чанар, ёс зүй, ёс суртахууны хэм хэмжээ алдагдсанаас болж.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт хангалтгүй байгаа юм л даа. Хүрэлбаатарын Булгантуяа сайд товч хариулъя. 1 минут.

Х.Булгантуяа: Д.Өнөрболор гишүүний тойрогтоо санаачилж хийж байгаа энэ төвүүд их чухал байгаа юм.

Сая орон нутгаар ажиллаж байхад ахмадын төв байгуулмаар байна. Залуучуудын төв, Хүүхдийн ордон, Эмэгтэйчүүдийнх гээд насны сегментээр биш Иргэд, хөгжлийн төв гээд манай

нийт хүүхдүүд ер нь 12 хувь нь л хөгжлийн хөтөлбөрт сургуулиас гадна хамрагдаж байна гэж байна.

Тэгэхээр бид ганцхан хамгаалал өнөөдөр яриад байх биш хөгжлийн асуудлыг бас давхар хөндөхөд аймаг орон нутгуудад төвүүдийг байгуулахаар манай яамнаас жишиг зургийг нь гаргаад ирэх оноос авхуулаад улсын төсөв дээр тавиад явж байна.

Би жишээлбэл өөрийнхөө тойрог дээр нэгийг байгуулах гэсэн чинь соёлын төвтэй андуурагдаад нөгөөдөх нь өнгөрсөн оны төсвөөс жишээлбэл хасагдчихсан. 2022 оны төсвөөс.

Тэгэхээр ийм төвүүдийг барьж байгуулж байж энд иргэд, олон нийт өөрсдөө. Үнэнийг хэлэхэд насанд хүрсэн гэр хороололд амьдарч байгаа ажилгүй хүн ерөөсөө гэрээсээ гараад худаг явдаг юм байна. 8 нэрийн барааны дэлгүүр, нүүрсний цэг. Тэгээд сургууль, цэцэрлэг рүү хүүхдээ хүргэж өгөх гэж очдог.

Зөв боловсон цагаа өнгөрөөх ийм барилга байгууламж.../минут дуусав/

Г.Занданшатар: Ер нь яах вэ, Хүүхэд хамгааллын хуулиа сайн судалчих хэрэгтэй байгаа юм.

2021, 2022 онд өөрчлөлт ороод, 2022 онд оруулсан өөрчлөлтөөр Монгол Улсын хэмжээнд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан, сум, орон нутгийн хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан байгууллага нь нутгийн өөрөө удирдах байгууллагатай зөвшилцөн сум, баг, дүүрэг, хороонд хүүхдийн асуудал хариуцсан нийгмийн ажилтан ажиллуулна.

Нийгмийн ажилтны ёс зүйн дүрэм, түүнд тавих шаардлагыг тухайн асуудал

эрхэлсэн Засгийн газрын гишүүн, мэргэжлийн холбоотой зөвшилцөж батална.

Нийгмийн ажилтан хүүхэд эрсдэлт нөхцөлд байгаа талаарх мэдээллийг хүлээн аваад тухайн газар дээр нь очиж шалгана. Тухайн хүүхэдтэй нөхцөл байдлын талаар ярилцана. Хуулиар хориглоогүй мэдээлэл цуглуулж цагдаагийн байгууллагад өгнө. Нийгмийн ажилтан амь нас, эрүүл мэндэд аюултай нөхцөлд байгаа хүүхдүүдийн эрсдэлт нөхцөл байдлын үнэлгээ хийж шаардлагатай болсон тохиолдолд цагдаагийн байгууллагын туслалцаа авна. Нийгмийн ажилтныг ажиллах нөхцөл бололцоогоор хангах үүргийг сум, баг, хорооны Засаг дарга хариуцна. Ингээд хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилт энэ тэр гээд ингээд хуульд бүх юм нь байгаа байхгүй юу. Хэрэгжүүлэх асуудал нь л байгаа. Ерөөсөө.

Д.Өнөрболор гишүүн тодруулж асууя. 1 минут. Дамдинсүрэнгийн Өнөрболор гишүүн.

Д.Өнөрболор: Баярлалаа. Сая уг нь Б.Энхбаяр сайд энд байсан юм.

Миний хэлсэн тэр авлигын эсрэг гэмт хэргийн улмаас төрд учирсан хохирлын 2 их наядыг энэ хүүхдэд зарцуулахад анхаарлаа хандуулах нь зүйтэй байх аа, Х.Булгантуяа сайд аа.

Дараагийн нэг асуудал нь, энэ хүний мөн чанар, сая тэр ёс суртахуун, ёс зүйн хэм хэмжээ алдагдсанаас болоод нийгэм, гэр бүлийн болон хүүхдийн эрхийн асуудал маш ноцтой эмзэг асуудал болж хувирч байна.

Тэгэхээр Засгийн газар, тэр дундаа Боловсролын яамнаас Л.Энх-Амгалан сайд мянган сэтгэл зүйч бэлтгэсэн

мэдээлэл маш сайн үзүүлэлт гэж миний хувьд үзэж байгаа.

Сэтгэл зүйчийг ер нь анхан шатдаа, баг, хороо, сумддаа. Ядаж. Х.Булгантуяа сайд аа, суманд ядаж 2 сэтгэл зүйч бэлтгэх ажил маш чухал шүү.

Сая Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтраад манай Сэлэнгэ аймагт бид сэтгэл зүйч бэлтгэх сургалтуудыг хамтарсан багт хийсэн. /минут дуусав/

Г.Занданшатар: Зүйтэй. Хүүхэд хамгааллын хуульд сэтгэл зүйчийг ч гэсэн заасан байгаа. Сайн байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайд Баттөмөрийн Энхбаяр яаралтай ажил гараад, би чөлөө өгөөд явуулсан байгаа шүү.

Би тэгээд завсарлуулах гэснээ энэ олон хүнийг ахиад нэг цаг хүлээлгээд яах вэ гэж бодоод. 13.00 цагаас даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Шуурхай хуралдчихъя гэж бодож байна.

Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дээр зохион байгуулагдаж байгаа “ШИНЭ СЭРГЭЛТ-МАЛ АЖ АХУЙ” үндэсний чуулганд Ховд аймгаас оролцож байгаа залуу малчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Монголын нүүдлийн соёл иргэншлийн өвийг тээж, залгамж халаа нь болж байгаа залуу малчдадаа нутаг орондоо эзэн болон суугаад, адуу малаа адуулаа эрхэлж, төрийн сүлддээ залсан энэ морин сүлдээ дээдэлсэн малчин удамт Монгол заяаг үргэлжлүүлж байгаад нь баяр хүргээд, амжилт хүсье ээ. /алга ташив/

Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Ингээд почирдсон, сэтгэл сэртхийлгэсэн үйл явдлын дараа бүгдээрээ араас нь яваад баймааргүй байна.

Өнөөдөр анх удаа ийм сонсгол болж байгаа ч юм биш. 2016 оноос хойш яг энд сууж байгаа Г.Арсланбаяр дарга, Н.Баярмаа дарга бүгдээрээ өнгөрсөн 2016-2020 онд 7, 8 удаа яг ийм уулзалт хийгээд Та бүхний уялдаа холбоог хангая, хэн хэн юугаа хариуцах юм, бид нараас, хууль тогтоогчдоос юу шаардах юм гээд бүгдээрээ үүрэг даалгавар авсан.

Авсан үүрэг даалгавраа бидний хувьд биелүүлсэн. 320 саяхан төгрөгийн хүүхэд хамгааллын төсөвтэй байсныг би Төсвийн байнгын хороон дээр ажлын хэсгийг нь ахлаад, бүх эмэгтэй гишүүд ороод, манай эрэгтэй гишүүд чинь ороод бид 2017 оноос эхлээд л тэрбум тэрбумаар нь нэмээд өнөөдөр яг хүүхэд хамгааллын төсөв нь 8 тэрбум, урсгал зардалтайгаа нийлээд 12 тэрбум төгрөг байгаа.

Сая хэлж байна. Хууль хангалттай байгаа. Гэтэл яг зохион байгуулалтын ажлаа та нар хийхгүй байна шүү дээ.

Одоо Х.Булгантуяа сайд ажилдаа ор. Ийм хэрэг гарсны хоёр хоногийн дараа орж ирчхээд энд ингээд яриад суумаар суумааргүй байна.

Би зөвхөн Чингэлтэй дүүрэг дээр ярихад манай дүүрэг 170 мянган хүн амтай. Түр оршин суугчидтайгаа нийлээд.

Гэтэл энд Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар нь 15-хан бүтэцтэй. 20 мянган өрхөд ганцхан мэргэжилтэн нь оногдож байна. 10 мянган хүүхдэд бас

ганцхан хүүхдийн эрхийн байцаагч оногдоод явж байна.

Гэтэл тэнд халамж, нийгмийн даатгалын бүтцийг нь харахад 60, 70 хүнтэй. Хөл сайтай. Гэхдээ ажил нь болохоор арай хөнгөн байдаг. Гэр бүл, хүүхэд, залуучуудын тэнд ажиллаж байгаа хүмүүс нь дандаа халуун цэг дээрээ очдог учраас үнэхээр амаргүй ажил байдаг.

Гэтэл тэд унаа мал. Түрүүн Ц.Сандаг-Очир гишүүний хэлдэг яг үнэн л дээ. Байдал маш хүнд байгаа.

Би байнга тэд нартайгаа очиж уулздаг. Бүр хүсэлт тавьсны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын байрыг хүртэл төсөвт хөрөнгө мөнгө суулгаад Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтайгаа ярьж байгаад би хийж өгсөн. Одоо харин нийслэлийн хэмжээнд жишиг байр болоод бүр эрчүүдээ хамгаалах өрөө хүртэл сая Н.Баярмаа дарга бид очоод нээсэн.

Бид ингээд юмнуудаа уг нь хийгээд байна. Харин бодлого тодорхойлж байгаа, яам толгойлж байгаа хүмүүс ажлаа хийх хэрэгтэй байна. Газрын дарга нар.

Одоо яг үнэн. Бид өнөөдөр ингээд 14 тэрбумаар төсөв нэмлээ гэж ярьж байна. Гэхдээ үүнийг юунд, яаж хуваарилах юм гэдэг чухал байна л даа. Өнөөдөр анхан шат дээр хөлгүй байна шүү дээ.

Тэгэхээр яаж хүний нөөцийг нэмэгдүүлэх вэ, яаж энд ажиллах хүмүүсийг нь бий болгох вэ. Хүүхдийн эрхийн байцаагчийн орон тоог би одоо 2024 оны төсөв дээр 30-аар, 40-өөр, 50-иар нэмээд орж ирж байгаа энэ зардал нь ийм байгаа. Үүнийг та бүхэн минь

дэмжээд өгөөч ээ гээд уг нь сууж байх ёстой шүү дээ.

Тэгэхэд чинь хүүхдийн үхлээр юм уу, эсвэл зарим нь бүр улс төр хийгээд, тэр лүүгээ эмэгтэй улс төрчид, эмэгтэй парламентчид руу хүртэл нэр хүндийг нь унагаах Пи Ар хийгээд явж байна шүү дээ.

Хүүхдийн үхлээр улс төр хийж болохгүй. Энэ хүчирхийллийн эсрэг бид үнэхээр хүчтэй тэмцэх ажлыг хийгээд байгаа хэрнээ өсөөд байна шүү дээ. Яамныхан.

Бүр 15.7 хувиар өсчихлөө гээд ингээд статистик яриад сууж байна. Архидалт, ядуурал гол үндэс юм байна гээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Мэдээллээ сонсоогүй юм уу. Орж ирж байгаа гэж ярьсан шүү дээ. Юмаа сонсож бай.

Хүрэлбаатарын Булгантуяа сайд хариулъя.

Х.Булгантуяа: Бүтэц нэмэгдэхээр орж ирээгүй. Яг одоогийн үйл ажиллагааныхаа төсөв дээр ялангуяа хүүхэд хөгжил, хамгаалал руу.

Одоо манай төсвийн ихэнх нь хүүхэд хамгаалал руу. Дээрээс нь нэмээд хүүхэд хамгаалалдаа ч чадан ядан хүрч байгаа учраас хүүхэд хөгжил рүү жоохон нэмж оруулах юм сан.

Ер нь нийт хүүхдийн ерөнхий боловсролын сургуулийн хамрагдалт нь сайн байгаа ч гэсэн хүүхдийн 12 хувь нь л хөгжлийн үйл ажиллагаанд оролцож байна гэсэн.

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор бид ирэх онд ялангуяа энэ соён

гэгээрлийн, мэдээлэл сурталчилгааны ажлыг нэлээдгүй хийе, олон нийтийн оролцоог хангая, хуулиа сурталчилъя гэдэг ийм байдлаар.

Дээрээс нь нэмээд одоо байгаа өөрийнхөө бүтцээ ч гэсэн бид бүрэн санхүүжүүлж чадахгүй байгаа. Энэ дээрээ л нэмэлт санхүүжилтүүдийг олгоё гэдэг байдлаар оруулж ирж байгаа.

Хүүхэд хамгааллын тухай хуулийг хаврын чуулганаар өргөн барих гээд байна. Нийгмийн бодлогын байнгын хороон дээр Нийгмийн даатгалын багц хууль гээд том хууль явж байсан.

Хавар үүнийг батлагдаж, хэлэлцэгдэж амжихааргүй байгаад байна. Өргөн бариагүй байсан учраас гээд. Би хавар Нийгмийн даатгалын багц хууль, дээрээс нь нэмээд төсвийн тодотгол, төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, хүүхдийн мөнгө, нэн шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асрамжийн тэтгэмж гэх мэтчилэн эдгээр санхүүжилтүүдийг шийдэх дээр фокуслалаа.

Гэхдээ би одоо энэ хүүхдийн асуудал дээр манай бүхэл бүтэн салбарын бүтэц, зохион байгуулалт байна. Үүн дээр Улсын Их Хурлын гишүүдтэйгээ, холбогдох төрийн байгууллагуудтайгаа хамтран онцгой ач холбогдол өгч ажиллана.

100 жилийн түүхтэй боловсролын салбарт өнөөдөр алдаа оноотой байгаа. Манай хүүхэд хамгаалал бол хууль нь, боловсон хүчин нь, эрх зүй нь бий болоод дөнгөж 2016 оноос хойш бий болоод 7, 8-хан жилийн нүүрийг үзэж байгаа.

Тэгэхээр алдаатай оноотой, уялдаа хангагдаагүй зүйлүүд байгаа. Би тэрийг хүлээн зөвшөөрнө. Би ч гэсэн өөрөө сул

гишүүн байхдаа, би гишүүн болоод 3 жил болохдоо бас энэ асуудал дээр өмнөх сайд нарт бухимдалтай л ханддаг байсан.

Тэгэхээр энэ бүгд дээр би ажил хэрэгч саналыг хүлээж авна. Тэгээд үүн дээр хамтран ажиллахад бэлэн.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж. М.Оюунчимэг гишүүн 1 минут. Тодорхой юм асуу. Тодруулж асууна.

М.Оюунчимэг: Энэ хүүхэд хамгааллын асуудал дээр маш тодорхой юм асууж, маш тодорхой хариултыг нь хэлдэг л дээ.

Одоо нэг жилийн дараа Хөвсгөл аймагт 8 настай охиныг маш ноцтой хэрцгийгээр хөнөөсөн хүн суллагдах гээд байж байна шүү дээ.

Тэгэхээр энэнээс өмнө бид одоо энэ хуулиа гаргахгүй бол. Саяын энэ сүүлийн кэйс ч гэсэн бас л яг энэ хүчирхийлэхээр үйлдэх завдсан гэдгээр 5 жил авчхаад гарч ирээд яг энэ асуудлаа хийж байна шүү дээ.

Тэгэхээр хууль чангатгах юмнуудыг нь үнэхээр Б.Энхбаяр сайд түрүүн шууд хийнэ гэж хэлж байна лээ. Их Хурал ч гэсэн ингэж хурдлаад үүнийг яаралтай арга хэмжээ авахгүй бол энэ бол ноцтой байна шүү.

Бид эмэгтэй гишүүд Х.Булгантуяа сайдыг ажил авсны дараа яаман дээр нь очиж байгаад яг энэ хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийн нэмэлт, өөрчлөлт, Гэр бүлийн тухай хуулиудыг яаралтай оруулж ирээрэй. Бүгдээрээ хамтарч ажиллая гэсэн.

Тэгэхээр үүнийгээ бүгдээрээ одоо хамтдаа хийе гэж уриалмаар байна.

Тэгээд түрүүн Б.Энхбаяр сайдын хэлдгээр нээрээ олон нийтийн сүлжээгээр янз янзын юм уриалж ингэж явуулаад байгаа нь өөрөө сэдэл өгөөд бас ноцтой.../минут дуусав/

Г.Занданшатар: Ш.Адъяаа гишүүн, С.Чинзориг хоёр гишүүн байхгүй байна. Хаслаа.

Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хүүхэд хамгааллын асуудлаар мэдээллийг сонслоо.

Тэгээд гишүүд одоо “би” гэж бага ярьж, “бид” гэж хамтарч ажиллаад сая яригдсан асуудлуудыг ажил хэрэг болгоно.

7 сарын 05-ны өдрийн хяналт, сонсголын тайлан байна.

Хүүхдийн хамгаалуулах эрхийн хэрэгжилтийг хангах хүрээнд зохион байгуулах, хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголын тайланг уншиж үзэцгээ гээд санавал манай Б.Баярсайхан гишүүн, Г.Амартүвшин гишүүн, А.Аубакир гишүүн, Д.Батлут гишүүн, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Н.Наранбаатар, Д.Өнөрболор, Б.Саранчимэг, Т.Энхтүвшин нарын гишүүдээс.

Дийлэнх нь эрэгтэй гишүүд байгаа шүү. Бас энэ чинь. Эрэгтэй, эмэгтэй гэж яриад байх ерөөсөө шаардлагагүй.

Бадарчийн Жаргалмаа гишүүн томилоод. Өөрсдөө тийм юм яриад байгаа учраас би хэлж байгаа юм.

Сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Бадарчийн Жаргалмааг

томилж ажиллуулаад, эндээс Цагаанхүүгийн Идэрбат, Ц.Сандаг-Очир, Д.Батлут нарын гишүүд үг хэлж, санал гаргаад. Үүний дагуу П.Анужин гишүүн, Мөнхжаргал гээд хүмүүсийн санал бодлыг үндэслээд Байнгын хорооны тогтоол гарсан байна.

Энэ дээр Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хохирогч хамгааллын бүтэц, тогтолцооны зураглалыг гаргах, байгууллагуудын чиг үүрэг, бүтэц, үүргийн давхцалыг арилгах, уялдаа холбоог хангах, шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэх гээд. Энэ шаардлагатай санхүүжилтийн асуудал энэ тэрийг тэр үед шийдвэрлэх юмнууд гарсан байна.

Тэгэхээр Улсын Их Хурал өнөөдөр гэнэт ярьж байгаа асуудал биш.

Сүүлийн хоёр жилд хүүхэд хамгааллын асуудлаар удаа дараагийн сонсгол, хэлэлцүүлгүүд зохион байгуулж, холбогдох Байнгын хорооны тогтоол, Улсын Их Хурлын тогтоол хүртэл батлан гаргасан байна.

Үүнийхээ хэрэгжилтийг л хангаж шаардах хэрэгтэй.

Хүүхэд хамгааллын тухай хуульд нийгмийн ажилтны асуудал заачихсан байна. Энэ бүх асуудлуудаа хэрэгжүүлэх шаардлагатай.

Тэгээд өнөөдрийн ярьсан асуудлуудаар нэгдүгээрт ажлын 5 хоногийн дотор Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн, Балжиннямын Баярсайхан нарын гишүүдийн гаргасан саналын дагуу хүүхдийн эрхийн асуудлаар, хүний эрхийн асуудлаар.

Сонсгол бол тусгай дэгээр зохион байгуулагддаг учраас хүүхдийн эрхийн асуудлаар сонсгол зохион байгуулахыг Байнгын хороо шийдвэрлэх ёстой. Нийгмийн бодлогын байнгын хороо ирэх долоо хоногийн нэг дэх, хоёр дахь өдөртөө багтаагаад гэсэн үг болох нь.

Нэг дэх, хоёр дахь, гурав дахь өдөртөө. Одоо даргын дэргэдэх зөвлөл хуралдана. Тэнд хэлэлцэх асуудлын товд оруулж яг тодорхой асуудлуудаар.

Одоо ерөнхий хэлэлцүүлэг зохион байгуулагдлаа.

Яг тодорхой асуудлуудыг тодорхой болгож, төсөв мөнгө, хүн хүч, тэгээд агуулга, бүтэц, зохион байгуулалтын асуудлаа нарийвчлан болгож. Тэгээд хэрэгжсэн, хэрэгжээгүйг нь гаргаж, шаардлагатай бол хариуцлага тооцож ажиллах хэрэгтэй.

Хоёрдугаарт нь, Хууль зүйн байнгын хорооныхондоо чиглэл өгөөд, одоо энэ давтан гэмт хэрэг үйлдээд байгаа гаж донтой, хүүхдийн эрх, эрх чөлөөний төлөө гэмт хэрэг өдүүлдэг энэ хүмүүсийн жагсаалтыг гаргаж хар жагсаалтад оруулж, ёстой тэр нөгөө цахим гав зүүж хөдөлгөөнийг хязгаарлаж байгаа шүү дээ. Тийм ээ. Энэнээс авхуулаад шаардлагатай бүх хууль эрх зүйн арга хэмжээ авах хэрэгтэй.

Одоо согтуу жолооч нарт эрүүгийн хэрэг үүсгэдэг байсан. Хуучин Эрүүгийн хуулиар. Энэ чинь хутга зэвсэг бариад гудамжаар гүйж байгаа согтуу хүнтэй ялгаагүй шүү дээ.

Ийм учраас энэ согтуу жолооч нарт хатуу хариуцлага тооцох хэрэгтэй.

Замын нөхцөл байдал маань ямар билээ. Гэрэлтүүлэг ямар билээ. Одоо энэ

хүмүүс чинь ингээд. Нэн ялангуяа сургуулийн орчимд хүүхдүүдийг дайрч алаад байна.

Энэнээс авхуулаад тэр ялын бодлогыг чангатгах асуудлаа харин Улсын Их Хурлаар цогц хууль болгож гаргахад нь анхааръя.

Энэ яригдсан саяын холбогдох байгууллага дээр ирсэн саналуудыг нэгтгээд яг ажил хэрэг болгох ажлын хэсгийг байгуулж, зөвлөл байгуулж ажиллая.

Энэ дээр Нийгмийн бодлогын байнгын хороон дарга П.Анужин санаачилгатай ажиллаж байгаа.

П.Анужин дарга аа, Пүрэв-Очирын Анужин дарга энэ дээр санаачилгатай ажиллаж байгаа. Энэ ажлын хэсгийг ахлаад ингээд ажлаа хийнэ.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо, Нийгмийн бодлогын байнгын хороо хамтарч энэ бодлогыг гаргаад, ажлын хэсэг гаргаад газрууд дээр нь очиж шалга. Төсөв мөнгөний асуудлыг шийд. Төсвийн ажлын хэсэгт орж ажилла.

Тэгээд загасны ой санамжтай байхгүй. Дараа нь би тэгсэн, би ингэсэн, тэд тэгсэн ингэсэн гэж яриад байхгүйн тулд ахиад ийм хэрэг ёзоор гарахгүй байх шалтгаан нөхцөлийг, эрсдэлт нөхцөл байдлыг устгахад чиглэсэн хүүхэд хамгааллын тогтолцоогоо бэхжүүлэхэд хамгийн гол нь анхаарах хэрэгтэй.

Ингээд чуулганы нэгдсэн хуралдаанаар цаг үеийн шинжтэй асуудлаар мэдээ дээс сонслоо. /алх цохив/

Чуулганы нэгдсэн хуралдаан завсарласныг мэдэгдье. 14.00 цагт Ерөнхий сайдын мэдээллээр үргэлжилнэ.

З А В С А Р Л А Г А

Эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын чуулганы 10 дугаар сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдааны үдээс хойших чуулган эхэлснийг мэдэгдье. /алх цохив/

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар “Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсоно.

Хоёр.Ерөнхий сайдын мэдээлэл:

“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар

“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан Зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар Зам, тээврийн хөгжлийн сайд, Улсын Их

Хурлын гишүүн Сандагийн Бямбацогт мэдээлэл хийнэ. Индэрт урьж байна.

С.Бямбацогт: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлого болон түүний эхний үе шат болох “Шинэ сэргэлтийн бодлого” Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд ачаа тээврийн урсгалыг сайжруулж, Ази, Европыг холбосон транзит тээврийн дэд бүтцийг хөгжүүлэх суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилтыг дэвшүүлсэн.

Энэ хүрээнд тавьсан зорилтуудаа үр дүнтэй, хурдтай, чанартай, бас цаг алдалгүй хэрэгжүүлэхэд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна.

Цар тахлаас үүдэн нэгэн үе царцанги, зогсонги байдалд ороод байсан дэлхийн эдийн засгийн цусны эргэлт хурдсаж хэвийн байдалд шилжлээ. Үүнд тээвэр, логистик, зам харилцаа, дэд бүтэц шийдвэрлэх чухал үүрэг гүйцэтгэж байгаа билээ.

Тиймээс Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн тэргүүлсэн Засгийн газар хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар холбохыг нэн тэргүүнд чухалчилж, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд онцгой анхааран ажиллаж байна.

Монгол Улс 2023 онд Дэлхийн банкнаас гаргасан логистикийн индексээр 30 байраар урагшилж 97 дугаар байрт орсон. Цаашид илүү урагшлах, илүү дэвшихийг бид зорьж байгаа.

Тээвэр бол эдийн засгийн хөгжлийг тэлэх хөгжлийн судас. Зам тээврийн салбар 2019 онд буюу цар тахал гарахаас өмнө бүх төрлийн тээврээр 69 сая тонн ачаа, 2022 онд 61 сая тонн ачаа тээвэрлэсэн байна.

Харин 2023 оны эхний 9 сарын байдлаар бүх төрлийн тээврээр нийт 75 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс ачаа тээвэр даруй 86 хувиар өссөн үзүүлэлт юм.

Агаарын тээврээр 2023 оны эхний эхний 9 сарын байдлаар нийт 1.3 сая зорчигч тээвэрлээд байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад олон улсын зорчигч тээвэр 137 хувиар, орон нутгийн зорчигч 27 хувиар тус тус өссөн байна.

Монгол Улс, Ази, Европыг холбосон транзит улс болохыг зорьж байна.

Энэ хүрээнд манай улс нийт 14 улстай авто тээврийн хэлэлцээрийг байгуулан олон улсын тээвэрлэлт хийх суурь нөхцөлийг бүрдүүлээд байна. Тухайлбал, 2023 оны 6 дугаар сард Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Бүгд Найрамдах Хятад Ард Улсад хийсэн айлчлалын үеэр Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд авто тээврийн хэлэлцээрийг шинэчлэн байгууллаа.

Ингэснээр захиалгат тээвэр буюу аялал жуулчлалын зорилгоор зорчих зорчигч тээвэрлэлтийг 8-аас дээш хүний суудалтай тээврийн хэрэгслээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Бээжин, Тяньжин, Хөх хот болон бусад хотууд руу хийх боломж бүрдээд байна.

Далайн боомтоос, эсхүл далайн боомт руу Хятад Улсын нутгаар дамжин чингэлэг тээвэр хийх нөхцөл бүрдлээ.

Мөн Монгол тээвэрчид Бүгд Найрамдах Хятад Ард Улсын нутгаар дамжин Казакстан, Киргизстан улсуудаар нэвтэрч Европын орнууд руу тээвэр хийх боломж бий боллоо.

Түүнчлэн Европын Холбооны гол транзит улсын нэг болох Польш Улстай авто тээврийн хэлэлцээр байгуулж Европ руу гарах тээврийн гарцаа нэмэгдүүлээ.

Ойрын хугацаанд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс, Гүрж Улс, Узбекистан улсуудтай авто тээврийн хэлэлцээр байгуулахаар эцэслэн тохиролцоод байна.

Мөн ойрын үед Монгол Улсынхаа иргэдэд урд хөршийн Эрээн, Такашикэн, Өрөмч зэрэг хил орчмын бүсийн хотууд руу суудлын автомашинтайгаа зорчих боломжийг нээж өгөхөөр анхаарч ажиллаж байна.

Энэ хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Ерөнхий сайд хилийн боомтуудын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх, ачаа тээврийн терминалуудыг байгуулахад онцгой анхаарал хандуулан ажиллаж байгаа.

Энэ хүрээнд Гашуунсухайтын боомтод жилд 10 сая тонн нүүрс шилжүүлэн ачих хүчин чадалтай чингэлэг тээврийн терминал ашиглалтад орсон.

Мөн тус боомтод жолоочгүй автомат удирдлага бүхий **AGV**_[automated guided vehicles] тээврийг нэвтрүүлж, өдөрт 320 гаруй чингэлгээр ачааг экспортод гаргаж байна.

Түүнчлэн Шивээхүрэн боомтод чингэлэг тээврийн терминалыг шинээр ашиглалтад орууллаа.

Монгол Улс нэгдэн орсон Олон улсын хуурай боомтын конвенцын хүрээнд Замын-Үүд, Улаанбаатар, Алтанбулаг, Цагааннуур, Ховд, Чойбалсан, Сайншанд, Бичигт гэсэн цэгүүдэд хуурай боомт байгуулж,

экспорт, импортыг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэхээр Дэлхийн банк, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ази, Номхон далайн эдийн засаг, нийгмийн комисстой хамтран судалгаа техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлуудыг эхлүүлээд байна.

Энэ бүхний үр дүнд эдийн засаг тэлж, экспортын хэмжээ нэмэгдэн, импортын тээвэрлэлт хурдсаж, тээврийн болон бараа бүтээгдэхүүний үнэ хямдран аялал жуулчлал хөгжих бодит үр дүнгүүд гарсаар байна.

Цар тахлын улмаас үүссэн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн хөөргөдөл санасан хэмжээнд хүртэл буугаагүй байхад харин тээврийн үнэ тариф өртөг зардал хэд дахин буурлаа.

Илүү тодруулж хэлэх юм бол цар тахлын үетэй харьцуулахад тээврийн зардал 7-гоос 8 дахин хямдарсныг энд онц олж хэлье.

Энэ эерэг нөлөө эдийн засагт алгуур боловч үр өгөөжөө өгсөөр байгаа. Агаарын тээврийн либералчлал, хямд тийз, хүртээмжтэй нислэг бодлогыг Монгол Улсын Зам, тээврийн хөгжлийн яам хэрэгжүүлж байгаа.

Монгол Улсын Засгийн газар, Зам, тээврийн хөгжлийн яам агаарын тээврийн либералчлалд онцгой анхаарал хандуулан ажиллаж байна. Эхний бодит үр дүнгүүд ч гарсаар байна.

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан олон улсын болон дотоодын нислэгийн чиглэл, давтамжийг эрс нэмэгдүүллээ.

Өнөөдрийн байдлаар Монгол Улс дэлхийн 42 улстай агаарын тээврийн

харилцааны хэлэлцээртэй болж, дэлхийн 115 цэг рүү шууд нислэг үйлдэх эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлээд байна.

Энэ 2023 онд гэхэд Катар, Грек улстай агаарын тээврийн харилцааны тухай Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгууллаа.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайдын Америкийн Нэгдсэн Улсад хийсэн айлчлалын үеэр **“Open Sky”** хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Ингэснээр сүүлийн 20 жил яригдсан Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улсын хооронд шууд нислэгтэй болох асуудал бүрэн шийдэгдэж байгаа.

Ийнхүү шууд нислэгтэй болсноор тийзийн үнэ одоо байгаагаас хоёр дахин хямдарч 1000-аас 1500 орчим доллар болно. Мөн нислэгт зарцуулах хугацаа 10-аас 12 цаг болж, 30-аас 40 цаг нисдэг нислэгийн хугацаа 10-аас 12 цаг болж богиносгох юм.

Ирэх оны эхний хагаст багтаж эхлээд Америкийн Нэгдсэн Улсын Сан-Франциско хот руу, цаашдаа боломжит бүх хотууд руу болон Америкийн Нэгдсэн Улсаас Монгол руу нислэг үйлдэх ийм бололцоонууд бүрдэнэ.

Ойрын үед Кувейт, Унгар, Их Британи, Испани, Латви улстай агаарын харилцааны хэлэлцээр байгуулахаар бид ажиллаж байна.

Мөн монголчуудын маань хамгийн ихээр оршин сууж байгаа улс орнуудын нэг болсон Австрали Улстай бас **“Open Sky”** хэлэлцээрийг байгуулж, шууд нислэгтэй болох ажилд анхаарал хандуулан чухалчилж ажиллаж байна.

Эдгээр хэлэлцээрүүдийг байгуулснаар дэлхийн гол агаарын

тээврийн зангилаа цэгүүд рүү ямар нэгэн хязгаарлалтгүйгээр шууд болон аяллын дугаар хувааж ашиглан нислэг үйлдэх, зорчигч, жуулчдад ая тухтай хямд зардлаар аялах боломж бүрдэнэ.

Өнгөрөгч зун манай улс жуулчдын хөлд дарагдсан. Энэ үед манай зам тээвэр, тэр дундаа агаарын тээврийн салбар ирсэн зочдоо унаа хүлгээр улдааж явгалахгүй байх үүргээ нэр төртэйгөөр гүйцэтгэсэнээ онцолж энд хэлье.

Тухайлах юм бол Бүгд Найрамдах Солонгос Улстай агаарын тээврийн харилцааны хэлэлцээ хийж, Монгол, Солонгосын хооронд долоо хоногт 10 нислэг хийдэг байсан бол 70 нислэг буюу өдөрт дунджаар 10 нислэг үйлдэх эрх зүйн боломжийг бүрдүүлж, аялал жуулчлалын оргил ачааллын үед өдөртөө 12 хүртэл нислэгийг хийсэн.

Мөн Япон, Монголын хооронд долоо хоногт 61, Монгол Туркийн хооронд долоо хоногт 28 нислэг үйлдэх эрх зүйн боломжийг бүрдүүлж, агаарын харилцааны хэлэлцээр тус тус шинэчилсэн нь зорчигч урсгалыг нэмэгдүүлж, аялал жуулчлал, худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэхэд бодитой үр дүнгээ өгч байна.

Энэ онд үндэсний агаарын тээвэрлэгч **“МИАТ”** компани дэлхийн хамгийн сүүлийн үеийн технологиор бүтээгдсэн Бойнг-700-87-900 агаарын хөлөг хүлээн авч нислэгийн үйл ажиллагаанд ашиглаж эхэлснээр Монголоос дэлхийн аль ч цэг рүү шууд нисэх боломж бүрдлээ.

Ирэх оны 6 дугаар сар гэхэд **“МИАТ”** компани агаарын хөлгийн тоогоо 10 болгон нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Хөдөөгийн сэргэлтийн хөтөч орон нутгийн нислэг амжилттай сэргэсэн. Орон нутгийн 8 чиглэлд нислэг сэргээсэн онгоцны тийзийг 2-оос 2.5 дахин хямдрууллаа.

Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанаар орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулах, үнэ тарифыг бууруулах асуудлыг хэлэлцэн дэмжсэн.

Засгийн газрын 2023 оны Орон нутгийн чиглэлд нислэг үйлдэх арга хэмжээний тухай 201 дүгээр тогтоолоор “МИАТ” компани 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн орон нутгийн 9 чиглэлд зохих нөхөн олговортойгоор нислэг үйлдүүлэхээр шийдвэрлэсэн.

Энэ дагуу “МИАТ” компани 2023 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Өлгий, Ховд, Улиастай, Улаангом, Алтай, Мөрөн, Чойбалсан, Даланзадгад чиглэлд амжилттай нислэг үйлдэж байна.

2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар орон нутгийн нислэгээр нийтдээ 310 мянган зорчигч тээвэрлээд байна.

Монгол Улсын Засгийн газраас агаарын тээврийн либералчлалын хүрээнд орон нутгийн нисэх буудлуудын хүчин чадлыг сайжруулахыг зорьж байна.

Тухайлах юм бол “**Өндөрхаан**” нисэх буудлыг “**4С**”¹ ангиллын нисэх буудал болгох төслийг “**Кувейтийн сан**”-гийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна.

Мөн аялал жуулчлалын гол бүс нутагт байгаа Мөрөн, Гурвансайхан, Ховд, Чойбалсан нисэх буудлуудын хүчин чадлыг нэмэгдүүлж, Олон улсын нисэх буудлын статустай болгож, олон улс руу шууд нисэх боломжийг бүрдүүлэхээр ажиллаж байна.

Экспортын гарц, импортын үүдээ нэмэгдүүлэх төмөр зам.

Бид сүүлийн жилүүдэд өөрсдийн дотоод нөөц бололцоогоо ашиглан хөгжлийн, бас эдийн засгийн судас болсон төмөр замын том төслүүдээ амжилттай хэрэгжүүлж чадсан.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд 1820 километр төмөр зам барихаар төлөвлөснөөс одоогийн байдлаар **960** километр төмөр замын барилгын ажлыг бүрэн дуусгаад байна.

Үлдсэн 860 километр төмөр замын төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэх ажлууд хийгдэж байна.

“**Шинэ сэргэлтийн бодлого**” Үндэсний төмөр замын сүлжээг өргөжүүлэх хүрээнд 2023 онд Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн **233** километр, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн **415** километр, нийт **648** километр төмөр замыг байнгын ашиглалтад оруулаад байна.

Төмөр замын зүүн коридорын бүтээн байгуулалтын хүрээнд Орос, Монголын хилээс Эрэнцав, Баянтүмэн чиглэлийн төмөр замыг шинэчлэн засварлах, Чойбалсан-Хөөт, Хөөтөөс Монгол, Хятадын Бичигт, Зүүнхатавч боомт хүртэлх төмөр замыг шинээр байгуулах бүтээн байгуулалтын томоохон ажлыг эхлүүлэхээр техник,

¹ Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллага (ICAO)-ийн дүрэмд А-320, В-737 зэрэг хөлгүүдийн 1800-1900 метр ба түүнээс дээш урттай хөөрөх, буух зурвасыг **4С** ангиллын зурвас гэнэ.

эдийн засгийн үндэслэл зураг, төсөл боловсруулах ажлыг гүйцэтгэж байна.

Улмаар Эрэнцав-Чойбалсан чиглэлийн төмөр замын шугамыг Чойбалсан, Хөөт, Бичигт чиглэлийн шинээр байгуулах төмөр замын шугамтай холбон төмөр замын зүүн коридорыг байгуулж Орос, Хятадыг, мөн Европ, Азийг холбосон төмөр замын зүүн коридорыг хөгжүүлэх ач холбогдолтой төслийг эхлүүлэх бэлтгэл ажил хангагдаж байна.

Зам тээврийн салбарт 2023 онд Засгийн газрын тогтоолоор концессын зүйлийн жагсаалтад оруулсан Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн баруун босоо төмөр замын коридор, Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн хөндлөн чиглэлийн төмөр замуудын төслүүдийг эхлүүлэхээр төлөвлөж ажиллаж байна.

Мөн **“Шинэ сэргэлтийн бодлого”-ын “Боомтын сэргэлт”-ийн** хүрээнд Монгол, Хятадын хилийн Гашуунсухайт, Ганц мод, Шивээ хүрэн, Сэхээ, Бичигт, Зүүнхатавч төмөр замын боомтуудыг холбох хил дамнасан төмөр замын төслүүдийг эхлүүлээд байна.

Хил холболтын Шивээхүрэн-Сэхээ чиглэлийн 7.1 километр төмөр замын барилгын ажлыг өнгөрөгч 5 дугаар сарын 27-ны өдөр эхлүүлж ирэх 11 дүгээр сард багтаан дуусгахаар ажиллаж байна.

Гашуунсухайт-Ганцмод хил холболтын төмөр замын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулан 9 сарын 28-ны өдөр Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр Зам, тээврийн хөгжлийн яам хэлэлцэн баталсан.

Одоо тус хил холболтын төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг ирэх 2024 онд эхлүүлэхээр төлөвлөж байна.

Монгол, Орос, Хятадын эдийн засгийн коридорын гол зам болох хойд хилээс урд хил хүртэлх Сүхбаатар-Замын-Үүд чиглэлийн төмөр замын төв коридорын хүчин чадлыг нэмэгдүүлэх, хос төмөр замтай болох. Түүний нэг чухал хэсэглэл болох Улаанбаатар хотыг тойрон гарах Богд хаан төмөр замын төслийг мөн хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа болно.

Тус төслийн нарийвчилсан ТЭЗҮ-г боловсруулж Оросын талд хүргүүлсэн бөгөөд төслийн хөрөнгө оруулалтыг Оросын талтай хэлэлцэж байна.

Ингэснээр төмөр замын төв коридорын нэвтрүүлэх чадвар нэмэгдэж, транзит тээврийг хөгжүүлэхэд томоохон түлхэц болох юм.

Манай улс урьд нь урагшаагаа Замын-Үүд гэсэн төмөр замын ганцхан гарцтай байсан.

Харин ойрын жилүүдэд Орос, Монгол, Ази, Европыг холбосон төмөр замын 3 коридор, Алтанбулаг, Улаанбаатар, Замын-Үүд, Арцсуурь, Нарийнсухайт, Шивээхүрэн, Эрэнцав, Чойбалсан, Бичигт гэсэн 3 Ази, Европ, Орос, Хятадыг холбосон коридортой болно.

Мөн Замын-Үүд-Эрэн, Гашуунсухайт-Ганцмод, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүнхатавч, Ханги-Мандал гэсэн экспортын төмөр замын 5 гарцтай болно. Хятад Улс руу. Одоо бол нэг гарцтай байгаа.

Энэ бол Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын санаачилсан

“Шинэ сэргэлтийн 5 цагариг” хөтөлбөрийн төмөр замын салбарт дэвшүүлсэн бодлогын бодит биелэл болж байгаа юм.

Чанартай зам, чансаатай засвар арчлалт.

Зам дагаж хөгжил ирнэ. Бас зам дагаж **“Хөдөөгийн сэргэлт”** бодитоор бий болно.

Монгол Улс нийтдээ 14 мянга 900 километр олон улсын болон улсын чанартай авто замтай.

Цар тахлын өмнө буюу 2019 онд олон улсын болон улсын чанартай авто замд эзлэх хатуу хучилттай замын хэмжээ 46 хувь буюу 6900 километр байсан бол 2022 оны мөн үед 50 хувь буюу 7485 километр хатуу хучилттай авто замтай болж нэмэгдсэн.

Түүнчлэн 2023 онд хүлээгдэж буй гүйцэтгэлээр улсын болон орон нутгийн чанартай 400 километр, тусгай зориулалтын 220 километр, нийт 660 километр хатуу хучилттай замыг ашиглалтад оруулахаар төлөвлөж байна.

Авто замын салбарт 2023 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 755 километр авто зам, барилгын ажил, 230 урт метр төмөр бетон гүүрийн барилгын ажил, гадаадын зээлийн санхүүжилтээр нийт 260 километр авто замын барилгын ажил, мөн 200 урт метр төмөр бетон гүүр, барилгын ажил, төр, хувийн хэвшлийн түншлэлээр нийт 1240 километр авто замын барилгын ажил, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 265 километр авто замын барилгын ажил тус тус хийгдэж байна.

Орос, Хятадыг хатуу хучилттай авто замаар холбосон Азийн авто замын

сүлжээний **“АН-4”** [Asian Highway Network] замын Монгол Улсын баруун бүсээр дайран өнгөрсөн Баруун босоо тэнхлэгийн 745 километр замыг бүрэн ашиглалтад орууллаа.

Энэхүү босоо тэнхлэгийн зам нь Монгол Улсыг урд, хойд хөрш Ази, Европтой холбосон Азийн авто замын сүлжээнд холбогдсон хоёр дахь коридор болж байна.

Саяхан уг чиглэлд Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон Оросын Холбооны Улстай хамтарсан гурван улсын туршилтын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулж транзит тээврийг эхлүүлсэн.

Манай улсын авто замын гол сүлжээ болох Азийн авто замын **“АН-3”** [Asian Highway Network] сүлжээний Улаанбаатар, Дархан чиглэлийн 204 километр зам барилгын ажлыг ирэх сард дуусгаж, 2 урсгал, 4 эгнээ замын хөдөлгөөнийг нээх гэж байна.

Цаашид Дархан-Алтанбулаг чиглэлийн 113 километр авто зам, Улаанбаатар хотоос Замын-Үүд боомт хүртэлх 718 километр авто замуудыг 2 урсгал, 4 эгнээтэй болгож төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

Ингэхдээ одоо байгаа авто замыг ашиглалтад хэвээр үлдээж, иргэдийн зорчих хөдөлгөөнд огтхон ч саад болохгүйгээр бүтээн байгуулалтын ажлыг хийж хэрэгжүүлнэ.

Мөн Монгол, Хятадын хилийн Ханги, Гашуунсухайт боомтыг хатуу хучилттай авто замаар холбох, Таантолгой-Манлай-Ханги чиглэлийн 477 километр, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 250 километр

тусгай зориулалттай авто замын төслийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газраас 2022 онд бүх аймгийн төвийг нийслэл хоттой хатуу хүчтэй авто замаар холбож дууссан.

Ингэснээр 21 аймаг, 96 сум, суурин газар хатуу хүчтэй авто замтай болоод байгаа.

Цаашдаа **“Шинэ сэргэлтийн 5 цагариг”** хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд бүх аймгийн төвийг хооронд нь авто замаар холбох, урд хойд хөрш, Ази, Европыг холбосон авто замын босоо 5 коридортой болох ажлыг эхлүүлээд байна. Эхлүүлэхээр төлөвлөж байна.

Тус хөтөлбөрийн хүрээнд Бага-Элэнх, Шивээхүрэн, Бургастай, Арцсуурь, Эрээнцав, Бичигт гэсэн авто замын 3 шинэ коридорыг нэмж байгуулна.

Харин хэвтээ чиглэл Цагааннуур, Сүмбэр, Ульхан боомтыг хөндлөн холбосон хэвтээ чиглэлийн 2 коридортой болох юм. Энэ хүрээнд Чойрыг Мандалговьтой, Мандалговийг Арвайхээртэй, Чойбалсанг Баруун-Урттай, Алтайг Улиастайтай, Ховдыг Улаангомтой, Өлгийг Улаангомтой, Улиастайг Мөрөнтэй, Мөрөнг Цэцэрлэгтэй, Улиастайг Ховдтой гэх мэтээр аймгийн төвүүдийг өөр хооронд нь холбосон бүс нутгийн 5 цагариг хатуу хучилттай авто замуудыг барина.

Энэ бүхний үр дүнд манай улс аймгийн төвүүдээ төдийгүй Ази, Европыг холбосон авто замын 5 коридортой болно гэдгийг дахин онцолж хэлье.

Мөн 2024 онд авто замын хөдөлгөөний эрчим ихтэй хамгийн их эвдрэлтэй байгаа Дундговь, Өмнөговь, Хэнтий, Дорнод, Төв, Өвөрхангай, Баянхонгор зэрэг аймгийн нийт 350 гаруй километр авто замд их засвар хийхээр төлөвлөөд байгаа бөгөөд авто замын засвар ашиглалтын стандарт, санхүүжилтийг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллаж байна.

Түгжрэлгүй төрийн үйлчилгээ, иргэддээ ил тод зам тээвэр.

Монгол Улсын Засгийн газраас дэвшүүлсэн **“Шинэ сэргэлтийн бодлого”** тэр дундаа манай зам тээврийн салбарт гарч байгаа өсөлт дэвшил, эерэг өөрчлөлтийн үндсэн шалтгаан нь либералчлал, чөлөөт өрсөлдөөнийг дэмжсэн бодлого, үйл ажиллагааны бодитой үр дүн гэж харж байгаа.

Хэн нэгэнд давуу тал олгодог, бусдад хүнд суртал учруулдаг, авлига ашиг сонирхолд автдаг бусармаг байдлыг халж, адил боломжийг бүгдэд нээлттэй, тэгш олгосны үр дүнд зам, тээврийн салбарт сэргэлт ирж, эдийн засагт өсөлтийг дагуулж байна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын чуулганаар иргэний нисэхийн тухай, Төмөр замын тээврийн тухай салбарын гол тулгуур хуулиудаа батлуулж, Олон улсын иргэний нисэхийн 4 конвенцод нэгдэн орлоо.

Зам, тээврийн салбарын хууль, эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах хүрээнд Авто тээврийн тухай хуулийг шинэчлэн боловсруулж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга

хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн яамны хариуцан хэрэгжүүлэх нийт 94 төсөл, арга хэмжээ тусгагдсан.

Үүнээс 2023 оны 10 дугаар сарын байдлаар 50 төсөл, арга хэмжээ буюу 54 хувийг бүрэн хэрэгжүүлсэн, 35 төсөл, арга хэмжээ буюу 38 хувь нь хэрэгжих шатдаа байгаа бөгөөд хэрэгжилтийн хувь 80 гаруй хувийн гүйцэтгэлтэй байна.

Эрхэм гишүүд ээ,

Манай зам тээврийн салбар иргэддээ үйлчлэх чиг үүргээ ил тод, хөнгөн шуурхай, чанартай хэрэгжүүлж, эдийн засгийн өсөлтөд зүтгүүр байхыг хичээн ажиллаж байна.

Хөгжилд хөтлөх авто болон төмөр замын бүтээн байгуулалтаа цаашид улам эрчимжүүлж бүх төрлийн тээврийг олон улсад жишигтэй хөл нийлүүлэн хөгжүүлэхэд цаашид онцгой анхаарч амжилтаа улам ахиулахын төлөө хичээн зүтгэж ажиллах болно.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: Мэдээлэл хийсэн С.Бямбацогт сайдад баярлалаа.

Одоо мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийг төлөөлж Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга Одонгийн Цогтгэрэл үг хэлнэ. Индэрт урьж байна.

О.Цогтгэрэл: Улсын Их Хурлын дэд дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Монгол Улс Төв Азийн өндөрлөгт хоёр том хөршийн дунд далайд гарцгүй 1.5 сая хавтгай километр газар нутагтаа

тархан суудаг байршилтай, цаг уурын эрс тэс нөхцөлтэй орон билээ.

Манай улсын хувьд цаг уур, байршил, дэд бүтэц, байгалиас өгөгдсөний нь сул талыг нөхөж, дэлхий дахинтай хөл нийлүүлэн алхахын тулд ухаалаг, хүчтэй зам тээврийн сүлжээг байгуулах шаардлагатай тулгардаг.

Энэ ч нөхцөл байдлаа мэдэрсэн бидний өвөг дээдэс Их Монгол Улсын үеэс өртөө, улааны ухаалаг тогтолцоог бий болгон морь мэдээллийн хурдаар дэлхийн дайдыг эзэлж явсан түүхтэй.

800 жилийн өмнө манай өртөө, зам харилцаад өрнө, дорныг холбож бидний давуу тал болж байсан бол өнөөдөр бид 100 жилээр хоцрогдсон төмөр замтай, Аймгууд нь чадан ядан холбогдсон авто замтай, тээвэр ложистикийн нэгдсэн сүлжээгүй байгаа нь хөгжлийг хойш чангаагч бул хар чулуу болон оршсоор байна.

Зам, тээврийн зангилаа нь хөгжлийн хөдөлгүүр, чиглүүлэгч байх ёстой ч өдгөө хязгаарлагч, боомилгоч гох дэгээ болон тээглэн хэвтсээр байна.

Хүн төрөлхтөн 300 километр цагийн хурдтай төмөр замын сүлжээ байгуулан ашиглаж байхад бид 100 жилээр хоцрогдсон 60 километр цагийн хурдтай төмөр замаа өргөтгөх тухай бид хүүрнэдэг.

Тээвэр ложистикийн өртөг импортын барааны үнийн 30 хүртэл хувиар нэмэгдүүлж байгаа тухай. Мөн Монголд бизнес эрхлэхэд хамгийн хүндрэлтэй зүйлсийн нэг нь ложистикийн тогтолцоо байгаа тухай Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк зэрэг байгууллагуудын судалгаануудад удаа дараа дурдагдсан.

Үүнийг анзааран дотоодын зам харилцааг хөгжүүлэх, тэр тусмаа төмөр замын томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр Засгийн газрын зүгээс санаачилгатай ажиллаж буй нь сайшаалтай боловч сүүлийн 7 жилд Дархан, Улаанбаатарыг холбосон 200 километр замыг дуусгаж чаддаггүй эрх баригчид Та бүхэнд хандан анхаарах зүйлсийг тодорхойлчлон хэлэхээс өөр аргагүй.

Мэдээлэлд ирүүлсэн төсөвт өртөг тодорхой төмөр замын 7 төслийн өртөг өнөөдрийн ханшаар 24 их наяд юм байна.

Техник, эдийн засгийн үндэслэл нь эцэслэгдээгүй 2 төслийг оруулан тооцвол төслийн өртөг дотоодын нийт бүтээгдэхүүний тэн хагастай тэнцэж байна.

Ийм том төсөвтэй төслүүдийг эхлүүлэхдээ хаалттай хүрээнд шийдвэр гарч, тухай бүрт нь төслийн тусгай зориулалтын компанийг байгуулан ажиллаж байгаа.

Яг л урьдын Хөгжлийн банк, нүүрсний хулгай дөнгөж өчигдөрхөн болсон ногоон автобусны будилаан гарсан жимийн араас төмөр замын том төслүүд магадгүй айсуй.

Аудит хяналтаа сайжруулж, арга ажиллагаагаа ил тод болгохгүй бол хоёр, гурван жилийн дараа, магадгүй түүнээс ч богино хугацааны дараа төмөр замын гэх дэх айхтар том хэргүүд магадгүй дэлгэгдэх дүр зураг харагдаж байна.

Шийдвэрийг гаргаж шахсан, хаалттай, нууц болгосон, улс төрчид огцорсон, хариуцахаа больсон шалтгаанаар сугарч үлдээд, “Монголын төмөр зам” төрийн өмчит компани болон

бусад тусгай зориулалтын компаниудаа хайсан, шүүсэн үйл явдлууд давтагдах вий.

2012-2016 онд муу нэртэй, луу данстай Хөгжлийн банкны Чингис бондын санхүүжилтээр Улаанбаатар хот болон хот хоорондын авто замын сүлжээг өргөтгөн холбож томоохон үсрэлт гаргаснаас бусдаар авто замын салбарт ахицтай, дорвитой бүтээн байгуулалт, шийдэл явагдахгүй байгааг бас сануулан хэлье.

Мянган сайн зам бариад арчлалт тордлогоо муу бол бас болдоггүй. Зам бүрт постууд нэмэгдэж байгаа ч хариуцаж байгаа АЗЗА компаниудын арчилгаа нь сайжирдаггүй, чадавх нь нэмэгддэггүй, санхүү, үйл ажиллагаа жигдэрдэггүй, үлгэн салган мөлхсөн байдалтай.

Ялсан намын цүнхчдийг багтаах сав болсон төрийн өмчит компаниудын нэгэн адил улсын төсөв, иргэдийн татвараас хумсалсан энэ бүтцээ хэрхэн яаж сайжруулах вэ?

Аймаг, хотуудаа холбосон авто замаа эдийн засгийн хувьд амилуулан ложистикийн сүлжээ байгуулах ажилд Засгийн газрын өмнө томоохон шийдлээ хүлээж байгаа.

Орон нутгийн онцлогтой онцгой бүтээгдэхүүнийг Улаанбаатар хотод авчрах, өөр аймгууд руу бусадтайгаа солилцох, эдийн засагт бүтээмжээ нэмэгдүүлэх, өртгөө бууруулахад ложистикийн сүлжээний чанар ихээхэн нөлөөтэй.

Далайд гарцгүй улсын хувьд аялал жуулчлалын экспортыг хийх эрмүүн хүсэлтэй Засгийн газрын хувьд агаарын тээврийн асуудал анхаарлын гадна үлдэх

ёсгүй. Либералчлах, хувьчлах, чөлөөт өрсөлдөөн оруулах замаар өрсөлдөх чадвараа нэмж, үнэ өртгийг бууруулж, хүртээмжээ сайжруулах бодлого хэрэгтэй хэвээр байна.

Дотоод эдийн засаг дахь эрчмээ нэмж чадах эсэх, аялал жуулчлалын болон биет бүтээгдэхүүний экспортоо нэмэгдүүлэх эсэх, үүний ачаар улсынхаа эдийн засгийг тэлж, үсрэнгүй хөгжилтэй улс болох эсэх нь авто, төмөр зам, агаарын замаа хэрхэн хөгжүүлэхээс л өнөөдөр хамаарч байна.

Үүнийг ойлгон анхаарч буй Засгийн газарт хурдтай, бүтээмжтэй ажиллахыг хүсэхийн зэрэгцээ Их Британийн Ерөнхий сайд асан хатагтай М.Тэтчерийн хэлсэн **“Төрийн мөнгө гэж огтоос байдаггүй. Зөвхөн татвар төлөгчдийн мөнгө л бий”** гэж хэлснийг санан бодлогынхоо чиг болгон ажиллахыг сануулъя.

Шинэ сэргэлтийн бодлогод тусгагдсан төслүүдийг хэрэгжүүлэх арга зам хийгээд хөрөнгийн эх үүсвэрийг өнөөг хүртэл тодорхой болгоогүй байгаа нь хөтөлбөрийг тунхаглалын чанартай болгож байна.

Үүгээр ч зогсохгүй 2016 оноос хойш эрх баригчид хэд хэдэн гоё нэртэй хөтөлбөрүүдийг баталсан боловч үр дүнгүй, ард түмэнд таалагдах гэсэн популист арга хэмжээнүүд болж, зарим нь хувирсаар байгааг цохон тэмдэглэе.

Хөгжлийг чиглүүлэгч байх ёстой зам тээврийн салбар нь хөгжлийн занга, тээг болсон хүндхэн нөхцөл байдлыг нэн даруй өөрчлөх үйлсдээ тууштай, үр дүнтэй ажиллахыг эрх баригч Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Одоо ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Сандагийн Бямбацогт Зам, тээврийн хөгжлийн сайд, Лувсангийн Халтар Зам, тээврийн хөгжлийн дэд сайд, Сандагдоржийн Батболд Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Доржийн Эрдэнэбат Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх, Цэрэнжавын Одхүү Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Баасанжавын Болор-Эрдэнэ Зам, тээврийн хөгжлийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Энхтайваны Мөнхнасан Зам, тээврийн хөгжлийн яамны Авто тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Хүчитбаатарын Итгэлт тус яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Цэвээний Эрдэнэ-Очир тус яамны Замын ашиглалт, засварын хэлтсийн дарга, Цэдэндамбын Мятагмаа тус яамны Судалгаа, статистикийн хэлтсийн дарга, Хишигжаргалын Хэрлэн “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн Замын дарга, Батбаярын Мөнхтамир “МИАТ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал, Чимэддоржийн Мөнхтуяа Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, Буянтогтохын Гүрсоронзон “Авто тээврийн үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал, Батсуурийн Отгонсүх “Монголын төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал, Нэргүйн Будбаяр “Таван толгой төмөр зам” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал гэсэн ийм бүрэлдэхүүнтэй байна.

Нэлээд өргөн бүрэлдэхүүнээр ирсэн байна. Одоо мэдээлэлтэй холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайд болон ажлын хэсгийн гишүүдээс

асуулт асууж, үг хэлэх цөөнхийн гишүүдийг бүртгэе.

Нийт хугацаа асуулт асуух, үг хэлэх хамтдаа 5 минут. Нэрээ өгнө үү. Цөөнхийн гишүүд.

Д.Ганбат гишүүнээр тасаллаа. Ширнэнбандийн Адьшаа гишүүн асуулт асууж, үг хэлнэ. Дэгээрээ зөвхөн цөөнх.

Ш.Адьяа: Зам, тээврийн сайдын мэдээллийг сонсож байна.

Зам, тээврийн салбарын сэргэлтийн асуудал сайдын мэдээлэл сонсоход бас тодорхой үр дүнтэй байна гэсэн бодолтой байна.

Тэгэхээр ер нь зам, тээврийн салбарт хөрөнгө оруулалт оруулах, гадаад харилцаа, бизнесийн орчныг дэмжих талаар С.Бямбацогт сайд сайн ажиллаж байгаа л гэж ойлгож байгаа.

С.Бямбацогт сайд бид хоёр яах вэ, нэг тойргоос гарч ирсэн. Улс төрийн янз бүрийн тийм үзэл бодлын зөрүү байдаг юм.

Тэгэхдээ ялангуяа агаарын тээвэрлэлийг либералчлах, түүнчлэн төмөр замын бүтээн байгуулалтад төр, хувийн хэвшлийн хүрээнд хөрөнгө оруулалт оруулах талаар санаачилгатай ажиллаж байгаа гэж ойлгож байгаа.

Харин Дарханы замын асуудал чинь одоо бас л бүрхэг хэвээрээ байна. Энэ Л.Халтар гээд нөхөр эхлүүлсэн. Тэгээд улайчхаад л суугаад л байдаг юм. Тэгээд энэ хүн нь хариуцаж байгаа гэж би ойлгож байгаа.

Тэгээд энэ хүн нь ажлаа бушуухан дуусгаж үзээрэй. Би тийм мэдээлэл авсан.

Л.Халтар сайд Дарханы замыг хариуцаж байгаа гэж би ойлгож байгаа.

Дээр нь нэг асуулт байна.

МИАТ компани болон төмөр замын салбарын үнэ буураад байна гэсэн мэдээлэл байгаа. Зарим талаараа буураад байгаа.

МИАТ компани чинь үнэхээр зах зээлийн жишгийн дагуу үнэ буулгаад байна уу, аль эсвэл сонгуульп зориулсан ч юм уу төрийн өмчит компани ашигтай байдаг юм байна гэж үзүүлэх ийм үзүүлэлтийн хүрээнд энэ үнэ, тарифын буулгалт болоод байна уу гэдэг талаар нэг хариулт авъя гэж бодож байна.

С.Одонтуяа: Хариулахаас өмнө зочид танилцуулъя.

Нийслэлийн 9 дүгээр цэцэрлэгийн багш, ажилчдын төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүгдийн ажилд амжилт, эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Өчигдөр, өнөөдөр багш нарын баяр болж байгаа. Та бүхэнд бас Багш нарын баярын мэндийг хүргэе. /алга ташив/

Хэн хариулах вэ? Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт.

С.Бямбацогт: Ш.Адьяа гишүүний асуултад хариулъя.

Манай салбарын либералчлалыг дэмжиж хэлж байгаад баярлаж байна.

Яах аргагүй манай Зам, тээврийн хөгжлийн яамны бодлого бол ил тод,

нээлттэй, хурдан шуурхай, цахимжсан бодлого, зорилт дэвшүүлж ажиллаж байгаа. Энэ хүрээндээ бид чөлөөт өрсөлдөөнийг дэмжье, бүгдэд тэгш боломж олгоё, өрсөлдөөний үед үнэ хямдардаг гэдэг ийм л бодлого барьж ажиллаж байгаа. Үүний ч үр дүн гарч байгаа.

Энэ хүрээнд сая таны асууж байгаа “МИАТ” компанийн асуудал бас яригдана.

Урьд нь агаарын тээврийн компаниудын томилгоог сайд өгдөг байсан. Сайд өгөхдөө нэг нэгээр нь уулзаад, нэг нэгээр нь тусдаа ханцуй дотроо наймаалцах байдлаар явдаг байсан байж магадгүй.

Тэгвэл би очоод энэ салбарт үндсэндээ агаарын тээврийн 5 авиа компани тавуулаа хоорондоо тохир. Тавуулаа тохироод ирэх юм бол бүх томилгоог чинь зөвшөөрнө гэж ийм шийдэл гаргасан.

Үүний үр дүнд үндсэндээ дэлхийн 42 улс руу 115 чиглэлд нислэг үйлдэх бололцоотой болсон.

Агаарын тээврийн салбарт маань өрсөлдөөн бий болж, үнэ хямдарч байгаа.

Түрүүн хэлсэн. Сөүл рүү долоо хоногт 12 нисдэг байсан бол одоо 80 удаа нисэж байгаа. Дээд тал нь. Энэ зун ниссэн.

Турк руу долоо хоногт 5 удаа нисдэг. Ганцхан **“Turkish Airlines”** нисдэг байсан бол “МИАТ” компани нисдэг болсон. Нислэгийн үнэ, тариф 2-оос 2.5 дахин буурсан. Нислэгийн хэмжээ долоо хоногт 30 болж нэмэгдсэн.

Сөүл, Улаанбаатарын хооронд Монголоос ганцхан “МИАТ” нисдэг байсан. Солонгосоос ганцхан **“KAL”** нисдэг байсан.

Тэгвэл одоо Солонгосоос 4 авиа компани, Монголоос 3 авиа компани. Нийтдээ 7 авиа компани нисэж хоорондоо өрсөлдөж байж үнэ буурч байгаа.

Бусдаар одоо юу гэдэг юм ямар нэгэн сонгуульд зориулсан байдлаар үнэ буурч байгаа юм байхгүй.

Дотоод нислэг дээр 2-хон аймагт нисдэг байсан. Ховд, Баян-Өлгий гэсэн аймагт.

Бусад аймгууд дээр алданги онон. Ер нь нисдэггүй байсан. Энэ нислэгийг “МИАТ” компани нийгмийн хариуцлагын хүрээнд алдагдалгүй, гэхдээ ашиггүй байх үнэ тариф гарга. Энэ нислэгийг сэргээмээр байна гэсэн чиглэлийг өгсөн.

Энэ чиглэлийн дагуу “МИАТ” компани 9 чиглэлд нисэж байна. Өөрөөр хэлэх юм бол дотоод нислэг маань 2-оос 3 дахин. Тухайлах юм бол Мөрөн, Улаанбаатарын чиглэлд 3 дахин, Өмнөговь, Улаанбаатарын чиглэлд 3 дахин үнэ буурсан. Гэхдээ алдагдалгүй нисэж байгаа.

Б.Мөнхтамир захирал нэмээд хариулчхаарай.

Өмнө нь 2020, 2021 онд алдагдалтай ажиллаж байсан. Өнгөрсөн 2022 онд ашигтай ажилласан. Хэчнээн либералчлаад байх тусмаа ашигтай ажиллаж байгаа.

Нислэгийн тоо нэмэгдэж байна, зорчигчдын тоо нэмэгдэж байна, онгоцны

тоо нэмэгдэж байна. “МИАТ” компанийн эдийн засгийн үр ашиг сайжирч байгаа.

Үүнийг Б.Мөнхтамир дарга тоон үзүүлэлтээ хэлчхээрэй.

Дарханы замын тухайд сая Ардчилсан намын бүлгийн даргын мэдээлэлд 7 жил барилаа гэж ярьж байх шиг байна. 7 биш юм аа. 2019 онд эхэлсэн юм билээ.

2019 онд эхлээд үндсэндээ 4 жилийн хугацаанд нийт замын 50 орчим хувь нь хийгдсэн байсан. Одоо энэ 2023 онд үндсэндээ үлдсэн 50 орчим хувийг нь хийж дуусгах зорилт тавьж ажилласан.

Одоогийн байдлаар үндсэндээ энэ барилгын улирлын сезон дуусахад 90 хувьтай ажил хийж дуусгах бололцоотой болж 2 урсгалтай 4 эгнээ зам бүрэн нээгдэх гэж байгаа.

Манай дэд сайд Л.Халтар маань хариуцаж байгаа. Харьцангуй хариуцлагатай сайн ажиллаж байгаа.

С.Одонтуяа: Б.Мөнхтамир дарга хариулах уу? 94.

Б.Мөнхтамир: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Ш.Адъяаа гишүүнчлэлийн асуултад нэмж хариулья.

Ерөнхийдөө “МИАТ” компанийн үндсэн тарифын үнэ маань сүүлийн жилүүдэд хямдарч байгаа нь “МИАТ” компанийн үндсэн зардлын 30 хувийг эзэлдэг шатахууны үнэ маань олон улсад авдаг байсан үнээс харьцангуй хямдралтай үнээр шууд экспортлогч компаниар Монгол Улсын Уул уурхайн яамны харьяа “Эрчис Ойл” компаниар дамжуулан үйлдвэрлэгчээс нь шууд

дамжуулан авч байгаатай шууд холбоотой гэж ойлгож болно.

Өнгөрсөн онуудын хугацаанд. Сая сайд бас хэллээ. Агаарын тээврийн либералчлалыг эрчимтэй хөгжүүлснээр өрсөлдөөний дүнд үнэ маань үе шаттайгаар буурч явж байгаа.

Өнгөрсөн сард “МИАТ” компани 2011 оноос хойш бууруулаагүй байсан үндсэн нислэгүүдийнхээ тарифуудыг 10-аас 26 хувийн шатлалтайгаар бууруулж оруулж ирсэн.

Өрсөлдөөнд үнэ бууруулснаар нийт зорчигч урсгалыг нэмэгдүүлэх нь эргээд агаарын тээврийн компаниудын хувьд ашиг орлогоо нэмэгдүүлэх үндсэн үзүүлэлтүүд болдог.

2023 оны эхний 3 улирлын урьдчилсан тайлан тооцоогоор “МИАТ” компани татварын өмнөх байдлаар 63 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөж байна.

4 дүгээр улирлын сүүлийн low season буюу зорчих урсгал эрс буурч байгаатай холбогдуулан оны эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 45 орчим тэрбум төгрөгийн цэвэр ашигтай гарах төлөвлөгөөтэй ажиллаж байна. Баярлалаа.

С.Одонтуяа: Ш.Адъяаа гишүүн нэмэлт тодруулья.

Ш.Адъяаа: Б.Мөнхтамир захирлаас дахиад нэг юм тодруулчихъя.

“МИАТ” компанийн өмнөөс Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын нэг агаарын тээврийн компани дотоодын зах зээл дээр нислэг үйлдэж байгаа.

Энэ ямар зарчмаар үйлддэг юм?
Тэднийх түрээсэлдэг юм уу?

Түүнчлэн Монголын агаарын дотоодын зах зээлд хувийн компаниуд тодорхой нислэг хийж байсан.

Өмнөд Африкийн компанитай адилхан нөхцөлөөр дотоодын компаниудаа дэмжих, дотоодын аж ахуйн нэгжүүдээ төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд дэмжих энэ бодлого байхгүй байсан юм болов уу.

Энэ талаар нэг мэдээлэл авъя.

Яагаад гэхээр Өмнөд Африкийн компани ирээд ашигтай ажиллаад, нөхцөл сайжраад байна гэж ойлгож байгаа.

Гэтэл дотоодын хувийн авиа компаниудаа дэмжих бодлого байхгүй байсан юм уу гэдэг. Энэ талаар хариулт авъя.

С.Одонтуяа: 94. Б.Мөнхтамир захирал хариулья.

Б.Мөнхтамир: Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбогдуулан нийт энэ аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхтэй холбоотойгоор орон нутгийн нислэгийг “МИАТ” компани Сэргээх үүргийг хүлээсэн.

Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор бид 2023 оны 7 сарын 01-нээс буюу 5 сард гарсан тогтоолоо 2 сарын хугацаанд бэлтгэл ажлыг хангаж яаралтай орон нутгийн нислэгийг эхлүүлэх шаардлага үүссэн.

Энэ үүссэнтэй холбоотойгоор тухайн нислэгийг яаралтай эхлүүлэхийн

тулд бэлтгэл ажлын хувьд тухайн чиглэл бүрт нисэх нислэгийн онгоц, онгоцны бүхээгийн үйл ажиллагааны нисэх багийн бүрэлдэхүүн, инженер, техникийн ажилтан болон сэлбэг нөөцийн гэсэн олон бэлтгэл ажлууд шаарддаг учир яаралтай эхлүүлэх зорилгоор бид Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улсын “СemAir” компаниас нойтон түрээсийн буюу тухайн онгоцыг нисгэгч, инженер, техникийн ажилтан, сэлбэгийн нөөц хэрэгсэлтэй нь хамтад нь даатгалыг нь хамт хамруулан түрээсэлж авч 2023 оны 7 сарын 01-нээс орон нутгийн 8 чиглэлд нислэгүүдийг эхлүүлээд.../минут дуусав/

С.Одонтуяа: Хариултаа дуусгачих уу? 94 дүгээр микрофон.

Б.Мөнхтамир: Одоо цаашид бид орон нутгийн нислэгийг 2024 оны нэгдүгээр улирлаас эхлээд өөрийн хуурай түрээсийн онгоцоор өөрийн гэсэн нисгэгч, инженер, техникийн ажилтан, техник үйлчилгээний нөхцөлтэйгөөр нь түрээсэлж явуулна.

Түүрүүн орон нутгийн дотоодын компаниудаас дэмжиж болоогүй юу гэдэг асуулт байсан.

Бид нислэгийг эхлэх үүднээс дотоодын нислэг үйлдэж байгаа “Аэро Монгол” болон “Хүннү эйр” компаниудаас үнийн санал авч харьцуулалтын аргаар хамгийн хямдхан санал өгсөн компанийг нь авч хэрэгжүүлж явсан юм. Баярлалаа.

С.Одонтуяа: Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асууна. Асуулт, үг хамт шүү.

О.Цогтгэрэл: Зам, тээврийн салбарын тухай. Түүн дотроосоо зөвхөн төмөр зам дээр хэдэн зүйлийг тодруулаад асууя.

Өнөөдөр 7 төсөл концесс болоод хэрэгжилтийн шатанд яваа гэсэн. Төмөр замаа тавьчихсан Тавантолгой-Гашуунсухайт-Зүүнбаян, Ханги-Мандал гээд, дахиад Зүүнбаянгийн байна уу хэд хэдэн төслүүд байдаг.

Төмөр зам дээр асар том боомтын болоод төмөр замын сэргэлт гээд зүйл гарч байна гэж тайлангуудад дурдагддаг.

Гэтэл энэ төмөр замуудаас яг өнөөдрийн байдлаар холбогдоод, тэр боомтын болоод ачаагаа зөөж байгаа, ажиллаж байгаа, бусадтай холбогдсон, урд хөрштэйгөө холбогдсон зам өнөөдрийн байдлаар нэг ширхэг ч алга.

Монгол Улсын өнөөдрийн олон улсын зээлжих зэрэглэлээс харахад Монгол Улсад орж ирж байгаа санхүүгийн эх үүсвэрийн өртөг 10 хувиас доошгүй. Асар өндөр өртөгтэй.

Гэтэл ийм өндөр өртгөөр хэдэн их наядар барьчихсан замууд маань хэдэн жилдээ ингээд гоё төмөр замын тууз хайчлаад нээгээд байдаг. Нөгөөдөх нь холбогддоггүй. Нэг тонн ч ачаа зөөдөггүй. Тэгээд л индэр дээр ярихаараа бид төмөр замын сэргэлт болж байна гээд байдаг.

Тэгэхээр үүний цаана энэ дээр хэзээ яг бодитой ахиц гарах вэ?

Борлуулалт хийдэг, ашиг орлого олдог, ажил хийдэг зүйлийг хөрөнгө оруулалт гэдэг. Харин саяын зүйлүүдийг хийдэггүй бол энэ зүгээр хоосон зардал.

Хоосон зардал гэдэг чинь одоо үндсэндээ хэдэн их наядын зардал өнөөдрийг хүртэл шороонд булсан хөрөнгө. Ийм л байдалтай байна.

Тэгэхээр хэзээнээс холбогдож эхний ачаа тээвэр гарч ашиг, орлогоо өгч эхлэх вэ?

Хоёрдугаарт нь, одоо яг ажиллаж байгаагаар нь “Улаанбаатар төмөр зам”-аас ганц хоёр зүйл асууя.

“Улаанбаатар төмөр зам”-ын өнөөдрийн байдлыг харахад үндсэндээ 40, 50 жилийн өмнөх нөхцөл байдалтай. 1700 байна уу, 2000-аад километр замтай 20-иод мянган хүн ажилладаг. Бүтээмж ярих юм бол дэлхийтэй харьцуулахын аргагүй.

Яг үндсэндээ тэр Солонгосууд ирж социалист нийгмийн хоцрогдлын жишээний кино зураг авдаг. Одоо тэр төмөр замын рейс рүүгээ өтгөн шингэнэ шууд асгаад цутгаад явж байдаг. XXI зуунд ийм төмөр зам өнөөдөр бид ашиглаад 50 жил өөрчилж шинэчилдэггүй.

Энэ дээр хэзээ яаж ахиц дэвшил гарах юм бол? 50 жил байрандаа байдаг салбар, бизнес гэж байдаг юм болов уу?

Тэгэхээр үүнтэй холбоотойгоор ер нь 1949 оны хэлэлцээртэй холбоотой “Улаанбаатар төмөр зам” одоо яг ямар ямар татваруудыг төлж, ямар ямар татваруудыг төлөхгүй байгаа вэ? Ямар ямар татваруудыг төлөхгүй байгаа юм?

Үүний дараа одоо энэ төрийн өмчийн компанийнхаа хувьд жилийн яг ямар ашиг, орлоготой ажиллаж байгаа вэ? Ямар борлуулалт хийдэг юм? Ямар ашиг, орлоготой ажилладаг юм?

Хоёрдугаарт нь, “Улаанбаатар төмөр зам” дээр тарифын хөнгөлөлт гэдэг Оросын Холбооны Улстай хийсэн гэрээний тухай яригдаад байдаг.

Энэ тарифын хөнгөлөлтөөс манайх олж байгаа, алдаж зүйл яг юу байдаг юм? Энэ тарифын хөнгөлөлтийн гэрээ хэлэлцээр хийснээс манайх хожиж байгаа юу?

Зарим мэдээллээр транзит тээвэр нь дийлэнх яваад, манайх ачаа тээврийнхээ боломж байдаггүй. Яг энэ тарифын хөнгөлөлтийн хэлэлцээрээс манайх олж хожиж байгаа зүйл байхгүй гэдэг зүйл яригддаг.

Энэ тарифын гэрээний тухай бас мэдээлэл өгөөч?

Тэгээд төгсгөлд нь “Улаанбаатар төмөр зам” төрийн өмчит компанийнхаа хувьд өр зээлийн асуудал ямар байдалтай байгаа вэ? Хэдэн жилийн өмнө бусдын нэг барьцаанд баталгаа гаргаад, үүний өмнө өр зээлд орлоо. Олон зүйлүүд яригдаж байсан.../минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариулах вэ?
С.Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Тийм ээ. Зарим талаараа таны хэлж байгаатай санал нэгдэж байгаа.

Үндсэндээ бид Замын-Үүд, Улаанбаатар, Алтанбулаг гээд ганцхан төмөр замтай. Замын-Үүд, Эрээн гээд Хятад Улстай ганцхан төмөр замаар хил холболтын төмөр зам нарийн, өргөн царигаар холбогдсон байсан.

Нэлээд олон төмөр зам барьсан. Бид Зүүнбаянгаас Тавантолгой хүртэл 411 километр төмөр зам барьсан. Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэл 230 километр төмөр зам, Зүүнбаянгаас Ханги-Мандлын 230 километр төмөр зам гээд нэлээн төмөр зам барьчихсан. 800 гаруй километр төмөр зам.

Хил холболтын асуудлаа харьцангуй юу гэдэг юм нэлээн ч хожуу анхаарсан юм билээ. Уг нь барьж байх явцдаа хил холболтын асуудлыг анхаараад явж байх байсан.

Одоо нэлээн эрчимтэй, Засгийн газар онцгой анхаарч ажиллаж байгаа. Үүний үр дүнд Тавантолгой-Гашуунсухайтын хил холболтын төмөр зам үндсэндээ ирэх онд бүтээн байгуулалтын ажил эхлэхэд бэлэн болж байгаа.

Хятадын талтайгаа бид Засгийн газар, Тээврийн яамтай ажиллаж байна.

2004 оны хилийн дэглэм, түүний хэлэлцээрт өөрчлөлт оруулсан. Ганцхан Замын-Үүд, Эрээн гэсэн төмөр замаар холбогдоно гэсэн байсан бол хилийн дэглэмд энэ хэлэлцээрт өөрчлөлт оруулаад бид Шивээхүрэн, Сэхээ, Гашуунсухайт, Ганцмод, Бичигт, Зүүнхатавч гэсэн 3 боомтыг нэмчихсэн байгаа.

Одоо дээрээс нь Ханги-Мандалыг нэмчих юм бол энэ 4 боомт нэмэгдээд 5 төмөр замаар ойрын үед холбогдох. 1955 оны хэлэлцээрт ойрын үед, энэ жилдээ багтаагаад өөрчлөлт оруулахаар ажиллаж байна.

Ингэх юм бол холболтын асуудлууд бэлэн болчихно.

Холболтын бүтээн байгуулалтын ажил эхэлчихсэн байгаа.

Шивээхүрэн-Сэхээ дээр үндсэндээ дэлгэмэл уртаар 20 орчим километр урттай, нарийн царигийн холболтын төмөр замын ажил эхэлсэн явж байна.

Мөн Гашуунсухайт-Ганцмодны ажил эхлэхэд техник, эдийн засгийн

үндэслэл хийгдсэн. Бэлэн болж байна. Ийм байдалтай байж байгаа.

Энэ төмөр замуудын үр өгөөжийн тухайд өнөөдөр хэдийгээр барьчихсан хилээр цаашаа гарахгүй байгаа ч гэсэн энэ дээгүүр нүүрс тээвэрлэж байгаа. Экспортын ачаа.

Тавантолгой төмөр замынхан нийтдээ 2 сая гаруй тонн ачаа урагш нь тээвэрлэсэн байна. “Монголын төмөр зам” компани наашаагаа “медлинг” тээвэр, ялангуяа Улаанбаатар хотын энэ “медлинг” тээврийг үндсэндээ 100 хувь төмөр замаар тээвэрлэхээр тээвэр эхэлсэн байгаа.

Урьд нь бид медлинг тээврийг Дундговь, Өмнөговийн авто замаар тээвэрлээд энэ замыг эвдээд Дундговь, Өмнөговийн иргэд эвдэрхий зам дээгүүр явдаг байсан бол одоо энэ жил бид медлинг тээвэрлэлтээ тээвэрлэхгүй гэж байгаа.

Урьд нь медлинг нэрээр нуугаад, хуйвалдаад үндсэндээ Тавантолгойгоос нүүрс нааш нь Чойр, Мааньт, Олон Овоот руу хулгайн нүүрс авчраад. Нүүрсний хулгай. Тэр С.Батдөлийн хэрэг. 500 сая вагоны авлигал авдаг. Би эндээс ярьж л байсан.

Энэ асуудлын эх үүсвэр нь үндсэндээ энэ медлингийн тээвэр байсан. Тэгвэл бид вагоноор тээвэрлэдэг болсноороо “Улаанбаатар төмөр зам” тойрсон нүүрсний тээвэртэй холбоотой янз янзын асуудал байхгүй болж байгаа.

“Монголын төмөр зам” компаниас нийтдээ 2 сая гаруй тонн ачаа тээвэрлээд байгаа. Тийм үү. Тийм. Б.Отгонсүх захирал бас нэмээд хариулчхаарай.

Ийм байдлаар ямар ч байсан аль болох барьсан төмөр замаа үр өгөөжтэй болгох, эдийн засгийн үр өгөөжийг нь хүртэх тал дээр гадагш нь хил холболтын төмөр замуудаа барих, дотооддоо тээвэр хийх. Ингэхийн тулд бас вагон, зүтгүүрүүдийг нэмэх. Аль болох ахиу ачаа тээвэрлэх ийм бодлого, зорилтыг бид бас барьж ажиллаж байгаа.

Өөрөөр хэлэх юм бол хамгийн богино хугацаанд холбогдох замууд бол үндсэндээ бид 2025 он гэхэд Гашуунсухайт-Ганцмодыг холбох бодолтой байна. Шивээхүрэн-Сэхээ бол ирэх онд холбочих бодолтой байна.

Ханги-Мандалын хэлэлцээр хийгдчих юм бол бас богино хугацаанд холбогдох бололцоотой байгаа. Ийм байдлаар үндсэндээ холбогдоход тун ойрхон болчихсон.

1955 оны хэлэлцээрт өөрчлөлт хийгээд цаашаа явчихад бэлэн болчихсон байгаа гэдгийг бас хэлье.

“Улаанбаатар төмөр зам”-ын 1949 оны хэлэлцээрт бид бас нэлээд олон жил ярьж байж өөрчлөлт оруулсан.

Энэ “Улаанбаатар төмөр зам” өнгөрсөн 6 сард бид хэлэлцээрт өөрчлөлт оруулж гарын үсэг зурсан. Үүгээрээ бид үндсэндээ “Улаанбаатар төмөр зам”-ын их өр. Олон жил яригдсан. 30-аад жил яригдсан их өрийн асуудлыг тэглэсэн.

200 тэрбум төгрөгийн өр тэглэгдсэн. 167 тэрбум төгрөгийн дүрмийн сан нэмэгдсэн. “Улаанбаатар төмөр зам”-д Оросын талаас дүрмийн санд оруулах хөрөнгөөрөө 5 зүтгүүр нийлүүлэхээр болсон.

Ийм байдлаар бид “Улаанбаатар төмөр зам”-ын.../минут дуусав/

С.Одонтуяа: Нэмж. Х.Хэрлэн дарга. 92 дугаар микрофон.

Х.Хэрлэн: Сайн байцгаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

“Улаанбаатар төмөр зам”-ын дарга Х.Хэрлэн байна. О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

“Улаанбаатар төмөр зам” 1815 километр замтай. Үүнээс гол зам нь буюу Сүхбаатар өртөөгөөс Замын-Үүд өртөө хүртэлх 1111 километр төмөр зам байдаг.

Үүгээр дамжин өнгөрөх тээвэр явдаг. Дамжин өнгөрөх тээвэр Оросын Холбооны Улсаас Хятад болон Хятадаас Оросын Холбооны Улс руу жилдээ нийлбэр дүнгээрээ 4 сая орчим тонн ачаа тээдэг.

Энэ 4 сая орчим ачаанаас бид өнгөрдөг жил 40 орчим тэрбум төгрөгийн ашиг олсон. Энэ жил хүлээгдэж байгаа гүйцэтгэлээр 72.9 тэрбум төгрөг олохоор төлөвлөөд ажиллаж байна.

Хөнгөлөлтийн тухайд дамжин өнгөрч байгаа тээвэр хоёр талдаа 50, 50 хувийн хөнгөлөлт үзүүлдэг.

Энэ үзүүлэлт сүүлийн арван хэдэн жил үргэлжилж байгаа хөнгөлөлт байгаа. Энэ хөнгөлөлтийг багасгах тал дээр манай яамны холбогдох хүмүүс, мөн сайд, бидний зүгээс хамтарч Оросын Холбооны Улсад асуудлаа тавьж байгаа.

Үүнийг үе шаттайгаар багасгана. Цаашдаа энэ хөнгөлөлтийг байхгүй болгоно гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байгаа.

Нэг бидний болгоомжилж байгаа зүйл бол баруун болон зүүн талд явж

байгаа энэ дамжин өнгөрөх тээвэрт бид ачаагаа алдчихаж магадгүй гэсэн ийм болгоомжлол байгаа. Тийм.

Гэхдээ бид энэ ажлыг хөөцөлдөж байгаа. Үүнийг ойрын хугацаанд шийдчих байх гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Энэ замын хөгжил, хөдлөх бүрэлдэхүүний шинэчлэлийн асуудал үеийн үед яригддаг асуудал.

Ирэх жил бид 75 жилийн ойгоо тэмдэглэх гэж байна. Өнөөдрийн байдлаар манай замын 50 орчим хувь нь ашиглалтын хугацаа дууссан. Хөдлөх бүрэлдэхүүний 60, 70 хувь нь ашиглалтын хугацаа дуусчихсан иймэрхүү байдалтай байгаа.

Бид 2030 он хүртэлх Хөгжлийн хөтөлбөрөө баталчихсан. Энэ хөтөлбөрт эдгээр хөдлөх бүрэлдэхүүний шинэчлэл, замын шинэчлэлийн асуудлууд хугацаатайгаа ингээд тавигдчихсан байгаа. Энэ хөтөлбөрийн дагуу бид ажиллаж байгаа. Баярлалаа.

С.Одонтуяа: О.Цогтгэрэл гишүүн тодруулъя. 1 минут.

О.Цогтгэрэл: Би тэр ашигт ажиллагааг л асуусан юм даа. Та тэр транзит тээврээсээ 40 тэрбумыг олдог ч гэлүү. Тэгэх шиг боллоо.

Ер нь Улаанбаатар. Энэ чинь төрийн өмчит компани уу? Хувь нийлүүлсэн нийгэмлэг үү? Энэ байгууллага маань жилдээ яг ямар ашигтай ажиллаж байгаа вэ?

Би үүнийг асуугаад байгаа нь нөгөө талд нь хэчнээн арван тэрбумын хөнгөлөлт явж байгаа вэ? Аль аль татваруудаас ямар хөнгөлөлт? Тэгээд энэ

талд нь ашгийг чинь харахаар энэ байгууллагын чинь үр ашгийн үзүүлэлт гэвэл нэг хачин зүйл байгаа юм шиг санагдаж байгаа учраас энэ дээр тодруулж хариулж өгөөч ээ гэж хүсэж байна.

Тэгээд тэр түрүүний асуултаас дутуу нь тэр. Ер нь тарифаас бид хожсон юм уу, алдчихсан юм уу?

Гуравдугаарт нь, одоо танай компанийн өр, авлагын байдал ямар байдалтай байгаа вэ?

С.Одонтуяа: С.Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тийм. “Улаанбаатар төмөр зам” Орос, Монголын хамтарсан 16 мянган хүнтэй том байгууллага. Том байгууллага.

Энэ байгууллага үндсэндээ нийгмийн үүрч байгаа ачаа нь маш их. Одоо үндсэндээ маш олон жил нефть бүтээгдэхүүн, хүнсний бүтээгдэхүүн, үр тариа, эрчим хүчний нүүрс гээд энэ бүгдийг тийм үү. “Улаанбаатар төмөр зам” тариф нэмчих юм бол эрчим хүчний үнэ өсчихнө. Хүнсний бүтээгдэхүүний тээврийн төмөр замын тариф нэмчих юм бол хүнсний бүтээгдэхүүний үнэ өсчихнө.

Нефть бүтээгдэхүүн тээвэрлэх тарифаа нэмчих юм бол нефтийн үнэ өсчихнө гэдэг байдлаар олон жил үнэ тарифыг нь барьж ирсэн юм билээ. Барьж ирсэн.

Бид бол үгүй ээ, барихгүй ээ. Алдагдалтай ажиллах ёсгүй гэсэн бодлого барьж удаа дараагаар үе шаттайгаар тарифыг нэмсэн.

Гэтэл үнэд бас нөлөөлөхгүй байгаа. Нөлөөлөхгүй байгаа. Гэтэл үндсэндээ тийм худлаа айдас бий болгодог. Ийм байдлаар.

Гэтэл 50 хувь хөнгөлөөд байгаа мөртлөө “Улаанбаатар төмөр зам”-ын тийм үү, экспорт транзит ачаа нь 70, 80 тэрбумын ашигтай ажил байгаад байдаг. Энэ хөнгөлөлтийг л.../минут дуусав/

С.Одонтуяа: 92. Х.Хэрлэн дарга нэмж хариулъя.

Х.Хэрлэн: О.Цогтгэрэл гишүүний асуултад гүйцээж хариулъя.

“Улаанбаатар төмөр зам” түүхэндээ 2021 онд хамгийн дээд ашиг буюу 49 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан.

Энэ жил бид 55 орчим тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж, бас нэг түүхэн дээд амжилтаа эвдчих ийм төлөвтэй байгаа.

Татварын хөнгөлөлт бол байхгүй. Бид 1949 оны хэлэлцээрээр аливаа татвараас чөлөөлөгдсөн байгаа шүү дээ.

Монгол Улсад татвар төлөхгүй байгаа. Төлдөггүй. Хэрвээ татвар төлдөг бол алдагдалтай л ажиллана гэсэн үг л дээ. Нарийн тоог нь би танд бичгээр гаргаад өгчихье. Тэгье.

С.Одонтуяа: С.Бямбацогт сайд саяын хариултаа микрофонд хэлчих үү? Тэр тарифын хөнгөлөлтийг чинь л асуугаад байна л даа. Гишүүд. С.Бямбацогт сайд нэмээд хариулчих.

С.Бямбацогт: Ер нь Орос, Хятад хоёр улстай төмөр замын хэлэлцээр хийгээд энэ хэлэлцээртээ аль аль талдаа 50, 50 хувь.

Одоо Хятадтай 60 хувийн хөнгөлөлттэй хийх, Оростой 50 хувь хөнгөлөлттэй хийх ийм хэлэлцээр хийчихсэн юм билээ.

Харамсалтай нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээгүүр Хятадын ачаа явдаг, Оросын ачаа явдаг. Энэ 4 сая тонн. Энэ 4 сая тонн нь 50 хувь хөнгөлөгдөж байгаа мөртлөө ашигтай.

Бид Оросын нутаг дэвсгэр ачаа явуулах шаардлага байдаггүй. Тийм болохоор Оросын нутаг дэвсгэрт хөнгөлсөн тарифын хөнгөлөлтийг эдэлж чаддаггүй. Тэгж чаддаггүй. Ерөөсөө байхгүй. Ячаа явдаггүй.

Хятадын нутаг дэвсгэр дээр хэлэлцээр хийхийг Хятадууд зөвшөөрдөггүй. Хөнгөлөлтөө аваад хаячих. Харилцан хөнгөлөлтгүй байя гэдэг.

Үүгээрээ Монгол Улсад үндсэндээ энэ хийсэн 50 хувийн хөнгөлөлт маань Монгол Улсад ашиггүй болчихоод байгаа юм. Ашиггүй болчихоод байгаа юм.

Гэхдээ 50 хувийн хөнгөлөлттэй явж байгаа тариф нь хамгийн өндөр ашигтай.

Бусад тарифуудтай харьцуулах юм бол эрчим хүчний нүүрсний тариф, нефть бүтээгдэхүүний тарифтай харьцуулах юм бол хамаагүй өндөр тарифтай бас. Нөгөө талдаа. Тийм болохоор ийм байна.

Тэгээд үндсэндээ “Улаанбаатар төмөр зам” татвар төлдөггүй. Гэхдээ нөгөө нийгмийн ачаа үүрч явж байдаг гэдэг үүднээсээ аль болох юу гэдэг юм эрчим хүчний нүүрсний үнийг бид тийм үү хамгийн их тээвэрлэж байгаа нь эрчим хүчний нүүрс тээвэрлэж байгаа. Энэний

тарифыг ашигтай болгоод нэмчих юм бол цахилгааны үнэ өсчихнө л гээд хатуу барьчихдаг.

Гэхдээ бид алдагдалгүй үнээр тээвэрлэнэ гэсэн ийм зарчим барьж үндсэндээ ямар ч байсан алдагдлуудаа л тарифаа үе шаттай нэмж байна.

Оросын талтай бидний ярьж байгаа юм бол энэ хөнгөлөлттэй байхгүй болгоё. Хөнгөлөлтөө байхгүй болгох юм бол дотоодын тээврийнхээ тарифаа нэмье гэдэг ийм байр суурьтай ажиллаж байгаа.

Ийм харилцан ашигтай байх ёстой. Тэгэхгүй дотоодын тээврийн тарифаа нэмчхээд Орост өгч байгаа хөнгөлөлтийг бид хэвээр нь байлгаж болохгүй. Ийм бодлого барьж ажиллаж байгаа.

С.Одонтуяа: Одоо Бөхчулууны Пүрэвдорж гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Б.Пүрэвдорж: Тэгэхээр нүүрсний хулгай гэж яриад байгаа юм. Нүүрсний хулгай бол үндсэндээ тээврийн хулгай юм.

Тэгэхээр ард иргэд нүүрсний хулгай гэж яриад байдаг. Ямар хулгай явсан бүтцийг нь мэдэхгүй байгаа.

Тийм учраас би иргэддээ тайлбарлаж өгнө.

2018 он хүртэл үүнийг 1 тонн нүүрс гэж үзье. Дэлхийн зах зээл дээр 120 долларын үнэтэй байсан. 1 тонн нүүрс. Тэрний 60 доллароор нь аман дээрээсээ нүүрсээ зараад, энэ нүүрсээ Цагаанхадны талбай дээр буулгадаг. Тэндээсээ цаашаа 29 километрт тээвэрлээд Ганцмодны боомт руу гаргадаг.

Тэгээд энэ 29 километр газарт урьд нь 3-аас 5 сая төгрөгөөр тээвэр хийдэг байсан юм билээ.

Гэтэл 2018 оноос нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ өсөж эхэлсэн.

Дээд тал нь 2021 онд 600 доллар хүрсэн. Ер нь дунджаар 450 орчим доллар дээр ингээд тогтсон. 3 жилийн туршид.

Гэтэл энэ 3 жилийн хугацаанд 450 доллар дээр байхад энэ амных нь үнэ 60 доллар хэвээрээ байгаад байдаг. Энэ хоорондох мөнгөө яаж хулгайлсан юм бэ гэхээр Цагаанхадны талбайгаас Ганцмодны боомт хүртэл 29 километр газарт нөгөө 5 сая төгрөгөөр тээвэр хийдэг байсныгаа 120 сая төгрөг болгож байгаад хулгайлаад байсан байхгүй юу даа.

Та нар бод доо. Цоо шинэ давхар чиргүүлтэй Хятад нүүрсний машиныг 360 сая төгрөгөөр худалдаж авчихаад энэ хоёрын хооронд гуравхан тээвэр хийгээд л 360 сая төгрөг олоод байсан байгаа шүү дээ.

Тэгээд тэр байтугай цоо шинэ машинаа банканд нь солярк дүүргээд солярк нь дуусаагүй байж байхад 360 сая төгрөг олдог ийм тээвэр дэлхийд хаана байна аа?

Тэгээд энэ хоёрын хооронд тэр яах вэ, КОВИД-той үед дунджаар 300 машин гарч байсан гэж үзэхэд тийм ээ, 100 саяыг нь хулгай гэж үзлээ гэхэд өдөр болгон 30 тэрбум төгрөг л наагаад байсан, хулгайлаад байсан байхгүй юу даа. Энэ эрх баригч нар.

Тэгээд ийм замбараагүй. Тэгээд тэрнийх нь нийлбэр ингээд хэдэн жилээр тооцохоор 44 их наяд төгрөг болсон гэж үздэг Ерөнхий сайдын үг чинь, бас

Т.Доржханд энэ тэрийн үг чинь зөв болчихоод байгаа байхгүй юу даа.

Тэгээд энэ их хулгайг яаж зохион байгуулсан бэ гэхээр “Си” зөвшөөрлийн луйвар. Өөрөөр хэлбэл “Си” зөвшөөрлөөр бүх юмыг гацаадаг. Дээрээс нь “бөмбөлөг”-өөр бүх юмыг гацаадаг.

Тэгээд “Си” зөвшөөрөл 2016 он хүртэл тэр хил дээр байдаг хүмүүс нь энэ нэг цаасыг бичээд өгөөч ээ гээд одоо тэр “Авто тээврийн үндэсний төв”-ийнхөн хүн хүрэлцэхгүй байна. Үүнийг бичээд өгөөч ээ гэдэг. 20-иод мянган төгрөгийн үнэтэй л цаас байсан.

Гэтэл 2016 оноос хойш энэ “Си” зөвшөөрөл, авлигал нь явсаар байгаад 2 сая төгрөг байж байсан. Одоо сүүлдээ тэр компаниуд дээр очсон чинь бүр 20 сая болчихсон явж байна шүү дээ. Тийм.

8 мянган машин нэг улиралд 20 сая төгрөгөөр зөвшөөрөл авахаар 160 тэрбум төгрөгийн авлигал тэнд явж байна шүү дээ.

Тэр авлига чинь тэнд хөгжчихсөн ингээд л байж байхад өнөөдөр тэгээд л нэг тийм улс төр хийхээр Ардчилсан намын хэдэн нөхдүүд рүү дайрдаг. Энэ авлига, хээл хахууль чинь хэтэрчхээд байна шүү дээ.

Ямар бузартай юм бэ. Тэр залуу нэг жилийн дотор 4 удаа “Си” зөвшөөрөл авахад 80 сая төгрөг төлж байна. Тэр залуу байр авах боломж, тэр хүүхдүүдээ сайхан амьдруулах тэр бүх боломжийг авлигачид хулгайлж байна шүү дээ.

С.Одонтуяа: С.Бямбацогт сайд хариулъя. С.Бямбацогт сайдын микрофоныг нээгээрэй.

С.Бямбацогт: С.Пүрэвдорж маш зөв асуудал хөндөж байна.

“Си” зөвшөөрөл “Авто тээврийн үндэсний төв”, Зам, тээврийн хөгжлийн яамны харьяа байгууллага өгдөг байсан.

Тэр үед “Си” зөвшөөрлийн хулгай гэдэг асуудлыг 1, 2 сая төгрөг гэж ярьдаг.

Уг нь 100 мянган төгрөг. 99 мянга билүү, хэд билээ. Тийм. 100 мянган төгрөгийн үнэтэй зөвшөөрөл 90 хоногийн хугацаатай олгодог байсан.

Энэ зөвшөөрлийг бид Хятад Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хооронд хэлэлцээрээр хоёр яам нь заавал өгөх ёстой гэдэг. Үүнийгээ бид авлигал өгөөд байна гэдэг асуудлаас болоод үндсэндээ Боомтын хөгжлийн газар. Тийм ээ. Нөгөө Боомтын захиргаа руу шилжүүлсэн.

Боомтын захиргаа нь өгдөг болсон. “Бөмбөлөг тээвэр” болсон. “Бөмбөлөг тээвэр” бас бөөн авлигал болсон.

Дараа нь, үндсэндээ энэ “Авто тээврийн үндэсний төв” өгч чадахгүй байна. Урьд нь 1, 2 саяын үнэтэй авлигал яригдаад байдаг байсан учраас “Авто тээврийн үндэсний төв” өгөхгүй ээ. Уурхайд нь өгье гээд уурхайд өгөх шийдвэр гарсан.

Уурхайд очсон чинь нөгөө “Си” зөвшөөрөл чинь 10-аас 20 сая төгрөгийн үнэтэй болсон байна лээ. Ийм болчихсон байгаа.

Маш их жолооч нар гомдол гаргаж байна. Ганцхан Гашуунсухайтын боомт дээр “Си” зөвшөөрлийн авлигал яригддаг байсан. Урьд нь. Одоо бол бүх боомт дээр. Бичигтнээс авхуулаад тийм үү,

Шивээхүрэн, Ховдын Хөшөөт хүртэл бүх боомтууд дээр асуудал яригдаж байна.

Энэ рүү бид шалгалт оруулна. Оруулна. “Авто тээврийн үндэсний төв”-өөс хангалттай “Си” зөвшөөрөл өгөөд байхад уурхайнууд “Си” зөвшөөрлийнхөө нийлүүлэлт, өгөх тоогоо хязгаарлаж байгаад, зориуд зохиомлоор хомсдол бий болгож байгаад үнэ өсгөж дамлаж байна.

Энэ мэдээлэл байнга ирж байгаа. Ингэж болохгүй. Ерөөсөө манай яамны барьж байгаа бодлого нээлттэй байх ёстой. Бүгдэд тэгш боломж өгөх ёстой. Нийлүүлэлтийг аль болох нэмэгдүүлье. Ийм л бодлого барьж байгаа.

Нийлүүлэлт нэмэгдээд байвал үнэ хямдардаг, үйлчилгээ сайжирдаг. Өрсөлдөөнийг дэмжих ёстой бид нар.

Гэтэл өнөөдөр уурхайнууд маань яагаад тэгээд ойлгохгүй байгаа юм. “Авто тээврийн үндэсний төв”-өөс “Си” зөвшөөрөл бүгдийг нь өгчих юм бол ийм “Си” зөвшөөрлийн хомсдол бий болохгүй.

Гэтэл зориудаар хомсдуулж байгаад үнэ өсгөж иймэрхүү байдал үүсэж байгаа юм.

Замын-Үүд дээр ч гэсэн ялгаа байхгүй. Замын-Үүдийн автобус тээвэр дээр ганцхан компани явдаг байсан. “Дэлгэрэх Тех” гэж компани. Тэрийгээ олон компани болгоё. Иргэдэд илүү үйлчилье гээд 2 компани оруулсан. 4 компани болгосон.

Гэтэл миний монопол, миний давуу байдлыг алга болгочихлоо гээд хорсоод л хэвлэл мэдээллийн хэрэгслээр нөгөө Драгоныхонтой адилхан ингээд л

гүтгээд л, гутаагаад л явж байгаа. Гүтгээд гутаагаад.

Гэтэл манай яамныхан яасан. Ерөөсөө л том компаниуд, монопол компаниудад боломж олгох, маш том борлуулалтын орлоготой байх ёстой, маш олон автобустай байх ёстой, олон жилийн түүхтэй байх ёстой гээд ийм стандарт журам баталчихсан.

Тэгээд л энэ стандарт, журам хангахгүй байна шүү дээ. Тийм болохоор жижиг компаниудыг Замын-Үүдийн жирийн иргэдийг оруулахгүй. Ийм одоо юу гэдэг юм, бусдад давуу тал олгосон ийм журмууд байж байгаа.

Үүнийг би өөрчилж байгаа. Бүгдийг нь. Ийм байдал байх ёсгүй. Байх ёсгүй.

“Си” зөвшөөрлийг ч гэсэн би шалгалт оруулна. Ингээд хангалттай өгнө. Өгсөн хэмжээгээр нь чөлөөтэй байх ёстой. Тэгж байж тэр “Си” зөвшөөрлийн урьд нь 1, 2 сая төгрөг “Авто тээврийн үндэсний төв” дээр байхдаа яригддаг байсан “Си” зөвшөөрлийн авлигал одоо 10, 20 сая болчихсон нь буурна.

Хятадтай бид хангалттай нэмчихсэн. 90 хоногийг бид 120 хоног болгож байгаа. Бас.

Ийм байдлаар үндсэндээ нийлүүлэлтийг нэмэгдүүлнэ. Бүгдэд тэгш боломж олгоно. Чөлөөт өрсөлдөөнийг дэмжинэ. Ингэж байж үнэ хямдарна.

Ийм бодлогын үр дүн ч гэсэн гарч байгаа. Одоо агаарын тээвэр дээр гарч байна.

Замын-Үүд дээр ч гэсэн бас ачаа тээвэр тийм байсан шүү дээ. Эрээнээс Улаанбаатар хүртэл 25 мянган юаниар

явдаг байсан. Хангалттай чөлөөтэй явдаг болсон. Одоо өнөөдөр Эрээнээс Улаанбаатар хүртэл 3 мянган юаниар ачиж байна. 8 дахин буурсан. Ачаа тээврийн тариф.

Тийм болохоор нийлүүлэлтийг дэмжинэ. Өрсөлдөөнийг дэмжинэ. Бүгдэд тэгш боломж олгоно гэсэн бодлогыг бид барьж байгаа гэдгийг бас хэлье.

С.Одонтуяа: Б.Пүрэвдорж гишүүн тодруулъя.

Б.Пүрэвдорж: Тээврийн сайд тээвэрчдэдээ, тээврийнхээ компаниудад ижилхэн хандах ёстой.

Дахиад бас нэг факт ярья. “Энержи ресурс” компанийн машинууд Тавантолгойгоос нүүрс ачаад Цагаанхадан дээр буулгадаг. Цагаанхаднаасаа Ганцмод руу ачдаг.

Гэтэл жирийн компаниуд Тавантолгойгоос Цагаанхад руу буулгадаг.

Гэтэл энэ хоёрын хооронд НӨАТ төлж байна.

Гэтэл нөгөө “Энержи” компани НӨАТ төлөхгүй байна. Энэ бол таны хэлээд байгаа тэр ялгаварлал мөн.

Өөрөөр хэлбэл нүүрс экспорт руу чиглэсэн ачилт учраас Энержийнхэн хуулийн заалтаа олж байгаад шийдлээ гаргасан байх.

Тийм учраас бусад компаниудыг адилхан болгох талаар тэр тээвэрчдээ бодоод юутайгаа ярих хэрэгтэй.../минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? С.Бямбацогт сайд уу? С.Бямбацогт сайд.

С.Бямбацогт: Ер нь тээвэрчдийн эрх ашгийг хамгаалах нь манай Зам, тээврийн яамны үндсэн нэг чиг үүрэг. Тийм.

Энэ салбарынхаа ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдэх, ажиллах нөхцөл бололцоог нь бүрдүүлэх. Энэ ч үүднээсээ Зам, тээврийн сайд болчхоод би Гашуунсухайтын боомт дээр очиж ажилласан. Анх удаагаа очиж үзсэн.

Үнэхээр тэнд тээвэрчид тог байхгүй, ус байхгүй, сургууль байхгүй, цэцэрлэг байхгүй, 20-иод мянган жолооч ерөөсөө **“хээрээр гэр хийж, хэцээр дэр хийсэн”** тийм нөхдүүд байсан.

Одоо ямар ч байсан нэг тогтой, устай болсон, сургууль, цэцэрлэгтэй болсон, эмнэлэгтэй болсон. Эмнэлэг бас байхгүй.

Цаашдаа бид энэ тээвэрчдийн асуудал. Гаднын компанийнхан илүү давуу эрхтэй байдаг. Дахиад дотроо юу гэдэг юм, хувийн компани, одоо өөрийн чинь хэлж байгаа “Энержи Ресурс” компани илүү давуу эрхтэй байдаг ч юм уу, иймэрхүү ялгавар бол байх ёсгүй ээ.

Энэ дээр үндсэндээ бид оролцоо их багатай болчхоод байгаа юм. Яагаад гэвэл “Си” зөвшөөрлийг уурхайнууд өгдөг болсон. “Си” зөвшөөрөл уурхай өгч байгаатай холбоотойгоор тээврийн гэрээг үндсэндээ уурхайнууд хийж байгаа.

Манай яамны оролцоо, “Авто тээврийн үндэсний төв”-ийн оролцоо тун бага болсон.

С.Одонтуяа: Одоо Дашдондогийн Ганбат гишүүн асуулт асууж, үг хэлнэ.

Д.Ганбат: Манай дэд бүтцийн асуудал аягүй чухал л даа.

Тэр тусмаа манайх хоёрхон том орны дунд байж байгаа. Тэгээд далайд гарцгүй орны хувьд төмөр зам, агаарын тээвэр, авто тээврийн энэ асуудал маш чухал байгаа юм.

Энэ дээр нөгөө ямар сэргэлтийн бодлого нь билээ? “Шинэ сэргэлт”. “Автын сэргэлт” юм уу, ямар сэргэлт юм танай дээр. Аан..., “Зам, тээврийн сэргэлт”.

Төмөр зам дээр бол би нэг их сэргэлт мэргэлт яваад байна гэж бодохгүй байна.

Ер нь бидний баримталж байгаа бодлого эхлээд зөв үү, буруу юу гэдэг талаар ганц хоёр үг сонсчихмоор байгаа юм. Бас салбарын сайд, бас салбарын яам маань энэ талаар юу бодож байгаа юм бэ?

Бараг дэлхий эдийн засгийн эхний нэг, хоёр дахь эдийн засаг нь бид нарын урд талд байж байна шүү дээ.

Тэгээд сүүлийн 10 жил бид үүнийгээ ашиглаж чадсангүй. Тэр нь юутай холбоотой вэ гэвэл ерөөсөө л зам тээвэртэй л холбоотой. Энэ бодлого нь зөв байна уу, буруу байна уу? Сайд аа.

Нөгөө олон улсын шаардлага хангасан тэр нарийн төмөр замаа хэзээ барих юм бэ? Холбогдох юм бэ?

Заавал тээвэр хийгээд хоорондоо зорчих юм бол өргөн, нарийн байлгаж яах гээд байгаа юм бэ? Тэгээд л бид нарын өрсөлдөх чадвар чинь унаж байна шүү дээ. Энэ дээр юу бодож байна?

Нөгөө талаар далайд хүрэх боломж энэ тэрийг нөгөө Хятад Улсын

дарга ирээд айлчлахдаа баахан гэрээ байгуулаад явлаа гэсэн. Тяньжинь боомт дээр газар авлаа л гэсэн. Тэр чинь юу болсон бэ?

Нөгөө талаар манай энэ төмөр зам. Нэг нь, “Улаанбаатар төмөр зам”-ыг би бас онцгойлон ярих гэж байна. 50, 50 хувьтай. Үүнийгээ ядаж 51-тэй болгочхож болдоггүй юм уу?

Зөвлөлтийг дагаж байсан улс орнууд бүгд төмөр замаа авчихсан. Манайх авч чадаагүй хоцорсон. 50 хувиа.

Одоо хамгийн хоцрогдсон зам бол энэ болчхоод байна шүү дээ. Хоёр салаа замтай баймаар байна. Хос замтай. Нөгөө цахилгаанд нь оруулмаар байна. Энэ чинь одоо яг 100 жилийнх тэр чигээрээ.

Цаг хугацаа, тээврийн хүчин чадал энэ тэр гээд энэ юм чинь байхгүй. Үүнийгээ яаж шийдээд байгаа юм, ямар байгаа юм бэ гэхчлэнгийн ийм асуултууд байна.

Ингээд яриад байвал дуусахгүй л дээ.

Нөгөө барьчихсан гээд байгаа тэр хөндлөн замууд чинь ашиглагдаж байгаа юм уу? Тэр мухар төмөр зам байгаа. Тэр чинь юу болж байна вэ? Нөгөө Гашуунсухайтын. Тэр үнэтэй юу, хямдхан хийгдсэн үү?

Тийм үнэтэй, тийм их хөрөнгө оруулалт хийчхээд хэдэн жил яг дүүртэл ашиглаж чадахгүй байна вэ? Үүнийг тодруулаад өгчхөөрэй.

Нөгөө талаар би Баянхонгортой холбоотой хоёр, гурван юм асуугаадахъя.

Тэр онгоц хоорондоо нисгээд байна гэсэн. Эхлээд нисээд байсан. Одоо

байхгүй. Хэзээ нисэх юм? Одоо сонгууль ойртоод нисэхгүй.

Тэр “**Эрдэнэ Монгол**” гээд компани байна. Сая манай Баянлиг, Баянговийн малчдаас надад шаардлага ирсэн. Тэр говийн эмзэг эко системийг устгаж “**Эрдэнэ Монгол**” компани тээвэрлэлт хийсэн.

Тэд нарыг тэр замыг нь тавиулаад тээвэрлэлт хийлгэж болохгүй юу. Энэ дээр малчдын эрх ашиг маш их зөрчигдөж байна. Энэ дээр та нар ямар арга хэмжээ авах вэ?

Одоо тэр чинь ашиглалтад ороогүй юм байгаа юм чинь ашиглалтад орохоороо бүр цаашаа юу болох вэ гэсэн ийм асуудлууд байна.

С.Одонтуяа: С.Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын бичиг баримтад 2010 онд Монгол Улсын Их Хурал баталсан.

Эндээс гадагшаа чиглэсэн төмөр замын царигийг тухайн үед нь Улсын Их Хурал шийднэ гээд баталчихсан.

2014 онд Гашуунсухайтын төмөр замыг нарийн царигаар барихаар ийм шийдвэр Улсын Их Хурлаас гаргасан боловч 2020 онд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтээр хууль зөрчсөн байна, Үндсэн хууль зөрчсөн байна гээд бүр шийдвэр гаргаад үндсэндээ тэр хүчингүй болчихсон.

Ийм учраас төмөр замаа хурдан барихын тулд өргөн царигтай барьсан. Цаашдаа баригдаж байгаа төмөр зам нэгэнтээ ийм болж байгаа юм чинь гээд үндсэндээ өргөн царигаар баригдаад

Зүүнбаянгаас Хангийн төмөр зам өргөн баригдлаа. Мөн Гашуунсухайтаас Ганцмодны төмөр зам өргөн баригдчихсан байгаа.

Энэ уг нь нарийн барих бололцоотой байсан. Уг нь нарийн барьсан бол заавал хил холболтын төмөр зам өргөн, нарийн гээд байх шаардлагагүй болох байсан.

Гэтэл нэгэнт барьчихсан учраас одоо хил холболтын төмөр зам гээд өргөн, нарийн царигийн терминал байгуулах ийм шаардлагатай болж байгаа.

Баруун босоо төмөр зам буюу Арцсуурь, Нарийн сухайт, Шивээхүрэн. Энэ бол Орос, Хятадыг холбосон. Үндсэндээ транзит тээвэр их явна. Монголын дотоодын тээвэр явна. Ийм төмөр зам.

Мөн зүүн босоо төмөр зам, Эрэнцав, Чойбалсан, Хөөт, Бичигт. Энэ бас Орос, Хятад, Ази, Европыг холбосон төмөр зам.

Энэ төмөр замууд үндсэндээ Оросын төмөр замтай холбогдож байгаа учраас өргөн царигаараа баригдаад Хятадын хил дээр бас өргөн, нарийн хил холболтын төмөр замууд баригдаж, ингэж хийгдэхээр техник, эдийн засгийн үндэслэл хийгдэж байгаа.

Зүүн босоо, баруун босоо дээр үндсэндээ концессын компаниуд нь шалгарсан. Зүүн босоо дээр “East Corridor Railroad” гэж компани. Баруун босоо дээр “Essen Supply” гэж компаниуд концессын гэрээ байгуулахаар ажиллаж байгаа.

Далайд хүрэх боломжийн талаар та ярилаа. Маш чухал асуудал.

Монгол Улс өнөөдөр ганцхан төмөр замтай байж байгаад 3 төмөр замтай болох гэж байгаа. Ганцхан Ази, Европыг холбосон 2-хон авто замтай байж байгаад 5 авто замтай болох гэж байгаатай адил бид бас олон далайн боомттой болъё гэж байгаа.

Одоо ганцхан Тяньжинь гэсэн ганцхан боомтоор далайтай харьцаж байна. Импортоо авч байгаа. Энэ нийт импортын 80 хувь нь Тяньжинь боомтоор ирж байгаа.

Тэгвэл энэ Тяньжинь боомтоор ирж байгаа ачаа маш их удаан хугацаанд хүлээгдэж байгаа. Өндөр тарифтай байна.

Европоос Тяньжинь боомт иртэл 700 доллар. 1 контейнер. Тяньжинь боомт дээр 300 долларын хураамж төлдөг. Тяньжинээс Эрэн хүртэл 2000 доллар. Эрэнээс Улаанбаатар хүртэл 2000 доллар.

Ганцхан гарцтай байгаа учраас ийм байгаа.

Тийм болохоор бид өнөөдөр Ляонинь мужийн Жиньжоу /Jinzhou/ боомтоор хоёр дахь далайд гарах гарцтай болох. Мөн бас Инкоу /Yingkou/ гэсэн боомт. Ийм 3 боомтоор гарцтай болж үндсэндээ гаднаас ирж байгаа импортын ачаа барааныхаа үнийг бууруулах бодлого барьж ажиллаж байгаа.

Аль болох олон гарцаар гарч байж хурдан хугацаанд хямд зардлаар Монгол Улсад ирж байгаа импортоо авчирна. Мөн экспорт хийх бололцоо, боломж бүрдэнэ. Энэ ажлыг ойрын үед бодитой үр дүн болгохоор ажиллаж байгаа.

“Улаанбаатар төмөр зам”-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх, “Богд хаан

төмөр зам”-ыг эхний ээлжид барих энэ ажил эхэлсэн явж байсан.

“Улаанбаатар төмөр зам” Оросууд 50 хувийг нь эзэмшдэг. Гэтэл Оросын талтай бас ярьж хэлцэлгүйгээр эхлүүлсэн. “Улаанбаатар төмөр зам”-ын гол төмөр замаас салаалж эхлээд буцаад “Улаанбаатар төмөр зам”-ын гол төмөр зам руу буцаж нийлэх ийм төмөр замыг бид хамтрагч Оросын талтайгаа ярилцах ёстой.

Техник, эдийн засгийн үндэслэл бол хийсэн байгаа.

Ингээд “Улаанбаатар төмөр зам”-ын “Богд хаан төмөр зам”-ууд баригдана.

Цаашдаа бид үе шаттайгаар “Улаанбаатар төмөр зам”-ын хүчин чадлыг нэмэгдүүлэх бодлого барьж байгаа. Үнэхээр эдийн засгийн чадавх нь тийм сайн биш байх шиг байна. Сайн биш байгаа.

Өөрөөр хэлэх юм бол тарифыг бид барьчихдаг. “Улаанбаатар төмөр зам”-ын тээврийн тарифыг нэмээд байх юм бол тэр хэмжээгээрээ төмөр замаа шинэчлэх, вагоноо шинэчлэх, зүтгүүрээ шинэчлэх бололцоо боломж бүрдэнэ.

Гэтэл төмөр замын тариф нэмэгдэхэд нөгөө талд нь эрчим хүчний үнэ нэмэгдэх гээд байдаг, нефть бүтээгдэхүүний нэмэгдэх гээд байдаг, хүнсний бүтээгдэхүүн нэмэгдэх гээд байдаг.

Тийм учраас үнэ тарифыг хангалттай хэмжээгээр нэмж чадахгүй. Нийгмийн ачаа үүрч байгаа учраас. Ийм зовлон байгаа гэдгийг танд бас хэлье.

С.Одонтуяа: Зочид танилцуулъя.

Улсын Их Хурлын гишүүн Борхүүгийн Дэлгэрсайхан, Төмөртогоогийн Энхтүвшин нарын урилгаар **“ШИНЭ СЭРГЭЛТ-МАЛ АЖ АХУЙ”** Үндэсний чуулганд Дорноговь аймгаас оролцож буй залуу малчид Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцаж байна.

Өнөөдөр Баасан гарагийн үдээс хойш Ерөнхий сайдын мэдээллийн цагаар зөвхөн цөөнх асуултаа асуудаг.

Олонхын гишүүд асуух боломжгүй учраас олонхын гишүүд оролцоогүй байна. Манай цөөнхийн гишүүд бүгд асуултаа асуугаад ирсэн байна.

Улсын Их Хурлынхаа чуулганы дэгийг танилцуулж байгаа.

Тэгээд Та бүхэнд ажлын амжилт хүсье. Сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Манай Т.Энхтүвшин гишүүн идэвхтэй байгаа учраас хуралдаа сууж байна. Хэдийгээр олонхын төлөөлөл асуухгүй ч гэсэн.

Одоо 94 зүгээр микрофон. Б.Мөнхтамир захирал хариулах юм уу? Тийм ээ.

Б.Мөнхтамир: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе.

Д.Ганбат гишүүний асуултад хариулъя.

Түрүүн асуултад яригдаж байсан. Монгол Улсын Засгийн газраас гарсан шийдвэрийн дагуу 2023 оны 7 сарын 01-нээс “МИАТ” компани орон нутгийн нислэгийг сэргээхдээ 9 аймаг буюу

Баянхонгор аймаг руу нислэг сэргээх үндсэн чиглэлтэй байсан.

Нислэг эхлэхийн өмнө нийт 9 аймгийн нислэгийн аюулгүй ажиллагааг хангах үүднээс нислэгийн зурвас дээр аудит шалгалтуудыг хийсэн боловч Баянхонгор аймгийн нисэх буудлын зурвасын стандарт шаардлага нь тухайн **CRJ200** төрлийн агаарын хөлгийг хүлээж авах боломжгүй байсан.

Энэ боломжгүй гарсан дүгнэлтийн дагуу Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын харьяа Нисэх Буудлуудын Удирдах Газар бид тухайн дүгнэлтийг өгөөд 2024 оны үндсэн төсөв дээр зурвасын ажлуудыг хийгдсэний дараагаар Баянхонгор аймгийн нислэгийг сэргээх үйл ажиллагааг оруулья гээд түр хойш нь тавьсан байгаа.

Нисэх Буудлуудын Удирдах Газар дээрээс тендерүүд нь зарлагдсан явж байгаа юм билээ. Энэ зарлагдаад, ажлууд нь хийгдээд нисэх буудлын зурвасын өргөн жишээ нь 50 метр байх ёстой байхад 50 метртээ хүрэхгүй байгаа.

Ерөнхийдөө нислэгийн аюулгүй ажиллагааны зайлшгүй шаардлагыг хангаж явахгүй бол хөдөлгүүр лүү явуулах хөөрөх, буух тохиолдолд шороо, чулуу үсэрч орох магадлалууд байдаг учраас бид энэ нислэгийн зурвасын өргөн тал дээр явгалах зурвасуудын аюулгүй ажиллагааг хангуулах үүднээс энэ шаардлагуудыг нь тавиад түр хойшлуулсан байгаа.

С.Одонтуяа: Нэмж хэн хариулах юм? 83. Д.Эрдэнэбат зөвлөх хариулах юм байна.

Д.Эрдэнэбат: Зам, тээврийн хөгжлийн сайдын зөвлөх Эрдэнэбат. Д.Ганбат гишүүний асуултад хариулья.

Баянхонгорын нисэх буудлын хөөрч, буух хатуу хучилттай зурвас дээр засвар хийх заавал шаардлагатай байгаа. Нийтдээ 8 мянга орчим метр квадрат засварын ажил хийгдэх ёстой.

Иргэний Нисэхийн Ерөнхий Газраас тендер нь зарлагдаад сая нээсэн. 4 компани шалгарсан байна лээ.

Тэгээд хэрвээ холбогдох ажлууд хийгдээд бэлэн болбол ирэх оны нэгдүгээр улиралд багтаагаад Баянхонгор аймгийн нислэг эхлэхэд бэлэн болно.

С.Одонтуяа: Д.Эрдэнэбат зөвлөх нэмээд хариулчих. Дараа нь С.Батболд дарга.

Д.Эрдэнэбат: Энэ “Эрдэнэ Монгол” гэж компани би андуураагүй бол Шинэжинст сумд байх. Тийм ээ. Баяжуулах үйлдвэр бариад энэ Баянговь, Баянлиг сумын нутгаар дайруулж уурхайн тоног төхөөрөмж тээвэрлэсэн асуудал гарсан юм билээ. Энэ дээр манай яаманд бас тодорхой хэмжээний гомдлууд ирсэн.

Тэгээд бид судалж үзсэн. Энэ аймгийн Засаг дарга болон сумын удирдлагуудаас нь орон нутгийн тээвэр хийх зөвшөөрлөө авсан юм билээ. Тэр компани нь.

Уг зам нь улс, олон улсын чанартай биш учраас манай яам биш орон нутгийн удирдлага зөвшөөрөл өгч явдаг зам байна лээ. Тэгээд бид энэ талаар нь хэлсэн.

Тэгээд тухайн компанийг иргэдтэйгээ ойлголц гэдэг ийм чиглэл өгсөн байгаа.

С.Одонтуяа: С.Батболд дарга нэмж хариулах юм уу? Болчихсон уу?

Д.Ганбат гишүүн тодруулъя.

Д.Ганбат: Тэр уул уурхай манай Баянхонгор аймагт тэр “**Эрдэнэ Монгол**” энэ тэр яваад эхэлбэл тэр замыг нь тавиулж байж эхлүүлэх ёстой шүү гэдэг дээр би анхааруулчихъя.

Тэгэхгүй бол тэнд чинь маш их эмзэг говийн эко систем байж байгаа. Энэ дээр анхаарах ёстой.

Нөгөө талаар Зам, тээврийн яам маань хаанахаа дэмжээд байна аа? Энэ хэдэн жолооч нар маань Гашуунсухайт, манай Баянхонгорын жолооч нар ч тэнд очиж байгаа л даа. Компаниуд ч ажиллаж байгаа.

Тэр хэд маань тээвэр хийж чадахаа байчихлаа л гээд байх юм. Уг нь тав, арван төгрөг олдог байсан юм. Тэндээс. Энэ Хятадын компаниуд л тээвэр хийгээд л, мөнгө төгрөг олоод л. Тэр чиг рүү л явчихлаа гээд байх юм.

Ер нь энэ дээр ямар бодлого бариад байгаа юм бэ? Уг нь манай жолооч нар, манай компаниуд тээврийг нь хийж ажилтай байвал энэ монгол хүн орлоготой, өөрийнхөө нутаг дэвсгэр дээр тэр тээврээ хийчихвэл.../минут дуусав/

С.Одонтуяа: С.Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Тантай санал нэг байна.

Өнөөдөр Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын зардал болгон нь уг нь Монголчуудын орлого байгаасай.

Ялангуяа тэр Тавантолгой чиглэлд үйл ажиллагаа явуулж байгаа тээвэрчид илүү их тээвэр хийгээсэй. Монгол тээвэрчид нь гэдэг бодлогыг бид барьдаг.

Би жишээ нь Ховдын Хөшөөт дээр ерөөсөө Ховдын жолооч нар явах ёстой. Өөр Хятадын болон гаднын компанийн юм явах ёсгүй гэж ийм бодлого барьж байж өнөөдөр Ховдын Хөшөөтийн уурхай дээр зөвхөн Ховдын тээвэрчид л тээвэр хийдэг.

Үүнтэй адилхан уг нь энэ Тавантолгойн тээвэр дээр монгол тээвэрчид маань тээвэр хийж байвал зөв байгаа юм.

Харамсалтай нь тээврийн үйл ажиллагаанд “Авто тээврийн үндэсний төв” болон Зам, тээврийн хөгжлийн яам энэ тээвэр зохицуулалтад оролцохгүй болчихоод байгаа юм.

Уурхайнууд өөрсдөө тээврийн компаниудтай гэрээ хийж байна. Уурхайнууд “Си” зөвшөөрлөө аваад өөрсдөө хэндээ өгөхөө өөрсдөө үзэмжээр шийдэж байна.

С.Одонтуяа: С.Бямбацогт сайд гүйцээж хариулъя.

С.Бямбацогт: Үүний цаад талд нь уурхайнуудын тээвэр зохицуулалт, тээврийн гэрээ хийж байгаа, дээрээс нь тэр “Си” зөвшөөрөл олгож байгаа энэ байдал дээр монгол тээвэрчдээс маш их гомдол ирж байгаа.

Өчигдөр билүү, уржигдар манай яаман дээр хүртэл ирж өргөх бичиг бидэнд барьсан. Шаардлага ирүүлсэн. Энэ дээр бид онцгой анхаарч ажиллана. Ажиллана. Анхаарах ёстой. Бидний үүрэг. Энэ тээвэрчдийн эрх ашгийг

хамгаалах нь бидний үүрэг. Манай Зам, тээврийн хөгжлийн яамны.

Тийм учраас шалгалт оруулна. Яагаад өнөөдөр Монгол тээвэрчид нь дутуу эрхтэй, гаднын бусад тээвэрчид нь давуу эрхтэй байгаад байна. Яагаад цөөхөн компаниудад “Си” зөвшөөрөл олгодог, яагаад өдөр болгон тээвэр хийдэг, яагаад Монгол жолооч нар 10 хоногтоо нэг удаа тээвэр хийдэг ийм байгаад байна. Ийм ялгаварлал байж болохгүй.

Ийм үүднээс бид үндсэндээ тээвэрчдийнхээ эрх ашгийг хамгаалах үүднээс шалгалт оруулна. Бүгдийг ил тод болгоно. Бүгдэд тэгш боломжийг бий болгохын төлөө ажиллана. Үүнийг танд хэлчихье.

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай

Хуралдаан 4 цаг 33 минут үргэлжилж, 15 цаг 32 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ**

хуулийн 109 дүгээр зүйлийн 109.11 дэх хэсэгт Ерөнхий сайдын мэдээллийн сэдвийг Улсын Их Хурлын цахим хуудсанд байршуулж, иргэдээс асуулт авч нэгтгэн намын бүлгүүдэд хүргүүлснээр Улсын Их Хурал дахь намын бүлгүүд өөрсдийн төлөөлсөн Улсын Их Хурлын гишүүнийг томилж, иргэдээс ирүүлсэн асуултуудыг өгөгдсөн хугацаанд багтан Ерөнхий сайд болон Засгийн газрын гишүүнээс асуухаар зохицуулж өгсөн.

Энэ удаагийн Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан D-Parliament.mn цахим системд иргэдээс асуулт ирээгүй байна.

Тийм учраас үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайдын мэдээллийг сонсож дууслаа. /алх цохив/

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

Ц.АЛТАН-ОД